ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ
ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ 2015. № 2 (52)

## ГАРЧИГ

**КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Гэр бүл дэх хүчирхийлэл нуугдмал гэмт явдал болох нь
Т.Мөнхдалай
2. Монгол Улсад үйлдэгдэж буй халаасны хулгайн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ
Б.Мөнхзул
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал
Г.Ганбаатар

**ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбар, мөн чанар, түүний хууль зүйн учир холбогдол
Г.Гантөмөр

**ЭРХ БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Нотлох ажиллагааны үе шатны зарим асуудал
Я.Цэлмэн
2. Монгол Улс болон ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа (харьцуулсан судалгаа)
Г.Жалбуу

**КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Гэмт хэрэг илрүүлэхэд бичил мөрний шинжилгээ, физик-химийн спектр анализын аргууд
Х.Түвшин-Эрдэнэ

**ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Цагдаагийн албан хаагчийн ажиллах нөхцлийн аюулгүй байдал, түүнийг хангахад анхаарах асуудал
З.Дашдаваа
2. Орон нутгийн цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудал
Б.Баянмөнх
3. Иргэний зөвлөлийн чиг үүрэг ба онол практик
С.Эрдэнэболор
4. Хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах үндэслэл, журам, түүнийг боловсронгуй болгох асуудал
Ш.Чулуун

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН**

1. Современные проблемы обеспечения пенитенциарной безопасности
Пантелеев Виктор Александрович

**ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

1. Төрийн албан хаагчдад оногдуулах хариуцлага: 1921-1990 оны үеийн хууль цаазын хүрээнд авч үзэх нь
Н.Мөнхзул

**ХАВСРАЛТ**

1. Цахим гэмт хэрэг гэж юу вэ?
С.Алимаа
2. Монгол Улсад бүртгэгдэж буй гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин өндөр зарим гэмт хэргийг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байдал, харьцуулсан судалгаа
С.Гантулга

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ
Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД
Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Н.ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ДОКТОРАНТ

ЭРХЛЭН ГАРГАСАН:
С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.МӨНХЗУЛ
МАГИСТР

## КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



# ГЭР БҮЛДЭХ ХҮЧИРХИЙЛЭЛ НУУГДМАЛ ГЭМТ ЯВДАЛ БОЛОХ НЬ

*Т.Мөнхдалай*
*Отгонтэнгэр их сургуулийн ахлах багш, докторант*

Гэмт явдал нь нийгмийн болон эрх зүйн сөрөг үзэгдэл, үйл явцын нэг хэсэг бөгөөд манай улсад сүүлийн жилүүдэд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрч улмаар гэр бүлийн орчин, түүний хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсөх хандлагатайбайгаа нь олон нийтийг бухимдуулж мөн айдас түгшүүрт оруулж байна.

Гэр бүл бол гэр бүлийн нийт гишүүдийн аз жаргал, ирээдүй, эв нэгдлийн илэрхийлэл бөгөөд амар амгалангийн эхлэл болж, ёс заншил, уламжлал, танин мэдэхүйн мэдлэг, боловсрол олгож байдаг бичил, таатай орчин билээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэн гарч буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал нь данганц гэр бүлийн хүрээнд бус нийгэм, хамт олон, төр засгийн хэмжээнд авч үзэх өргөн цар хүрээтэй асуудал юм.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хохирогчид нь голдуу хүүхэд эмэгтэйчүүд, өндөр настан, хэвтрийн, хүнд өвчтэй , хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг бөгөөд зарим тохиолдолд эрэгтэйчүүд ч хохирогч болдог байна.

Цагдаагийн байгууллага болон Хүний эрхийн үндэсний комиссоос хийсэн судалгаагаар 2014 онд 2270 гаруй эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөөс 300 гаруй охид бүсгүйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртөж 2009 оноос хойш 71 эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн улмаас нас барж, 2395 хүн гэмтэж бэртсэн[1] тоо баримт нь зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн тухайд яригдаж буй асуудал бөгөөд бүртгэгдээгүй гэмт хэргийн ард хичнээн хүн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болж хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдөж буйг нарийн тодорхойлох, тооцох боломжгүй юм.

Илэрч бүртгэгдсэн нэг гэмт хэргийн цаана нуугдмал, бүртгэгдээгүй хэрэг, үйлдэл наад зах нь 5-10 гэсэн харьцаатай байдаг байна.

2014 онд гэрбүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1076 бүртгэгдсэн нь 2013 оны мөн үетэй харьцуулахад 418 гэмт хэргээр буюу 1.6 дахин өсөн нэмэгдсэн тоо баримт[2] дээр хуулийн зохих байгууллагад хандаагүй, бүртгэгдээгүй хэргүүд буюу "нуугдмал гэмт явдлыг" тоог тооцоолон гаргаж нэмэхэд гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн бодит тоо хэд дахин өссөн үзүүлэлт гарах болно.

**Latent crime** буюу нуугдмал гэмт явдал[3] нь хууль сахиулах байгууллагад албан ёсоор бүртгэгдээгүй боловч бодитойгоор үйлдэгдсэн гэмт хэргийг илэрхийлсэн ойлголт юм.

Нийгэмд буй болсон объектив болон субъектив хүчин зүйлсийн нөлөөгөөр гэмт явдал бүртгэгдэхгүй өнгөрөх явдал гардаг бөгөөдобъектив хүчин зүйлсийн нөлөөлөлдхуульэрх зүйн хийдэл болон хууль тогтоомжийн боловсронгуй бус байдлаас хамаарч тухайн этгээдийн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй болсон, хуулиар гэмт хэрэг гэж тооцсон үйлдлийг хийсэн боловч хууль сахиулах байгууллагын албан тушаалтны мэргэжлийн алдаа дутагдалзэргээс хамаарч тоо бүртгэлд бүртгэгдээгүй байдаг бол субъектив хүчин зүйлсийн нөлөөлөлд хууль сахиулах байгууллага, тэдгээрийн алба хаагчдын "санаатай" буюу "санамсаргүйгээр" бүртгээгүй нуун дарагдуулсан, мөн түүнчлэн гэр бүлийн гишүүдийн хүсэл зоригоос хамаарч гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийг нуун дарагдуулах гэсэн зорилго агуулагдаж байдаг байна.

Тухайн улсад үйлдэгдсэн нийт гэмт хэргийн тоон үзүүлэлт нь бүртгэгдсэн гэмт хэрэг, нуугдмал гэмт хэргийн нийлбэрээс бүрдэнэ. Иймд үйлдэгдэн гарсан гэмт хэргийн талаар үнэн, бодит мэдээлэлтэй байх нь тухайн гэмт хэргийг илрүүлэх, шалгаж, шийдвэрлэх болон урьдчилан сэргийлэх арга замыг зөв тодорхойлоход төдийгүй, хүч хэрэгслийг оновчтой зохион байгуулах, ашиглах цаашдын төлөв байдал, чиг хандлагыг боловсруулах, төлөвлөхөд чухал бөгөөд хууль сахиулах байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргээс гадна бүртгэгдээгүй, нуугдмал гэмт хэргийн талаар судлах нь онол практикийн хувьд ач холбогдолтой болно.

XIX зууны эхэн үед оросын

[1] ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. 2003-2014 оны гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ.УБ., 2015. 5 дахь тал
[2] ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. 2013-2014 оны гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ.УБ., 2015. 12 дахь тал
[3] Б.Батзориг, Г.Эрдэнэбат. "Криминологи". УБ.2013. 26 дах тал

эрдэмтэн А.Кетле нарын судлаачид өөрийн бүтээлдээ нуугдмал гэмт хэргийн талаар анх судлан тодорхойлохыг оролдож байсан бөгөөд А.Кетле нь "үйлдэгдсэн гэмт хэргийн зөвхөн тодорхой хэсэг л мэддэгддэг ба нуугдмал гэмт хэргийн эзлэх хувь нь олон дахин их хувь эзэлдэг[4]" гэж тодорхойлсон байдаг.

"Аливаа гэмт явдал олны нүднээс далд, нуугдмал байдалд байх чадвартай. Тэр бүхнийг ил гаргаж, тодорхой болгон бич. Эрт, орой хэзээ нэгэн цагт олон түмний үзэл бодлын хүчээр энэ булай явдал арилна" хэмээн АНУ-ын нэрт сэтгүүлч, хуульч Жозеф Пулитцер хэлдэг байжээ.

Манай улсад нуугдмал гэмт хэргийг тооцоолох аргачлал, арга зүй боловсруулагдаагүй байгаа нь криминологийн прогноз хийх боломжийг үгүйсгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнгүй байгаагийн гол шалтгаан нь энэ талаар чиглэсэн судалгаа хийгдээгүй,анхаарал хандуулахгүй байгаад оршиж байна[5].

Бүртгэгдсэн гэмт хэргээс нуугдмал гэмт хэргийн ялгагдах онцлог нь түүний далд нууц шинж нь бөгөөд өөрөөр хэлбэл нуугдмал гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинж, өгөгдэхүүнүүд төрийн тоо бүртгэлийн системд байдаггүй байдлаар илэрнэ[6].

Нуугдмал гэмт хэрэг нь гэмт хэрэг болохын хувьд нийгэмд аюултай үзэгдэл бөгөөд, эрүүгийн хариуцлага хүлээгээгүйн улмаас дахин давтагдах шинжтэй байдаг байна.

Мөн түүнчлэн гэмт хэргийг нуун дарагдуулах явдал нийгэм, гэр бүлийн гишүүдийн харилцаанд оршин, түүний өөрчлөлтийг даган хувьсан өөрчлөгдөж байдаг нь хамт олон, гэр бүлийн гишүүдээс нэг нь нөгөөгийнхөө хийсэн хэргийг нэг бус удаа уучлан өршөөсөн явдалтай холбоотой бөгөөд ихэнхи тохиолдолд эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж тооцсон хөнгөн, хүндэвтэр төрлийн гэмт хэргийг нуун дарагдуулдаг байна.

Гэр бүлийн орчин, хүрээлэлд үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн дийлэнхи хувийг бодитойгоор үйлдэгдсэн боловч цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүйгээр далд үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг эзэлдэг бөгөөд хүчирхийлэлд өртөж хохирсон иргэнээс зөрчигдсөн эрхээ сэргээж, хамгаалуулахын тулд хуулийн зохих байгууллагад хандаагүй энэ байдал нь тухайн гэмт хэргийг үйлдэгч этгээдийг улам өөгшүүлэн удаа дараа гэмт хэрэг үйлдэж, үйлдсэн хэрэгтээ хариуцлага хүлээхгүй ял завших нөхцөл болдог байна.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэнд учирсан бие махбодь, эд хөрөнгө, сэтгэл санааны хохирлын тоо хэмжээ нь удаа дараагийн халдлагын улмаас улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болдог ба эцсийн үр дүн нь зөөлрүүлж хэлбэл гэр бүл салалтаар, хатуухан хэлбэл хүчирхийлэл үйлдэгч болон түүнд өртөгч хэн нэгний эрүүл мэнд, амь насыг хохироосноор дуусдаг байна.

**Судалгаагаар өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөн үйлчилж байгаа Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгайлан заасан 225 гэмт хэргээс гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг 37, үйлдэгдэх боломжтой 14 гэмт хэрэг хуульчлагдсан байна.**

Энэ тоо нь хэдийгээр эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа, тэр дундаа хүний амь нас, эрүүл мэнд , эрх чөлөө ашиг сонирхлын дөрөвний нэг буюу 25.8 хувийг эзлэж байгаа хэдий ч гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй ахуйн шинжтэй гэмт явдал[7]-ын дотор хүч хэрэглэсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин нилээд их байгаа явдалд анхаарал хандуулж тэмцэх арга замыг зөв тодорхойлох нь чухал ач холбогдолтой болно.

Иймд гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийгсудлан тогтоож гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг зөв бөгөөд оновчтой тодорхойлон хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх шаардлагатай байна.

Гэрбүлийн хүрээнд хамаарагдах гэрлэсэн болон хамтран амьдрагч хүмүүс, тэдний төрөл садангийн хүн[8]-тэй холбоотой бүлэг хүмүүсийн хооронд үйлдэгдэнгарч буй хүч хэрэглэсэн гэмтхэргийг гэр бүл дэх хүчирхийлэлтэй холбон авч үзье.

ШШГЕГ-ын харьяа хорих 407-р ангид хийсэн хэсэгчилсэн судалгаагаар танай гэр бүлд хүчирхийлэл байдаг эсэх, хүчирхийлэл төрүүлэгч этгээд хэн болох гэсэн асуулганд оролцсон 41 эмэгтэй ялтанаас гэр бүлд хүчирхийлэл байдаг, байнга өртдөг гэж 10 буюу 24.3%, хааяа нэг хүчирхийлэлд өртдөг байсан гэж 9 буюу 21.9% нь хариулсан бөгөөд хүчирхийллийг төрүүлэгч нь нөхөр гэж 12 буюу 48%, хадам эцэг эх, төрөл төрөгсөд, хамаатан садан байдаг гэж 5 буюу 20% , найз нөхөд, хамт ажиллаж, сурдаг хүмүүсээс 8 буюу 32% нь хүчирхийлэл үйлддэг хэмээн 25 ялтан хариулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хэн нэгэн хүний ганц нэгэн удаагийн, санамсаргүй, тохиолдлын зан үйл бус тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй, бусдыг зовоон

[4] А.Кетле "Социальная физика, или опыт исследования о развитии человеческих способностей" Киев. 1911 г. 262 дах тал

[5] Д.Мягмарцэрэн. Нуугдмал гэмт хэрэг: ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал. //Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2014. №1. 18 дах тал

[6] Дурдсан бүтээл

[7] С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг" УБ. 2007 он. 49-р тал.

Ахуйн шинжтэй гэмт явдал- англи. domestic crime- «ахуйн хөрсөн" дээр үйлдэгдсэн, өөрөөр хэлбэл бие хүн- ахуйн ба нийгэм- ахуйн харилцаагаар хоорондоо холбогдсон этгээдүүдийн ашиг сонирхлын зөрчилдөөнөөс үүдсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнд нь ордог гэмт явдлын хэлбэр

[8] "Гэр бүлийн тухай" Монгол Улсын хуулинд төрлийн хүн- гэж гэрлэгчдийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг, садангийн хүн- гэж гэрлэгчдийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хэлнэ гэж тайлбарласан.

тарчилгах нэг хэлбэр юм[9].

Гэр бүл дэх хүчирхийлэл нь хэн нэг нь нөгөөгөө хүч чадал, эрх мэдлээрээ далайлган, эрхшээлдээ оруулах санаа зорилгоор, байнгын хяналт тогтоон өөрөөсөө хамааралтай байдалд оруулж буй тэгш бус харьцаа бөгөөд энэхүү харьцаа нь үргэлж мөнхөд айдасыг[10] төрүүлж, хүний сэтгэл зүй, бие махбодид өөрчлөлт үүсгэж байдаг бөгөөд далд хэлбэртэй, дахин давтагдах шинжтэй гэмт хэргийн хохирогч нь байнгын дарамт айдастай байдаг.

Гэр бүлийн гишүүдийн амин хувийн амьдрал нь хувийн нууцтай холбоотой байдаг эмзэг нарийн асуудал бөгөөд гэр бүлийн нууц[11] хэмээх тодотголтой, хаалттай хөшигний цаана хүчирхийлэлд өртөж хохирсон, хохирсоор байгаа этгээдээс зөрчигдсөн эрхээ хуулийн дагуу хамгаалуулах эрх нь гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах тул тийм мэдээ, мэдээллийг бусдад мэдүүлэхгүй, тараахгүй гэсэн үзэл бодлоор хязгаарлагдан хаагдаж байдаг байна.

Аливаа нэг хүчирхийлэл нь бусдын аюулгүй орчинд амар тайван амьдрах, халдашгүй дархан байх талаар Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхолд халдаж ноцтой гэм хор учруулж байдгаараа гэмт хэрэгт тооцогддог.

Гэмт хэрэгүйлдэх болсон шалтгааны 86 хувийг нөхрийн байнгын архидан согтуурал, мөнгө санхүү сэтгэл санааны дарамт шахалт, айлган сүрдүүлэлт, үндэслэлгүй хардалт болон зодуур нүдүүр хэрээс хэтэрч тэвчихийн аргагүй байдалд орсон явдал гэж ял эдэлж буй эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагын дүн[12]-гээр тодорхойлогдож байсан бол эр нөхөр хүчирхийллийг байнга төрүүлж байдаг гэж 48% нь тодорхойлсон нь бидний хийсэн судалгааны дүнгээс харагдаж байна.

Хүчирхийлэлд өртөж хохирсон эмэгтэйчүүд нь гэр бүл, ойр дотны хүмүүсийн дарамт шахалт, байнгын заналхийлэл, хүчирхийллээс чөлөөлөгдөхийн тулд гэнэт багтарсан уур[13]-аа барьж чадахгүй гэмт хэрэг үйлдсэн болохыг харуулж байна.

Гэр бүл, ахуйн хүрээн дэх хүчирхийлэл, хохирогчийн буруутай үйл ажиллагаа зэрэг нь эмэгтэйчүүд, хүүхдүүдээс үйлдэх гэмт явдлын нөхцөл байдал, тоон үзүүлэлтэд зохих хэмжээнд нөлөөлж байгаа нь "Хүмүүс ил тодоор хүч хэрэглэн, дарлах үед эсрэг эрх чөлөөгөө хамгаалан эсэргүүцлийн бат бэх далан босгож чаддаг. Харин тэрхүү хамгаалах даланг нь бага багаар хэмлэн эцэстээ гарцаагүй нурахад хүргэдэг шавьж хорхойн үйлдлийг огтоос анзаардаггүй"[14] хэмээсэн Италийн нэрт сэтгэгч Чезаре Беккариагийн үзэл онолыг батлаж байна.

Хүчирхийлэл нь өөрөө хүчирхийллийг төрүүлдэг. Та яагаад хүнийг санаатай алах гэмт хэргийг үйлдэх болов гэсэн асуултанд судалгаанд оролцсон 39 эмэгтэй ялтаны 12 буюу 30.7% нь бусдад дарамтлуулаад гэж, 6 буюу 15.3% нь сэтгэл санааны хямралтай байдлаас, 18 буюу 46.1% нь хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас, бусад гэдэгт 2 буюу 5.1% нь гэмт хэрэг тус тус үйлдсэн гэжээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

| Асуулт | тоо | Хувь |
|---|---|---|
| Сэтгэл санааны хямралтай байдлаас | 6 | 15.3% |
| Хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас | 18 | 46.1% |
| Бусдад дарамтлуулаад | 12 | 30.7% |
| Бусад | 2 | 5.1% |

Дээрхи судалгаанаас харахад эмэгтэй ялтны 61.4% нь гэр бүл дэх хүчирхийллийн улмаас сэтгэл санааны хямралтай байдал, хохирогчийн буруутай үйл ажиллагаанаас болж гэмт хэрэг үйлдсэн байна.

Өнөөгийн нөхцөлд гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж хүчирхийлэл түүнээс үүдэлтэй гэмт хэргийн гаралтыг багасгах, түүнтэй тэмцэх талаар хэрэгжүүлж буй төрийн цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна.

Хэдийгээр "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" Монгол Улсын хуульд **Гэр бүлийн хүчирхийлэл[15]** гэдгийг гэр бүлийн хүрээнд гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учируулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүй хэмээн тайлбарласан байдаг ч хүний эрхийг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд энэ хуулиар оногдуулах шийтгэл сул, хүмүүжлийн нөлөөлөл байдаггүй нь тэднээс дахин давтан хүчирхийлэл үйлдэх явдлыг бий болгодог байна.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэх хүчирхийлэл нь дараах хэлбэрээр үйлдэгддэг байна.

Үүнд:

А. **Бие махбодийн хүчирхийлэл**-хэн нэг нөгөөдөө өөрийн хүсэл сонирхол, эрх мэдлээ тогтоох зорилготой биенд

---

[9] "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги" гарын авлага. УБ. 2005 он. 10-р тал

[10] С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг" УБ. 2007 он. 21-р тал.
Айдас- англ fear- страх- сэтгэлийн түгшүүрийн нэг хэлбэр ба болсон болон хүлээгдэж буй үйл явдлаас үүснэ. Хүнд сэтгэл зүйн ба бие махбодийн өөрчлөлт үүсгэнэ.

[11] Мөн бүтээлийн148-р тал
Гэр бүлийн нууц- англ familusecrecu- бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл:

[12] Хүний эрхийн үндэсний төвийн судалгааны тайлан. УБ.2008 он

[13] Мөн бүтээлийн147-р тал
Гэнэт багтарсан уур-санаа сэтгэл нь гэнэт хүчтэйцочрон давчдах байдал

[14] Чезари Беккари. "Гэмт хэрэг ба ялын тухай" Г.Эрдэнэбатын орч. УБ.2007 он 33-р тал

[15] "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" Монгол Улсын хууль. 2004 он

нь алгадах, цохих, түлэх, өлсгөх, цангаах, даарuулах, халууцуулах, бэлгийн харьцаанд хүчирхийлэх зэргээр хүч хэрэглэх, халдах явдлаар илрэн гарна.

**Б. Эд хөрөнгийн хүчирхийлэл**-нэг нь нөгөөгөө эрхшээлдээ байлгах зорилгоор өдөр тутмын зайлшгүй хэрэглээг нь хязгаарлах, ажил хийлгэхгүй байх, цалин орлогоо өөртөө зарцуулах боломж өгөхгүй байх зэргээр эдийн засгийн боломжийг нь хязгаарлан хамааралдаа оруулахыг ойлгоно.

**В. Сэтгэл санааны хүчирхийлэл**–хүчирхийлэл үйлдэгч хэн нэг нь нөгөөгөө эрх мэдэлдээ оруулах зорилгоор хүсэл эрмэлзлэл, итгэл найдварыг нь нэр хоч өгөх, дуугаа өндөрсгөн хашгичих, зандрах, тэнэг, арчаагүй, залхуу, завхай, царай муутай гэх мэтээр мохоож сүрдүүлэн хэл амаар доромжлохыг хэлдэг байна[16].

Гэр бүл оршин тогтнохын баталгаа нь наад захын суурь хэрэгцээгээ хангах эдийн засгийн хүчин чадалтай байх явдал бөгөөд эдийн засаг, мөнгө, санхүүгийн боломж тааруу байх нь ёс суртахууны доголдол гаргах, хууль бус үйлдэл хийхэд хүргэж энэ нь даамжиран гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэх нь бий.

Гэр бүлийн гишүүдийн хооронд албан тушаал, эд хөрөнгө, мөнгө, ажил мэргэжил, эрх мэдлийн зөрүү гарснаар маргаан үүсч энэ байдлыг даамжруулан гүнзгийрүүлбэл улмаар гэмт хэрэг үйлдэх сэдлийг төрүүлдэг.

Амар амгалан гэр бүл оршин тогтнох хамгийн гол үндэс бол эрх, үүргийн тэнцвэр юм. Эрхийг чухалчилдаггүй, хариуцлагыг тоомсорлодоггүй гэр бүлүүд байнга нурах, бутрах аюултай. Эрхийг чухалчилж, үүрэг хариуцлагыг үл тоомсорлох нь гэр бүлийн зөрчилдөөнийг бий болгоно. Зөрчилдөөнийг дэвэргэсэн сэдэл нь үл ойлголцлыг үргэлжлүүлэн хурцатгаж улмаар хэн нэгнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэнэ.

Монгол Улсад гэр бүлийн гишүүд, садан төрлийн холбоотой хүмүүс хэн алиныхаа хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхолыг зөрчихөд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад хандах нь цөөн байдаг.

Судалгаанаас үзэхэд ард иргэдийн дийлэнх хувь нь буюу 83% нь дараах нөхцөл байдлуудын улмаас гэр бүлийн хүчирхийлэлд өртөн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн боловч цагдаагийн байгууллагад ханддаггүй болох харагдаж байна:

- “Зардал, чирэгдэл их гарч цаг хугацаа их зарцуулна” гэж төвөгшөөн хойш тавьж орхидог,
- “За яахав, ийм байдал зөндөө л болдог шүү дээ” хэмээн бодож нүдээ аниад дуугай өнгөрөх, уг үйлдэлтэй эвлэрэхийг хичээхийг оролдох,
- “Цагдаад мэдэгдсэнч гэсэн тайлбар, мэдүүлэг авахаас өөр олигтой, үр дүнтэй хүмүүжлийн арга хэмжээ авдаггүйгээсулам их дарамтлуулж энэ явдал дахиад давтагдах байх” хэмээн түгшдэг,
- “Өөрөө ухаарч ойлгох биз, муугнь үзээд яахав” гэсэн хандлагаар ахин хэрэг зөрчил гаргахгүй, засарч хүмүүжнэ гэсэн итгэлээр ханддаг,
- “Хамаатан, садНаа эвгүй байдалд оруулаад, гэр бүлийнхээ нэр хүндийг унагана” хэмээн болгоомжлох,
- Бүх зүйлд өөрийгөө буруутай мэтээр төсөөлөх зэргээр илэрдэг байна.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгааныг тодорхойлбол дараах хүчин зүйлүүд байна:

А. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчирхийлэл, гэмт хэрэгт нөлөөлжбуй гол шалтгаан бол архидан согтуурах явдал юм.

Согтууруулах ундааг хэвийн хэмжээнээс хэтрүүлж хэрэглэх нь хүмүүсийн хоорондын харилцааг муутгах, зөрчилдүүлэхэд хүргэдэг соёлч биш байдлын байнгын дагуул мөн. Согтуурагчид нь хэн нэгний эрх, ашиг сонирхлыг үл хайхран эрх зүйн болон ёс суртхууны хэм хэмжээг байнга зөрчдөг бөгөөд согтуурал нь гэрбүлийнхүрээнд хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх, гэмтэн үйлд түлхэн оруулагч хүчин зүйл болдог.

Архидан согтуурах нь гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааг тасалж согтуурагчдын сэтгэхүйд хувиа бодсон, бүдүүлэг, дээрэнгүй хандлага, сэдлийг төрүүлж энэ нь эцсийн эцэст гэмт хэрэг үйлдэх явдлаар төгсдөг байна.

Согтуурсан мансуурсан этгээд харгис хэрцгий, бүдүүлэг ааш авир гарган авирлахад нь түүнд хүчээр дарлагдан доромжлогдож эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хүмүүсээс түүний үйлдлийг тэвчихийн аргагүй байдал үүсч гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.

Б. Удаах нэг гол шалтгаан бол ажилгүйдэлбөгөөд манай улсад 2014 онд эрүүгийн 27318 гэмт хэрэг бүртгэгдэж түүнд 23737 хүн холбогдон шалгагдсаны 11658 буюу 49.1 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд гэмт хэрэгт холбогдсон 10 хүн тутмын 5 нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байна[17].

Гэр бүлд хүчирхийлэл үйлдэгч этгээд нь эрхэлсэн тодорхой ажилгүйн улмаас бухимдаж тэрхүү бухимдлаа архи ууж согтууран гэр бүлдээ гаргадаг бөгөөд энэ үйлдэл нь даамжирсаар улмаар өөрийгөө гэмт хэргийн хохирогч өрөөлийг хэрэгтэн болоход хүргэдэг байна.

Дараагийн гол шалтгаан бол ажилгүйдлээс үүдэлтэй ядуурал:

Ядуурал сүүлийн жилүүдэд огтхон ч буураагүй, харин ч нэмэгдэж улам гүнзгийрсэн нь ажилгүйдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор өрх гэрийн орлого, санхүүгийн чадавхи уналтанд орсон.

Төлөвлөгөөт төвлөрсөн эдийн засгийн нийгмээс зах зээлийн эдийн засгийн нийгэмд

[16] “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги” гарын авлага. УБ. 2005 он. 20-р тал

[17] Цагдаагийн Ерөнхий газрын статистик мэдээ. 2014 он

шилжих шилжилтийн үеэс эхлэн дээр дурьдсан хоёр шалтгаан нь гэмт хэргийн гаралтанд үнэмлэхүй жин дарах болсныг 1980-1990 он хүртэл 10 жилийн дотор бүртгэгдсэн гэмт хэргийн тооноос /30552/ шилжилтийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /85101/ даруй 2.8 дахин өссөн тоо баримтаас харж болно.

Төр засгийн зүгээс ядуурлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч байгаа боловч ядуурлын талаар хийсэн судалгаагаар манай улсын нийт хүн амын 32.2% нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдарч нэн ядуу өрхөд хамаардаг гэсэн статистик судалгаа байна.

Төвлөрсөн суурин газарт 6 хүний нэг нь ажилгүй, улсын хэмжээнд ядуу амьдралтай 10 хүний нэг нь ажилгүй байна. Архидалт, ажилгүйдэл, ядуурал нь өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нийгмийн үзэгдэл бөгөөд ажилгүйдэл их байгаа газар архидалт их байдаг ба ийнхүү нэг шалтгаан нь нөгөө шалтгааныхаа их үүсвэр болж байна.

В. Бас нэг шалтгаан нь уламжлал, зан заншилтай холбоотой асуудал юм.

Нийгмийн ёс суртахуун гэдэг ойлголт устаж байна. Иргэд эрх, эрх чөлөөгөө эдлэж байна гээд дураар авирлаж, үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байна.

Хүн бүр өөрийн сэтгэл санаанд болон гэр бүл, орчин тойрондоо амар тайван байдал бий болгох нь чухал. Иргэний ухамсар, ёс зүйг дээшлүүлэх талаар олон талт ажлыг зохион байгуулахад төр, төрийн бус болон олон нийтийн бусад байгууллагын оролцоо чухал шаардлагатай.

Өнөөгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, үйл ажиллагаа, механизм нь түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх гэхээсээ илүүтэйгээр гэмт хэрэг үйлдэхэд түлхэн оруулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлага нь гэмт хэрэгтэнг урамшуулах өнгө аястай мэт хөнгөн болсон, эс бөгөөс гэмт хэрэгтнийг хийсэн хэрэгтээ гэмших биш иргэн, нийгэм, төрд өширхөх сэтгэлийг даамжруулах хандлагатай болжээ.

Өнөөдөр эрүүгийн эрх зүйн салбарт үйлчилж байгаа хуулиудаас эхлээд тухайн үйлдэгдэн гарсан гэмт хэрэгт сэрдэгдсэн сэжигтэнтэй харьцахад хууль хамгаалах байгууллагын албан хаагчдын ажлын арга барил, ёс зүй, соёл, итгэл үнэмшил, тогтсон хандлагыг өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Манай улсын эрүүгийн эрх зүйн практикт эрүүдэн шүүх, цагдан хорихпрактик давамгайлах хандлагатай байгаа нь эмзэглэлтэй, анхаарвал зохих асуудал бөгөөд Монголын гэх тодотголтой хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд гэмт хэрэгтнүүдийн эгнээ өргөжих нэг үндэс бол иргэд болон гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдтэй хүнлэг бус, хатуу ширүүн, шударга бусаар хандах явдал байсаар байгаа нь нийгмийн гишүүдийн сэтгэл зүйд гаж нөлөөлөл үзүүлж, гэмт зан үйлд дасан зохицох үйл явц эрчимжих хандлагатай байгаа явдал тун харамсалтай.

Социологич Э.Дюрхэйм "… гэмт хэрэг нь нийгэмд эерэг үүрэг гүйцэтгэдэг, учир нь хүмүүсийн хамтын ёс суртахуун аль нэг гэмт хэргийн тухайд түүнийг үзэн ядах, эрс буруушаах мэдрэмжээрээ нэгдэж, харин ч гэмт хэргийн эсрэг нийгмийн сэтгэлзүйн дархлааг хөгжүүлдэг" хэмээжээ. Тэгвэл бидний хамтын амьдралд энэ мэдрэмж үзтэл унасаар байна.

Хэдхэн жилийн өмнө хүний амь нас хохирсон асуудлыг нийгмийн сэтгэлзүй ихэд цочирдон хүлээн авдаг байсан бол өнөөдөр олон нийтийн сэтгэл зүйн хүлээн авалт, төсөөлөл ерөнхийдөө онц хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн асуудлыг ердийн,байдаг зүйл мэтээр тусган авах болжээ.

Иргэд эрх зүйт төрд итгэх итгэл алдарч, хууль сахиулах байгууллага тэдэнд үйлчилнэ гэдэгт итгэхгүй эрх ашгийг нь хэзээ ч хамгаалахгүй гэж бодсон ийм сэтгэл зүй давамгайлах тусам хуулийг үзэн ядах, хууль хүчний байгууллага, цагдаагийн ажилтнуудыг үзэн ядах, эрх мэдэлтэн чинээлэг иргэдийг үзэн ядахад хүрдэг.

Хууль хэрэгждэггүй юм бол, шударга ёс байдаггүй,тэгш үйлчилдэггүй юм бол би ч гэсэн гэмт үйлдэл хийхэд ядаг юм хэмээсэн бодол, сэдэл тэдний зан үйлд илрэх хандлагатай байна.

Иргэд цагдаад итгэхээсээ илүүтэйгээр болгоомжилдог, цэрвэдэг болжээ. Тэдний хооронд үл итгэлцлийн маш том орон зай үүсээд байгаа нь цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын үйл ажиллагаа, хууль эрх зүйн өнөөгийн тогтолцоотой шууд холбоотой асуудал юм.

2014 онд Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж, бүртгэгдсэн гэмт хэргийг бүс нутгийн хэмжээнд авч үзэхэд:

**А.** Баруун бүс буюу Баян-Өлгий аймагт 1.5, Увс аймагт 6 дахин

**Б.** Хангайн бүсийн Хөвсгөл аймагт 50 дахин

В.Төвийн бүс буюу Төв, Дархан-Уул аймагт 2.5, Сэлэнгэ аймагт 3.5,

Говьсүмбэр аймагт 7 дахин

**Г.** Зүүн бүсийн Хэнтий аймагт 1.8, Дорнод аймагт 2.3, Сүхбаатар аймагт 18 дахин өссөн[18] байгаа нь нэг талаас гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт их байгаа, нөгөө талаар тухайн бүс нутгийн нэрлэсэн аймгуудын хууль хяналтын байгууллага түүний дотор Цагдаагийн байгууллага нуугдмал хэргийг илрүүлэн бүртгэж, шалгаж шийдвэрлэх ажиллагаа сайн байгааг харуулж байна.

Нуугдмал, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн тухай бүрт нь илрүүлж гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх нь шударга ёсны зарчмын илэрхийлэл бөгөөд урьдчилан сэргийлэх том ажил болдог.

Эцэст нь нийслэл хийгээд төвлөрсөн газар руу чиглэсэн нүүдэл нь хот суурин газарт хүн амын бөөгнөрлийг эрс хөөрөгдөж

[18] Цагдаагийн Ерөнхий газрын статистик мэдээ

гэмт хэрэг өсөхөд тодорхой байдлаар нөлөөлж байна. Оросын академич В.Кудрявцев "Хүн амын төвлөрөл нь хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх сэдэл, гэмт хэрэгтний биеэ авч явах байдалд шууд нөлөөлөхгүй ч, юуны өмнө гэмт зан үйлийн халдварлал, солилцоо явагдах, гэмт хэргийн орчин бүрэлдэх , соёл төлөвших, гэмт үйл ажиллагаа байгууллагажих нөхцөл болж,механик нөлөө үзүүлдэг" гэсэн юм.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, улмаар урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чиг хандлагыг өөрчлөх, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зүйн тогтолцоог өөрчлөх, т үүнтэй тэмцэхэд чиглэсэн мэргэшсэн хуулийн ажилтан, баг бэлтгэн ажиллуулах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл, ёс зүй, ухамсрыг засах, хүмүүжүүлэх ажлын арга хэлбэрийг өөрчлөн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчирхийллийн гэмт хэргийн дийлэнхи нь төрлийн хувьд хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг байдаг ба энэ тохиолдолд тодорхой субьектээс уг хэргийг нуун далдлахад амар хялбар байдаг тул үүнтэй Цагдаагийн байгууллагаас тэмцэх ажиллагаа нь хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэгтэй салшгүй холбоотой бөгөөд хэрүүл маргаантай, гэр орондоо байнгын түгшүүр төрүүлдэг хүмүүсийн бүртгэл судалгааг сайтар хийн хяналтанд авч, хүчирхийллийн шинжтэй зөрчлийг даамжруулахгүйгээр зүй зохистой шийдвэрлэх, зөрчил гаргагчийг хүчирхийлэл үйлдүүлэхгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтанд хамруулах, төрийн бус олон нийтийн байгууллагатай холбож өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Эмэгтэйчүүд, хүүхдийн болон бусад олон нийтийн байгууллагуудгэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар арга хэмжээ зохиодог гэх боловч үнэн хэрэгтээ төсөл хэрэгжүүлсэн нэр зүүж үр дүн багатай ажиллаж байгааг өөрчлөн тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааг төрийн байгууллагын ажилтай нягт уялдуулан холбож өгөх хэрэгтэй байна.

**Санал**

Гэр бүл дэх хүчирхийлэл гэр бүлийн хүрээнд үйлдэгдэн гарч буй нуугдмал гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар дараах саналыг дэвшүүлж байна.

- Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэх хүчирхийлэл, гэмт хэрэг гэж юу болох, энэ төрлийн гэмт хэрэгт өртөгдөн хохирсон тохиолдолд зөрчигдсөн эрхээ хамгаалуулах талаар хаана, хэнд , хэрхэн хандах, ямар арга хэмжээ авах талаар Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган сургалт зохион байгуулж, мэдлэг олгох.

- Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй гол нөхцөлүүд болох архидан согтуурах, ажилгүйдэл, ядуурал гэх мэт нөхцөл байдлуудыг багасгах, саармагжуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тооцож үйл ажиллагааг идэвхижүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

- Энэ төрлийн гэмт хэрэгт өртөгдсөн тохиолдолд утас веб сайт (мессеж хэлбэрээр)зөвлөгөө авах цахим мэдээллийн санг цагдаагийн байгууллагын харьяанд бий болгох.

- Монгол улсын хэмжээнд гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг болон үйлдэгдэх боломжтой гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийн сан, бүртгэлтэй болох, энэ талаар олон нийтэд ил тод мэдээлж байх

- Архидан согтуурах явдал нь гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гарах гол шалтгаан, нөхцөлийн нэг мөн тулархидалттай тэмцэх, соёлтой хэрэглэх хэрэглээг сурталчилах нь зүйтэй.

- Гэр бүлд хүчирхийлэл байнга үйлдэгддэг нь олон нийтийн болон цагдаагийн байгууллагын ажилтны тодорхойлолтоор нотлогдсон нөхцөлд шүүхээс хүчирхийлэгчийн саналыг үл харгалзан гэр бүл цуцлах асуудлыг гэр бүлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулж өгөх

- Гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчирхийлэлтэй холбогдох эрүүгийн хэргийн диспозицад уг хэргийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн бол хүндрүүлэн үзэж хариуцлага тооцохоор эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах

- Гэр бүлийн хүрээлэлд нуугдмал гэмт явдлын бүрэлдэхүүн хэсэг болсон нууц далд хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, шалгаж шийдвэрлэхэд дагнасан, мэргэшсэн ажилтанг бэлтгэж ажиллуулах

- Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа нууц далд үйлдэлтэй гэмт хэргийг илрүүлж, мөрдөх тусгай арга зүйг боловсруулан хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ашиглах

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчилдөө захиргааны арга хэмжээ авагдсаны дараа 6 сарын дотор дахин тийм зөрчил гаргасан бол хүндрүүлэн авч үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нуугдмал гэмт хэргийн талаар судалгаа, шинжилгээ явуулах эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлж, үр дүнг тооцон ажиллах

- Хүчирхийлэл үйлдэгч этгээдийн нууж хаацайлан далдлахыг хүсэж байгаа нууцлаг зүйлийг ил гарган далд сэдвийг дэлгэн тавих байдлаар олон нийтийн анхаарлыг хандуулан тэдний хяналтыг тогтоох зэрэг болно.

# МОНГОЛ УЛСАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Б.Мөнхзул: ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч*



Криминологийн шинжлэх ухаан нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаантай нягт холбоотой бөгөөд гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг эрх зүйн асуудал олон асуудлыг судлахад тэдгээрийн уялдаа холбоо илэрнэ. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийг авч үзсэнээр түүний шалтгаан, нөхцлийг зөв тодорхойлох улмаар түүнд үндэслэн хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулах боломж нөхцөл бий болдог. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн криминологи шинжийн хүрээнд Монгол улсад үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэрэг, түүний дотор халаасны хулгайн гэмт хэргийн гаралт, бүтэц, түүнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнд криминологи судалгаа хийлээ.

Улсын хэмжээнд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 2010-2014 онд **33627** гэмт хэрэгбүртгэгдсэний 14954 гэмт хэрэг буюу 44.4 хувь нь орон нутагт, 18673 гэмт хэрэг буюу 55.5 хувь нь нийслэлд бүртгэгдэж, нийт гэмт хэргийн **29.4** хувийг эзлэж байна.




Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь өмчийн эсрэг бусад гэмт хэргийн гаралттай харьцуулбал ямагт өсч, нийгмийн хор аюул буюу иргэн байгууллага, аж ахуйн нэгж, төрд учруулах хохирол нь байнга өсөн нэмэгдэж ирснийг сүүлийн 5 жилийн хугацаанд хийсэн криминологийн болон социологийн судалгааны дүнгээс харж болно.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт гэрэг тэр дундаа Халаасны хулгайн гэмт хэргийн гаралтын талаар судалгаа хийхэд зарим талаар хүндрэл гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь Улсын Дээд шүүхийн too мэдээ, судалгаанд халаасны хулгайн гэмт хэргийн тоо судалгаа гардаггүй, нийт хулгайлах гэмт хэрэг буюу Эрүүгийн 145-р зүйлээр гаргасан хулгайн гэмт хэргийн ерөнхий тоо мэдээнд ордог байна.

Мөн ЦЕГ-ын статистик мэдээ буюу эрүүгийн тоо бүртгэлд халаасны хулгайн гэмт хэргийн талаар 2009 он хүртэл тусгай тоо мэдээ байдаггүй, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо бүртгэлд орж явдаг байсан бол 2010 оноос халаасны хулгайн гэмт хэргийн тоо, мэдээ тусгайлан гардаг болсон нь маш олон талын ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл халаасны хулгайн гэмт хэргийн криминологи шинж, тус гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах зэрэг болно иймээс сүүлийн 4 жилд бүртгэгдсэн халаасны хулгайн гэмт хэргийн талаар судаллаа.

Монгол улсын хэмжээнд 2010 онд 177, 2011 онд 169, 2012 онд 249, 2013 онд 426, 2014 онд 586 буюу сүүлийн 5 жилийн байдлаар нийт 1607 халаасны хулгайн гэмт хэрэг бүртгэгдсэн байна.




Үүнээс **91.3 хувь нь нийслэлд, 88 гэмт хэрэг буюу 8.7 хувь нь** үйлдэгджээ. Тиймээс халаасны хулгайн гэмт хэрэг бол хот суурин газар үйлдэгддэг ба тэр дундаа Нийслэлийн төвийн бүсийн дүүрэг болох Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүрэгт бусад дүүрэгтэй харьцуулахад илүү бүртгэгдсэн байна. Харин захын буюу багануур, налайх дүүрэгт сүүлийн 5 жилд нийт 6 гэмт хэрэг бүртгэгджээ. Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.




Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт 30.7 хувьтай байгаа нь сүүлийн 4 жилд бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах нийт хэргийн илрүүлэлтийн түвшингээс 21.8 хувиар бага, 51.4 хувь нь хөнгөн ангиллын хэрэг байгаагаас үзэхэд халаасны хулгайн гэмт үйлдлийг бүртгэх, хүлээн авах, хэргийг илрүүлэх, шийдвэрлэх асуудал учир дутагдалтай байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 559 иргэнд 354,3 сая төгрөгийн хохирол учирсаны 30.2 хувийг нөхөн төлүүлжээ.

Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгддэг газрыг судлах нь төлөвлөгөөний дагуу нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж уг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг явуулахад ач холбогдолтой юм.

***Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөл***

Монгол улс, улс төр, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэн өнөө үед гэмт явдлын бүтэц, шинж чанар хөдөлгөөнд өөрчлөлт гарч гэмт хэргийн тоо өсөн нийгмийн хор аюул нь эрс нэмэгдэж байна. Гэмт хэрэгтэй тэмцэж гаралтыг нь багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх гол нөхцөл бол гэмт хэргийг төрүүлж буй шаптгаан, нөлөөлж буй нөхцлийг судалж мөн чанарыг нь тодорхойлох явдал юм. Гэмт явдлын шалттаан бол аль ч нийгэмд нийгмийн бодит зөрчил мөн.

Харин тэрхүү зөрчил нь нийгмийн амьдралын янз бүрийн түвшинд янз бүрийн хэлбэрээр илэрч байна. Энэхүү ухагдахуун нь аливаа гэмт явдал бол нийгмийн үзэгдэл бөгөөд түүний шалтгаан нөхцлийг нийгмийн мөн чанараас салангид авч үзэх боломжгүй юм гэдгийг харуулж байгаа юм. Гэмт явдлын шалтгаан нөхцлийг тодорхой үзэгдлийн хувьд авч үзвэл нэг төрлийн ойлголт биш гэхдээ эсрэг, тэсрэгойлголт биш юм. Харин олонх тохиолдолд шалтгаан нь нөхцөлтэйгээр харилцан холбоотойгоор түүгээр дамжин илэрдэг байна[1].

Халаасны хулгайн гэмт хэргийн гаралтад нөлөөлөх шалтгаан, нөхцлийг дараах байдлаар авч үзье.

***Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал.*** Хэрвээ хэрэгцээ ба гуйланчлал нь үгээгүй ядуучуудыг гэмт хэрэгт түлхдэг бол нийгэм эдийн засгийн тэгш бус байдлаар нөхцөлдсөн баяжих гэсэн шунал нь баячуудыг болон чинээлэг хэсгийнхнийг гэмт хэрэгт илүүтэй түлхэж байдаг.

Хаана, ямар улс оронд өлсгөлөн, гуйланчлал их байна, баян хоосны ялгаа зааг хол байна, тэнд нийгэм эдийн засгийн тэгш бус байдал төдий хэмжээгээр их байгаагийн гэрч болдог байна.

***Эд материалын гачигдал.*** Үүнийг шунахайн гэмт явдлын хоёр дахь бодит шалтгаан гэж үзэж болно. Гачигдал хэрэгцээ нь ямагт нэг тогтмол түвшинд байдаггүй.

Эд барааны гачигдал түүхэн явцад өөрчлөгддөг. Эрт дээр үед тансаг хэмээгдэж байсан зүйл өнөөдөр хүний амьдралын наад захын хэрэгцээ болох тал ч бий.

Ялангуяа хоол хүнсний гачигдал дутагдал, өвчин эмгэгтэй үед эмчилгээ хийлгэх боломжгүй нөхцөл байдал нь гэмт хэргийн замаар мөнгө олох сэдлийг шууд бий болгодог байна. Орчин үед нийгмийн хүн амын давхаргын зарим хэсгийн амьдралын түвшин байнга доошилж байгаа нь халаасны хулгайн гэмт хэргийн шалтгааныг нөхцөлдүүлж байна. Нийгмийн шинэ нөхцөл байдалд тохирсон хянаптын механизмыг бүрэлдүүлэх нь тийм амар бус тодорхой цаг хугацаа шаардах үзэгдэл юм.

***Эрх зүйн зохицуулалтын хомсдол, хуулийн хоцрогдол.*** Нийгэмд гарч байгаа шинэ харилцааг зохицуулахад түүнд тохирсон шинэ хууль чухал ач холбогдолтой. Манай улсын өнөөгийн хууль тогтоомж эдийн засгийн шинэ орчны өөрчлөлтийг гүйцэхгүй, түүнд нийцэж зохицохгүй, хууль боловсруулах сэтгэлгээ нь нийгмийн өөрчлөлтөөс хоцорч байгаа явдал үүнээс улбаалж эрх зүйн зохицуулалтын хомсдол бий болсон нь шунахайн гэмт явдлын шалтгаан болж байна.

Халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, эрүүгийн хариуцлагад татах явцад хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдал энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй нэг бодит шалтгаан болж байна.

Шунахайн гэмт явдлын дотор халаасны хулгайн гэмт хэргийн нуугдмал гэмт явдлын түвшин үлэмж өндөр байна. Тухайлбал гэмт хэрэг гарсан талаар хууль хамгаалах байгууллагад мэдээлээгүй, цагдаагийн байгууллагын ямар ч бүртгэлд тусгагдаагүй гэмт хэрэг үлэмж олон байна гэсэн үг. Бага хэмжээний хулгайн хэргийн талаар хохирогч нь цагдаагийн байгууллагад мэдээлэхгүй өнгөрдөг. Энэ нь цагдаагийн байгууллага уг зүйлийг олно гэдэгт үл итгэх, өөрөө эд зүйлээ хулгайд хэзээ алдсанаа бүрэн мэдэхгүй байх, нэгэнт олдох магадлалгүй зүйл дээр цаг гарздаж харилцааны соёлгүй, хүний төлөө санаа тавьдаггүй цагдаагийн ажилтнууд дахин дахин харилцахаас төвөгшөөх зэрэг олон шалтгааны улмаас ийм байдалд хүрдэг байна.

Мөн нилээд тохиолдолд иргэдийн мэдээлж байгаа гэмт хэргийг цагдаагийн байгууллага санаатай бүртгэж авдаггүй байна. Энэ нь гэмт хэргийг ноцтой биш, алдагдсан зүйлийн хэмжээ их биш, эзэн холбогдогч нь олдох найдваргүй тул эзэн нь илрээгүй хэргийн тоог нэмэгдүүлж ажлын үзүүлэлтийг доош татна гэж үзэх зэрэг олон шалтгаанаас болдог байна.

Гэмт хэрэг илрүүлэх хуулийн байгууллагын арга тактик хоцрогдож, илрээгүй гэмт хэргийн тоо олширсноос гэмт хэрэгтнүүд өөгшиж, улам улам мэргэшин мэргэжлийн шинж чанартай болж байна

***Бөөгнөрөл.*** Халаасны хулгайн гаралтын нэг гол шалтгаан нь ард иргэд хүн ам ихээр төвлөрсөн газар шахцалдах, түлхэлцэх, автобус, нийтийн тээврийн хэрэгсэлд буух, суух үед нэг нэгнээсээ өрсөж, урагшипж дайрах бус бие биенээ хүндлэн очер дараатай үйлчлүүлж, боловсон хүндэтгэлтэй, хүлээцтэй байвал халаасны хулгайчийг гэмт үйлдэлээ гүйцэлдүүлэх боломжийг бүрдүүлэхгүй юм. Гэвч одоогийн байдалд бага насны хүүхдийг багаас нь бие биенээ хүндлэх, аливаа зүйлд хүлээцтэй хандах талаар хичээл сургалтыг оруулж сэтгэхүйд нь төлөвшүүлэх. Ингэснээр цаашид бие биенээ гэсэн сэтгэпгээгээр хэн нэгэндээ хүндэтгэлтэй ямарваа нэгэн зүйлд ханддаг болох. Чухам тэр шахцалдаан бөөгнөрлийг л үүсгэхгүй бол халаасны хулгайн гэмт хэрэг үйпдэгдэх нөхцөл бүрдэхгүй юм.

***Хувь хүнтэй холбоотой асуудал.*** Хувь хүний зан байдал, архидалт, хөнгөн аргаар амьдрах гэсэн сэтгэлгээ, өөрийгөө удирдах чадваргүй бусдын нөлөөнд өртөмтгий байдал зэрэг хувь хүнээс өөрөөс нь шалтгаалах нөхцөл байдлууд гэж хуваан үзэж болохоор байна. Мөн хохирогч хүн ам ихээр төвлөрсөн газраар явахдаа авч явж буй эд зүйлдээ анхаарал болгоомжгүй явах, биедээ шаардлагагүй тохиолдолд их хэмжээний мөнгө авч явах, гар утас, камер, зургийн аппарат зэрэг эд зүйлээ ил задгай хапаасандаа хийх эсхүл оосорлон халааснаасаа ил авч явж байгаа зэрэг байдлаас болж халаасны хулгайчид бэлэн өгөөш бэлдэж өгч байгаагаас уг төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

***Ажил, сургуульгүй байдал*** нь гэмт хэрэг үйлдэх нэг гол шалтгаан мөн. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийн онцлог нь тэдгээрийн ихэнх нь ажил, сургуульгүй хүмүүс байлаг. Энэ нь халаасны хулгайч нар хулгайлж олсон мөнгө эд зүйлээрээ өөрийн амьдралын хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй шударга өөрийн хөдөлмөрөөр амьдарч буй иргэнээс хавьгүй дээр амьдардаг.

***Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал***

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл, шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоон, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн цагдаа, хуулийн байгууллагын хүрээнд бус өргөн хэмжээнд олон нийтийг

[1] Н.Жанцан "Криминологи" УБ.2004.,44 дэх тал

хамарсан нэгдсэн цогц арга хэмжээг авах шаардлагатай байна.

Бидний үзэж байгаагаар халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь онол практикийн хувьд дараах 3 үе шаттай байж болох юм. Үүнд:

Үүнд:

1. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгдэхээс иргэдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, сурталчилгаа явуулах,

2. Бүх төрлийн хулгайн гэмт хэрэг үйлдэхээр завдаж буюу бэлтгэж байгаа үед нь иргэд, олон нийтийн байгууллага, хууль хэрэгжүүлэх байгууллагууд, цагдаагийн ажилтануудын хүч, гүйцэтгэх ажлын журмаар илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх,

3. Гэмт хэрэг үйлдсэний дараа алдагдсан эд зүйлс, гэмт этгээдийн үйлдлийн арга. үлдээсэн ул мөр, гадаад шинж төрх зэргээр эрэн сурвалжилж, мөн иргэд байгууллагын туслалцаа, хуулиар олгогдсон бусад эрх үүргээ хэрэгжүүлэх замаар цагдаагийн байгууллага гэмт этгээдийг тогтоож, хэргийг илрүүлж болох зэрэг нилээд зүйлийг энд дурьдаж болох юм.

Иймд халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй:

- Халаасны хулгайн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх, эрүүгийн хууль болон захиргааны хариуцлагын хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах,
- Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцдэг Нийслэлийн Цагдаагийн газрын харъяа Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн үйл ажиллагааг сэргээх, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, орон тоог нэмэгдүүлэх, ажлын арга барил, үр дүн, зохион байгуулалтыг сайжруулах,
- Нэгэнт үйлдэгдсэн халаасны хулгайн гэмт хэрэг, хулгайчдыг халуун мөрөөр нь түргэн шуурхай илрүүлэх, хулгайч бүр гэмт үйлдлийнхээ төлөө заавал хариуцлага хүлээлгэж байх нөхцлийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шуурхай ажиллагаагаар бүрдүүлэх, халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэж шийтгэгдэж байсан хүмүүс, хорихоос суллагдсан хүмүүсийн зан байдал, үйл хөдөлгөөнөөрөө хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийг олж тогтоон бүртгэлд авч хяналт тавьж ажиллах;
- Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэхээр санаархаж, бэлтгэж завдаж байгаа уг этгээдийн үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийн тусламжтайгаар тайлан зогсоох,
- Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг зарж борлуулдаг сүлжээг илрүүлж, хулгайн эд зүйл зарагддаг газруудад тавих хяналтыг сайжруулах,
- Халаасны хулгайн гэмт хэрэг голчлон үйлдэгддэг дүүрэг, зах, томоохон их дэлгүүрүүд, олон нийтийн газруудад тавих техникийн хяналтыг сайжруулах, суурин болон зөөврийн камер байрлуулах,
- Иргэдийг их хэмжээний мөнгө, үнэт зүйлийг биедээ авч явахгүй, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх, энэ үүднээс банкны болон цалингийн картуудыг өргөнөөр ашигладаг болгож хэвшүүлэх,
- Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогч болохоос иргэдийг сэрэмжлүүлэх, сургалт сурталчилгааг олон төрөл, хэлбэрээр зохион байгуулах,
- Халаасны хулгайчдыг нэг бүрчилсэн бүртгэл судалгаатай болгох, бүлэг, хань хамсаатныг болон гэмт хэрэг үйлддэг маршрут, хөдөлгөөнийг хянах,
- Халаасны хулгайн хэрэгт явуулах хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуулийн дагуу бүрэн дүүрэн явуулах, гэм бурууг тухай бүр хуулийн дагуу хөтөлж зохих хариуцлага, ялыг ялгамжтай шударгаар оногдуулж байх, тэдэнд ял завшуулахгүй байх:
- Халаасны хулгайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээг хэрэг бүртгэлтийн шатанд тухай бүр авч хэрэгжүүлэх:
- Хот суурин газруудад баяр ёслолын үе, нийтийн тээврийн хэрэгслийн оргил ачааллын үе, гадаадын жуулчид ирэх үе зэрэг халаасны хулгайн гэмт хэрэг ихэсдэг үед халаасны хулгайч нарыг илрүүлэх зорилгоор тухай бүр шуурхай илрүүлэх, эрэн сурвалжлах хэсгийг ажиллуулах;
- Халаасны хулгайн гэмт хэргийн дотор нуугдмал, илрээгүй гэмт хэргийн ихэнх хувийг эзэлж байдаг учир бусдын эд хөрөнгийг хулгайлсан нуугдмал гэмт хэргийг нөхөн илрүүлэхэд гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг бүрэн дүүрэн ашиглах зэрэг болно.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна:

- Халаасны хулгайн гэмт хэргийг эрүүгийн хуульд хүндрүүлэх нөхцөл байдал болгох хуульчлах. Эсвэл Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнггийг хулгайлах гэмт хэргийг хохирлын хэмжээгүй буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болгон хуульчлах буюу гэмт хэргийн тухай хуульд заасан зохицуулалтыг дэмжиж байна
- Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг Эрүүгийн хуулийн 145-р зүйлийн 145.3-д заасан зохион байгуулалттай бүлэг үйлдсэнээр зүйлчлэх нь зөв. Учир нь халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд байнгын ашиг олох зорилготой, үүргээ хувиарласан буюу тогтвортой шинжтэй байдаг ганцаараа халаасны хулгай хийдэг этгээд бараг байдаггүй буюу ихэвчлэн зохион байгуулалтанд орсон бүлэглэж үйлддэг. Үүнийг нотлох ажиллагаа шаардлагатай байна. Тухайлбал: Турк уосад халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийн үйлдлийг баримтжуулан 2-3 жил дагаж, шалгаж цаад бүлэглэлийг илрүүлж шийддэг туршлага байдаг.
- Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага болох Нийслэлийн Цагдаагийн газрын харъяа Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн үйл ажиллагааг сэргээж бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, орон тоог нэмэгдүүлэх,
- Халаасны хулгайн гэмт хэргийн байдал, шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ул суурьтай, иж бүрэн шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийж, үүний үндсэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийг Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжүүлэх,
- Нийтийн тээврийн хэрэгсэл болон хүн ихээр цуглардаг зах, худалдааны төвүүдийг иж бүрэн камержуулах, камерийн хяналтыг нэмэгдүүлэх зэрэг болно.



# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

*Г.Ганбаатар:ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн захирал, докторант, цагдаагийн хурандаа*

Эрүүгийн хэргийн гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүсэх бөгөөд гэрч, хохирогч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт, тэдгээрийн өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал нь тэднийг хамгаалалт хэрэглэх үндэслэл болно.Хамгаалалтын арга хэмжээний төрлийг дараах байдлаар хуульчилан хамгаалалтанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосон байна:

a) аюулгүй байдлын арга хэмжээ,

b) сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн төрөлтэй байхаар

Аюулгүй байдлын арга хэмжээ нь эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээний нэг төрөл бөгөөд нийгэмд аюултай хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй этгээдийн "нийгэмд аюултай байдал"-ыг үгүй болгоход чиглэгдэхээс цээрлүүлэх зорилгогүй байдгаараа ялаас ялгагдана[1].Аюулгүй байдлын арга хэмжээний хэлбэрийг:

1) Урьдчилан сануулах,
2) Тодорхой үйлдлийг хязгаарлах,
3) Биечилсэн хамгаалалт,
4) Мэдээллийн нууцлалыг хангах,
5) Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник, холбооны хэрэгслээр хангах,
6) Аюулгүй газарт түр байрлуулах,
7) Нүүлгэн шилжүүлэх,
8) Баримт бичгийг солих,
9) Гадаад төрхийг өөрчлөх

Аюулгүй байдлын хамгаалалтын дээрхи арга хэмжээг аюулын нөхцөл байдлаас хамаарч дангаар буюу хослуулан хэрэглэж болох тухай ч заажээ.

Аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг авах шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн өгсөн болон өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэлийн ач холбогдол, тэдэнд учирч болох эрсдэл, арга хэмжээг хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн, уг арга хэмжээг хэрэгжүүлснээр олон нийтэд учирч болох эрсдэл зэрэг нөхцөл байдлын үнэлгээ хийж эрсдлийн түвшин, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагадах зардлыг харгалзан үзнэ.

Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн баг авна. Сэтгэл зүйн арга хэмжээ нь :

- Гэрч, хохирогчийг хамгаалалтанд авсан үеэс эхлэн сэтгэл зүйчийг хамт байлгах,
- Мөрдөн шалгах ажиллагааны үед гэрч, хохирогч оролцох бол үүсч болох сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх,
- Шүүх хуралдааны дараалал, явцын нөхцөл байдлын талаар мэдээлэх,
- Шаардлагатай бол шүүх хуралдаанд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлгах,
- Шаардлагатай бусад арга хэмжээ авахаас бүрдэнэ.

Хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчид хууль зүйн, сэтгэл зүйн, эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх, хамгаалалтын явцад өмнө ажиллаж байсантай ижил хэмжээний цалин хөлс бүхий ажлын байраар хангах, ийм боломжгүй тохиолдолд өмнө авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх нөхөн олговрыг олгох, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйл заасан журмын дагуу нөхөн төлбөр олгох тухай ч хуульчилсанд энэ хуулийн ач холбогдол оршино.

2005 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зорилтыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох буюу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, тийнхүү тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлох байдлаар хуулчилжээ.

Хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт: "Гэр бүлийн хүрээнд гэр бүлийн гишүүдийн аль нэг нь нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийсэн эрүүгийн хариуцлага хүлээхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг "гэр бүлийн хүчирхийлэл" гэнэ гэсэн хэм хэмжээг Эрүүгийн хуульд нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ хэм хэмжээтэй харьцуулан үзвэлгэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг, зөрчил

[1] С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2008. 48 дахь тал

гэсэн ангилалд хуваагдаж байгаа ба Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг бус зөрчлийг зохицуулах хууль болох нь харагдаж байна.

Энэ хуульд зааснаар хуулийн хамрах хүрээг олон улсын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар гаргасан эрх зүйн баримт бичгүүдтэй харьцуулан үзвэл тухайн улсад суугаа харъяалалгүй хүн болон гадаадын иргэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тэднийг хамгаалах талаар орхигдуулсан сул талтай байна.

Хуульд хохирогчийн эрхийн талаар:[2]

1) Эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах,

2) Хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах,

3) Хүүхдийн тэтгэлэг гаргуулах,

4) Тэжээн тэтгүүлэх,

5) Эдийн болон эдийн бус гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг заасан төдийгүй нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах,нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг тогтоох, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах, хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх тайлан мэдээ, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийн сүлжээ бий болгох үүргийг хүлээлгэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд гүйцэтгэх төрийн бус байгууллагуудын оролцоог хохирогчийг хамгаалах байраар хангах, зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх тухай заасан ч итгэмжлэгдсэн төлөөлөгч гэж хэн болох тухайд ямар нэг тодорхой хэм хэмжээ тусгагдаагүй байна. Хуулийн цоорхойг нөхөх зорилго бүхий УДШ-ийн 2006.101.30-ны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 47 дугаартай тогтоолд:“Итгэмжлэгдсэн төлөөлөгч гэдэг нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон аливаа хэрэг маргаанд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах үүрэг бүхий, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас итгэмжлэгдсэн этгээд байна” гэж тайлбарласан байна.

Цагдаагийн байгууллагын хувьд хохирогчийг хамгаалах зорилгоор[3]:

- Хамгаалах байранд хүргэх,
- Эцэг эх, төрөл садан, хамт олны түр хамгаалалтад өгөх,
- Шаардлагатай тохиолдолд хүүхэд асран хүмүүжүүлэх эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх,
- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх байгууллага, албан тушаалтны талаар буюу хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх үүргийг хүлээлгэжээ.

Хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэж буй хариуцлагын өнөөгийн байдлыг авч үзвэл гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсооход чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчийг албадан саатуулах, эрүүлжүүлэх /согтсон, мансуурсан тохиолдолд/, шүүх ньхүчирхийлэл үйлдэгчийн эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хязгаарлах арга хэмжээ авах эрхтэй байна.

Шүүх нь 24 цагийн дотор хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах болон хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор:[4]

1) тусдаа амьдрахыг даалгах,

2) хохирогчтой уулзах, уулзахыг оролдохыг хориглох,

3) дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох,

4) асрамжиндаа байгаа хүүхэдтэй харилцахыг түр хориглох,

5) зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах,

6) согтууруулах, мансуурах дон өвчтэй этгээдийг албадан эмчилгээ хийлгэх,

7) албадан хөдөлмөрлүүлэх зэрэг эрхийг хязгаарлах арга хэмжээ авах эрхийг олгожээ. Дээрхи арга хэмжээ авагдсан этгээд хохирогчийг асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөгдөхгүй.

УДШ-ийн тайлбарт “тусдаа амьдрахыг даалгах” гэдгийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчирхийлэл үйлдэгдэх бололцоо, нөхцөл, шалтгаан арилах хүртэлх хугацаанд хохирогчтой хамт нэг гэр амьдрахгүй байхыг шүүхээс түүнд үүрэг болгохыг хэлнэ[5] гэж хуульчилсан ч хүчирхийлэгч, хохирогч 2 нэг гэр бүлд хамтран амьдардаг өнөөгийн манай нөхцөл, амжиргааны түвшин нь тусдаа амьдрах боломжийг олгохгүй байгаа тохиолдолд энэ арга хэмжээ хэрэгжих эсэх, үр дүнтэй эсэх нь эргэлзээтэй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэснээс хойш нилээдгүй хугацаа өнгөрсөн, энэ хугацаанд шүүхээсхохирогчийг хамгаалах зорилгоор хүчирхийлэгчид эрх хязгаарлах арга хэмжээ ногдуулсан 41 шийдвэрийг гаргасан ч тэдгээр

[2] Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 15 дугаар зүйл 15.2. 2004

[3] Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 15 дугаар зүйл. 15.1. 2004

[4] Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 2004. 16 дугаар зүйл

[5] Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай. УДШ-ийн тогтоол. № 47. 2006.10.30. 7 дахь хэсэг

шийдвэрийн нэг нь ч хэрэгжээгүй[6] байгаа нь дээрхи арга хэмжээ хир үр дүнтэй, хэрэгжих боломжтой, бодитой болохыг харуулж байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бүхэлд нь авч үзвэл Захиргааны хариуцлагын тухай болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиудтай зэрэгцээ хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх гэхээс илүүтэй хохирогчийг хамгаалах тухай хууль болжээ гэж үзэж байна.

Дүгнэн үзэхэд манай улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлээд 10 жил, төр, Засгийн Газраас энэ чиглэлд авах арга хэмжээний талаар тусгасан хэд хэдэн хөтөлбөр боловсруулан баталсан ч гэр бүлийн хүчирхийлэлийг таслан зогсоох, хохирсон иргэдийг бүрэн хамгаалж чадахгүй байна.

Ийнхүү гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар төр засгаас төрөл бүрийн хөтөлбөр боловсруулах, хууль батлан гаргаж байгаа боловч, амьдрал дээр иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн судалгаа, судалгааны үндсэн дээр байгуулсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний хэдэн төв, гарын авлагуудаас өөр бодит зүйл үгүй байна.

Хүчин төгөлдөр хуулиудыг багцлан авч үзвэл гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс үүдэлтэй гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгаж, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх бүрэн боломж нь байгаа ч хууль хэрэгжихгүй байгаад хамаг учир нь байна.Ийнхүү батлагдан гарсан хуулиуд хэрэгжихгүй байгаагийн үндсэн шалтгаан нь:

1.Хуулиудын хооронд уялдаа холбоогүй,

2.Хууль боловсруулахдаа мэргэжлийн хуульч, судлаачдыг хамруулдаггүй,

3.Хууль батлан гаргаж байгаа боловч хэрэгжих нөхцөл болох санхүү, эдийн засаг, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр орхигдуулдаг,

4.Хуулийн байгууллагууд улс төржсөнтэй холбоотойгоор тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчин дутмаг байдал,

5.Улс төрийн томилгоотой холбоотойгоор эхэлсэн ажил хэрэгжилт нь хангагдахгүй үгүйсгэгддэг зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын заалтуудаас харахад гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийг мөрдөх болон хохирогчийн эрхийг хангах, аюулгүй байдлыг хамгаалах баталгааг бүрдүүлсэн эрх зүйн орчин бүрдсэн ч тодорхой хүчин зүйлүүдээс үүдэлтэйгээр хууль хэрэгжихгүй байгаагийн улмаас гэр бүлийн хүчирхийлэл таслан зогсоогдохгүй, хохирогчдийн эрх хамгаалагдахгүй зөрчигдсөөр байна.

[6] mongolcom.mn. 2015.03.30

## ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



# ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗҮЙЛИЙН ТАЙЛБАР, МӨН ЧАНАР, ТҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ

*Г.Гантөмөр: Отгонтэнгэр их сургуулийн багш, хууль зүйн доктор, дэд профессор*

Эрүүгийн эрх зүйг сонирхон судлагч хэн боловч Эрүүгийн хуульд зүйлийн тайлбар байдгийг мэддэг, хуулийг хэрэглэх эрх бүхий субъектууд түүнийг үндэслэн эрүүгийн хуулийг хэрэглэдэг.

Гэхдээ Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбар гэж юу болох, ямар учраас эрүүгийн хуульд хуульчилдаг эсэх, түүний хууль зүйн мөн чанар, учир холбогдлын талаар тэр болгон мэддэггүй.

Монгол Улсад эрх зүйн ерөнхий онолд төдийгүй эрүүгийн эрх зүйд хуулийн зүйлийн тайлбарын талаар тусгайлан судалсан болон дурьдсан бүтээл үгүй байна.

Иймээс түүний мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг судлах хэрэгцээ шаардлага нь зөвхөн эрүүгийн эрх зүйн онол төдийгүй хууль зүйн техник,хууль хэрэглэх ажиллагааны практикаас урган гарч байгаа бөгөөд танин мэдэхүйн болон практик ач холбогдолтой асуудал гэж үзэж байна.

Түүхэн уламжлал талаас авч үзвэл, манай улсын анхны төрөлжсөн эрүүгийн хууль болох 1926 оны Шүүх цаазын бичгээс эхлэн зүйлийн тайлбарыг хэрэглэж иржээ. 1926 оны Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн "Шүүх цаазын бичгийн журамлан дагаж явуулах хэмжээ хязгаар" гэсэн нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн тайлбарт "... Аливаа хууль цааз дор заасан эл явдлыг гэмт хэрэг дор тооцвоос зохимой..." гэж, 11 дүгээр зүйлд "...Ял торгуулийг төгрөг ба мөнгөөр тогтооно. Хэрэв цааз хуулийн дотор ялын дээд хэмжээ нь нэг зуун төгрөгнөөс дээш бус болбоос ял торгохыг даган арван төгрөгнөөс дотогш торгож үл болно. Ял тушаах хугацааг шүүх таслах газрын тогтоон шийтгэсэн өдрөөс хойш нэгэн жил хүртэл сунгаж болно. Хэрэв ялыг тушаах чиггүй бөгөөс нэгэн төгрөгт нэг өдөр бодож түүний биеийг хорихгүйгээр үйлдвэр хийлгэнэ..." гэж заасан бөгөөд уг зүйлийн тайлбарт "...Ялыг шударгаар тушаахгүй, ялаас зайлхийсэн болбоос түүний хувийн хөрөнгө хогшлыг албан газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газарт хадгалуулсан мөнгө зоос, жич бусдаас авах зүйл байваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр тушаалгавал зохино..." гэж торгох ялыг биелүүлэхээс зайлхийсэн тохиолдолд уг ялыг биелүүлэх нөхцөл журмыг заасан байдаг[1].

1929 оны Шүүх цаазын бичигт ч ийм тайлбаруудыг өгснийг Ерөнхий ангийн 12 дугаар зүйлийн тайлбараас харж болно. 12 дугаар зүйлд "... Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүх таслах газраас тогтоосон нэг жилээс таван жил хүртэлх тэнсэх хугацааны дотор ялт хүмүүн дахин нэг төрлийн буюу өөр хүнд гэмт явдал эс үйлдвээс оноосон ялыг үл эдлүүлмой..." гэж заагаад уг зүйлийн тайлбарт нь "...Хэрвээ гэмт хэрэг үйлдсэн хүмүүний зан авир нь ард орны байдалд онц аюултай болбоос тэнсэж үл болмой..."[2]гэж ял тэнсэж болохгүй нөхцлийг заажээ.

Иим тайлбарууд 1934 оны Шүүх цаазын бичиг, БНМАУ-ын 1942, Эрүүгийн хуульд ч байсан. Тухайлбал 1942 оны Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 10 дугаар зүйлд "... Гэмт хэрэг үйлдэх үед үргэлжийн буюу түр ухаан солиурах өвчинтэй байсан буюу өөр өвчний эрхээр чухам үйлдсэнээ эс ухамсарласан ба мөн түүнчлэн гэмт хэрэг үйлдэхдээ ухаан бүрэн байсан боловч таслан шийтгэх үед ухаан балартах өвчин тохиолдвол ял шийтгэж үл болно..." хэмээн хэрэг хариуцах чадваргүй байдлыг хуульчлахдаа уг зүйлийн тайлбарт "...Ууж согтуурах үедээ гэмт хэрэг үйлдэгчийг эрүүгийн хаирцлагаас үл чөлөөлнө..." гэж заасан бол Тусгай ангид БНМАУ-ын хил хууль бусаар нэвтрэх гэмт хэргийг хуульчилсан 104-р зүйлийн тайлбарт "...Хөдөлмөрчин ард түмний эрх ашгийг хамгаалсан буюу үндэсний эрх чөлөөний төлөө тэмцсэн явдалд хавчигдсаны улмаас зайлсхийж БНМАУ-д тогтоосон паспорт буюу засаг захиргааны байгууллагын үнэмлэхгүйгээр нэвтрэн ирсэн гадаавын иргэн харъяат нарт улсын үндсэн хуулийн 88-р зүйлийн ёсоор өөрийн улсад суух орогнол олгох тул энэ зүйл үл хамаарна..."[3]гэж зааж байв.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд хууль тогтоогч ерөнхий ангид төдийгүй тусгай ангиийн нэг ч зүйлд зүйлийн /хэм хэмжээний/ тайлбар хийгээгүй, тийм хууль зүйн техникийг огт хэрэглээгүй байгаа нь сонирхол татаж байна. Харин үүний оронд урьдах Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбарт зааж байсан

---

[1] Д.Адъяабазар.Монгол улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт.УБ.1998 он.8 дахь тал

[2] Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/УБ. ХЗЯ. ХЗҮХ.2011 он. 313 дах тал

[3] Мөн тэнд. 381 дэх тал

хэм хэмжээг тухайн зүйлийн бүтцэд гепотез хэлбэрээр оруулж дугаарлан байрлуулжээ. Бидний дээр дурьдсан 1942 оны эрүүгийн хуулийн 104 дүгээр зүйлийн тайлбарт заасан хэм хэмжээг 1961 оны Эрүүгийн хуульд "Хууль бусаар хил нэвтрэх гэмт хэрэг" буюу 61 дүгээр зүйлийн "б" оруулж хуульчилсан байдаг. Мөн 139-р зүйлд урьдах эрүүгийн хуулийн "...хээл хахуулийг албан тушаалтны далайлган сүрдүүлснээр өгсөн эсвэл хээл хахууль өгсөн этгээд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө зохих байгууллага буюу хариуцлагатанг мэдээлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.."[4] гэсэн тайлбарыг уг зүйлийн "б" гепотез болгон оруулжээ.

1986 оны БНМАУ-ын шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн тухайд хууль тогтоогч Ерөнхий ангид зүйлийн тайлбарыг хэрэглээгүй, харин Тусгай ангийн 60 /Эх орноосоо урвах/, 79 /Хууль бусаар БНМАУ-ын хил нэвтрэх/, 123 /Улс хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг хулгайлж ашиглан шамшигдуулах/, 153 /Иргэний амины эд хөрөнгийг хулгайлах/, 192 / Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах/, 203 /Илт хууль бус таслан шийтгэх тогтоол, шийдвэр, магадал, тогтоол гаргах/, 247 /Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар авч явах, хийж бэлтгэх, олж авах, хадгалах, борлуулах/, 260 /Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих/ гэсэн 8 зүйлд тайлбарыг хэрэглэсэн байдаг.

Аливаа эрх зүйн үзэгдэл, ухагдахуун, түүнийг илэрхийлсэн нэр томъёог хэл зүйн үүднээс авч үзэх нь тухайн үзэгдлийн мөн чанарыг бүрэн таньж мэдэх, түүний ойлголтыг хууль зүйн үүднээс зөв тодорхойлох, хууль зүйн учир холбогдол, зарчим, бүтэц, зүй тогтол, үр дагаварыг нээн харуулах, цаашид гүнзгийрүүлэн судлах боломжийг олгоно.

Тайлбар гэдэг нь утгыг тайлбарласан бичиг, утга агуулгыг нэмэн дэлгэрүүлж тайлж хэлсэн, бичсэн зүйл, тайлбарлах юмны утга учрыг нэмж дэлгэрүүлэн хэлэх, таниулж өгөх[5] гэсэн утгыг илэрхийлэх ба тайлбар гэдэг үгийн сүүлийн утга нь бидний тодорхойлж буй хуулийн зүйлийн тайлбарт хамаарч болохоор байна.

Одоо Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбарын ойлголт, хууль зүйн мөн чанар, учир холбогдолын талаар авч үзье

Хуулийн зүйлийн тайлбарын хууль зүйн мөн чанарыг нээн харуулахад чиглэгдсэн анхдагч асуудал бол түүнийг эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахаас ялгах, өөрөөр хэлбэл тэдгээрийн хууль зүйн мөн чанар, шаардлага, арга зүй, учир холбогдлын ялгаатай талыг тодорхойлох явдал мөн.

Хуулийн зүйлийн тайлбар нь эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахаас өөр ойлголт бөгөөд эрх зүйн ерөнхий онолын үүднээс авч үзвэл албан ёсны, хэм хэмжээний тайлбар гэсэн ангилалд багтана.

Хуулийн зүйлийн тайлбар нь хууль тогтоогчоос тодорхой хуулийг батлан гаргахдаа уг хуульд орсон нэр томъёог болон тодорхой хэм хэмжээний үйлчлэх хэмжээ хязгаар, хэрэглэх нөхцөл байдлыг тайлбарлан хуульчлах замаар хийгдэх ба хуулийн адил хүчин чадалтай, түүнийг бүх нийтээр заавал мөрдөх, заавал биелэгдэх шинжтэй байдагт түүний мөн чанар, онцлог оршино.

Харин эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нь эрх олгогдсон субъектээс нэгэнт батлагдан, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг тайлбарлах, түүнд хуульчлагдсан хэм хэмжээний хууль зүйн агуулга, утга санаа, нэр томъёо, зарчим, үйлчлэх хүчин чадал, хэмжээ хязгаарыг нээн харуулах үйл ажиллагааг хэлэх[6] ба уг тайлбар нь тайлбарлаж буй хуульдаа нийцсэн байх, хэрэв хуультайгаа зөрчилдвөл хуулиа баримтлах, уг тайлбарыг хүчингүй болгох, өөрчлөгдөх зэрэг хууль зүйн учир холбогдол, онцлогтой байдаг.

Уг асуудлын хүрээнд авч үзэх хоердахь асуудал бол эрүүгийн хуулийн зүйлийн тайлбарыг ямар зорилгоор /шаардлагаар/ хууль тогтоогч өгдөг тухай асуудал юм.

Эрүүгийн хуульд зүйлийн тайлбарыг хэрэглэж байсан болон хэрэглэж байгаа өнөөгийн байдлыг судлан үзэхэд түүнийг эрүүгийн хуулийг хэрэглэх ажиллагааг хөнгөвчлөх, эрүүгийн хуульд байгаа эрх зүйн ойлголтуудыг хэл зүйн болон хууль зүйн үүднээс нийт ард иргэдэд болон хууль хэрэглэгчдэд ойлгомжтой болгох, Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээнд заасан зан үйлийн горим журам буюу тодорхой нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэхүй/ нь ямар нөхцөлд гэмт хэрэг болох эсвэл болохгүй буюу түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эс хүлээлгэх нөхцөл байдлууд эсвэл уг хэргийг үйлдсэн этгээдийг ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх нөхцөл байдлуудыг зааж өгөх зорилгоор хуульчилдаг нь харагдаж байна.

Хуулийн зүйлийн тайлбарын хууль зүйн мөн чанарыг тайлбарлах нь гуравдах асуудал буюу зүйлийн тайлбар нь бие даасан эрх зүйн хэм хэмжээ юу? эсвэл эрүүгийн хуулийн зүйлийн /хэм хэмжээний/ нэг хэсэг үү? гэсэн асуултанд хариулахаас ихээхэн шалтгаална.

Хүчин төгөлдөр үйлчилж буй 2002 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 79/ Эх орноосоо урвах/, 82 /Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах/, 82-1 /Сонгуулийг будлиантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах/, 89 / Хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх/, 108 /Хүн хулгайлах/, 112 /Хүн барьцаалах/, 113 /Хүн

[4] Мөн тэнд. 456 дах тал

[5] Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь. УБ.УХГ.1966 он. 512-513 дах тал, Монгол хэлний тайлбар толь. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Мон судар хэвлэлийн газар. УБ. 2014.1148 дах тал

[6] Ч.Нямсүрэн.Эрх зүй, төрийн онол. УБ.2004 он. 296 дахь тал, Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ.1996 он.81 дэх тал

худалдаалах/, 177 /Зандалчлах/, 185 /Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх/, 215 /Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих/, 231 /Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох/, 258 /Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх/, 263 /Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 265 /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 270 /Хээл хахууль зуучлах/, 270-1 /Хууль бусаар хөрөнгөжих/, 301 /Олон улсын хамгаалалтанд байдаг хүмүүст халдах/ гэсэн 17 зүйлд хууль тогтоогч зүйлийн тайлбарыг хэрэглэсэн байх ба үүний 6 нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, 7 нь нэр томъёог тайлбарласан, 2 нь тухайн үйлдэл нь гэмт хэрэг болохгүй буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх нөхцөл байдлыг заасан, 2 нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, нөхцлийг заасан байна.

УИХ-д өргөн бариад байгаа “Гэмт хэргийн тухай хууль”-ийн төсөлд[7] ч зүйлийн тайлбарыг хэрэглэхээр тусгажээ. Төсөлд ерөнхий ангид 6-р зүйл /Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал/ Тусгай ангид 10.1 / Хүнийг санаатай алах/, 10.3 / Эх нь нярай хүүхдээ алах/, 11.1 / Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.7 /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 12.1 /Хүчиндэх/, 12.3 /Бэлгийн мөлжлөг/, 13.1 /Хүн худалдаалах/, 13.2 /Хүн хулгайлах/, 13.4 /Хүн барьцаалах/, 13.6 /Хүний орон байранд хууль бусаар нэвтрэх/, 17.3 /Залилах/, 19.2 /Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.5 /Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 19.8 / Тагнуул хийх/, 19.12 /Монгол улсын хилийг хууль бусаар нэвтрэх/, 20.2 /Террор үйлдэхэд бэлтгэх/, 20.7 /Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших/, 20.10Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар ашиглах/, 21.6 / Өмгөөлөгч, прокурор, шүүгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх/, 22.3 / Гадаад улсын, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.5 /Хахууль өгөх/, 27.4 / Нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох/, 28.1 / Тушаал биелүүлэхгүй байх/ гэсэн нийт 24 зүйлд тайлбарыг хуульчилахаар зааснаас нэр томъёо тайлбарласан 10, гэмт хэргийн шинжийг тайлбарласан 1, гэмт хэрэг болохгүй /гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэх/ нөхцөл байдлуудыг заасан 6, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөхөөр заасан 7 тайлбар байна.

Монгол улсын Эрүүгийн хуульд зүйлийн тайлбарыг хэрэглэж ирсэн байдлыг судалж үзэхэд ийм тайлбарын тоо шинээр эрүүгийн хуулийг батлах, шинэчлэн найруулах бүрт өсөх хандлагатай явж ирсэн нь анхаарал татаж байна. БНМАУ-ын 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд 8, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2002 оны Эрүүгийн хуульд 15 зүйлийн тайлбар байгаа бол УИХ-д өргөн бариад буй “Гэмт хэргийн тухай хууль”-ийн төсөлд 24 зүйлд зүйлийн тайлбарыг хуульчилахаар тусгаад байна.

Одоо хүчин төгөлдөх үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгайн ангид байгаа 17 зүйлийн тайлбаруудыг судлахад тэдгээр нь бие даасан хэм хэмжээ бус, өөрөөр хэлбэл шинээр заавал мөрдөх зан үйлийн горим журмыг /гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заагаагүй/ хуульчлаагүй, харин тодорхой зүйлд хуульчлагдсан нэр томъёог тайлбарлах, эсвэл түүнд тодорхойлсон зан үйлийн горим журам буюу тодорхой гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зарим шинжийг дэлгэрүүлж тайлбарласан, эсвэл уг үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг /гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болох/ болохгүй нөхцөл байдлыг, эсвэл эрүүгийн хариуцлагаас, ялаас чөлөөлөх үндэслэл, нөхцлийг заасан гепотезийн үүрэгтэйгээр байгаагаас үзэхэд түүнийг бие даасан хэм хэмжээ гэж үзэх үндэслэлгүй байна.

Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээ гэж эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн эрх ашиг, сонирхол / үнэт зүйлд/ халдсан, эрүүгийн хариуцлага хүлээх, тодорхой нийгэмд аюултай гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж / бүрэлдэхүүн/, уг хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг хуульчилсан зан үйлийн горим журмыг хэлэх бөгөөд зүйлийн тайлбар нь шинээр зан үйлийн горим журам буюу гэмт хэрэг тооцсон, түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчилаагүй, харин тухайн зүйлийг тайлбарлах замаар түүнийг нийт ард иргэдэд төдийгүй хууль хэрэглэгчдэд эрүүгийн хуулийг зөв ойлгох, хэрэглэх боломжийг олгох зорилготойгоор хуульчилагддаг.

Монгол улсад Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбарыг хэрэглэж ирсэн, хэрэглэж байгаа нөхцөл, шаардлага нь эрх зүйн ерөнхий онолын болон ЭЭЗүйн онолын сэтгэлгээний хөгжил, хууль зүйн техник хэрэглэх арга ажиллагааны тогтсон, хэвшмэл чиг хандлагатай хамааралтай, тэдгээртэй холбон тайлбарлаж болох юм.

ЭЭЗүйд Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээ нь тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон диспозици, уг гэмт хэрэгт хүлээлгэх ялын төрөл, хэмжээг тогтоосон санкц гэсэн 2 хэсгээс бүрдэнэ гэсэн онолын үзэл баримтлалыг олонхи эрдэмтэд, судлаачид хүлээн зөвшөөрдөг, тэгж тайлбарласаар ирсэн[8]. Үүнээс үндэслэн Эрүүгийн хуулийн

[7] Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь. УБ.УХГ.1966 он. 512-513 дах тал, Монгол хэлний тайлбар толь. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Мон судар хэвлэлийн газар. УБ. 2014.1148 дах тал

[8] Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн онол. УБ.2004 он. 296 дахь тал, Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ.1996 он.81 дэх тал

тусгай ангийн хэм хэмжээнд диспозицид заасан зан үйлийн горим журам буюу гэмт хэргийн бүрэлдэхүүн, санкцаар тогтоосон уг хэргийг үйлдсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хэрхэн хэрэгжих, өөрчлөгдөх нөхцлийг заасан бүтэц буюу гепотез байдаггүй гэж үздэгээс түүнийг хуульчилдаагүй, үүний оронд зүйлийн тайлбар хийх хууль зүйн техник хэрэглэх аргыг өнөөдрийг хүртэл хэрэглэсээр байгаа билээ.

Харьцуулсан эрх зүйн үүднээс гадаадын зарим орнуудын эрүүгийн хуулийг судлахад дараах хоёр байдал, хандлага харагдаж байна.

Нэгдэх нь манай улсын эрүүгийн хуультай адил зүйлийн тайлбарыг хэрэглэж түүнд эрүүгийн хуульд байгаа нэр томъёо, тодорхой гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх нөхцөл журмыг хуульчилдаг явдал бөгөөд ийм орнуудад хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан ОХУ, Казакстан, Кыргызстан зэрэг цөөн орнууд хамаарч байна.

Хоёрдах хандлага буюу зүйлийн тайлбарыг хэрэглэдэггүй, эрүүгийн хуулийн нэр томъёог бие даасан дефинитив хэм хэмжээнд хуульчилдаг, харин тодорхой гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх /хүлээлгэхгүй байх/ нөхцөл, эрүгийн хариуцлага,ялаас чөлөөлөх нөхцөл журмыг тухайн зүйлийн бүтцэд гепотез хэлбэрээр хуульчилдаг орнууд дийлэнх хувийг эзэлдэг ба сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.Жишээ нь: Герман улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн II бүлгийн 11 параграфт /зүйлд/ хуулийн нэр томъёог тайларласан байдаг[9] бол Голланд улсын Эрүүгийн хуулийн "Нийтлэг үндэслэл" гэсэн I дэвтэр буюу манай жишгээр бол Ерөнхий ангийн IX хэсгийн 78-91-р зүйлүүдэд эрүүгийн хуульд байгаа бүхий нэр томъеог тайлбарлажээ[10]. Ийм зүйл Швейцари, Польш, Болгар зэрэг орнуудын эрүүгийн хуульд бий[11].

Уг хандлага, жишиг манай уллсын хувьд ч шинэ зүйл биш, хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ-ийн 5-р зүйлд ЭБШХ-д заасан нэр томъёонуудыг нэг бие даасан зүйлд хуульчилсан байдаг нь үүнтэй үндсэндээ ижил юм.

Иймээс бид эрүүгийн хуулийн зүйлийн тайлбар нь эрүүгийн хуулийн зүйлд заасан заасан нэр томъёог тайлбарлах, түүнд хуульчилсан тодорхой гэмт хэргийн шинжийг / бүрэлдэхүүнийг/ дэлгэрүүлж тайлбарлах, тухайн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг болохгүй нөхцөл байдлыг, эсвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, нөхцлийг хуульчлах замаар гепотезийн үүргийг гүйцэтгэдэг бие даасан хэм хэмжээ бус, уг хэм хэмжээний нэг бүрэлдхүүн хэсэг гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэхэд Эрүүгийн хуулийн зүйлийн тайлбар гэдэг нь бие даасан эрүүгийн хуулийн хэм хэмжээ бус, эрүүгийн хуулийн тодорхой зүйлд хэрэглэсэн нэр томъёог тайлбарласан эсвэл түүнд хуульчилсан тодорхой төрлийн гэмт хэргийн шинж, түүний агуулга, хамрах хүрээ, үр дагавар /уг үйлдэл нь ямар тохиолдолд гэмт хэрэг болох, ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлах/ зэрэг тухайн зүйлийг хэрэглэх нөхцөл, журмыг заасан, хууль тогтоогчоос албан ёсны, хэм хэмжээний тайлбар хэлбэрээр өгөгдсөн, тухайн хэм хэмжээний бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ.

Энэхүү судалгааны үр дүнд дараах саналыг дэвшүүлж байна:

- Цаашид Эрүүгийн хуульд зүйлийн тайлбарыг хуульчилахгүй байх, зүйлийн /хэм хэмжээний/ тайлбар хийдэг хууль зүйн техникийн энэ уламжлалт хуучинсаг аргаас татгалзах,
- Эрүүгийн хуулийн тусгай ангийн тайлбаруудад өгсөн нэр томьёоны тайлбарыг нэгтгэн Герман болон бусад барууны орны эрүүгийн хуулийн адил ерөнхий ангид бие даасан зүйлд нэг дор буюу дефинитив хэм хэмжээнд хуульчилах,[12]
- Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн /Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ч нэгэн адил хамаарна/ тодорхой зүйлүүдэд өгсөн гэмт хэрэг болохгүй нөхцөл байдал, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх нөхцөл байдлыг заасан тайлбаруудыг тухайн зүйлийн үндсэн бүтцэд гепотез хэлбэрээр 1961 оны Эрүүгийн хуультай ижил байдлаар хуульчилах, цаашид тийм хууль зүйн зүйн техникийн аргыг хэрэглэж хэвших,
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Цэргийн гэмт хэргийн бүлэг"-т[11] дефинитив хэмжээг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 274 дүгээр зүйлтэй адил байдлаар хуульчилж түүнд цэргийн хэргийн ойлголт, субъектын асуудлыг тусгах зэрэг болно.

[9] Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. ХЗЯ. УБ. 2015 он

[10] Г.Совд. БНМАУ-ын ЭЭЗүйн курс. Ерөнхий анги. УБ.УХГ.1973 он. 84 дэх тал, С.Жанцан. Монгол улсын ЭЭЗүйн онол.1-р дэвтэр. Гэмт хэргийн сургаал. УБ.2009 он.138 дах тал, С.Нарангэрэл. Монгол улсын ЭЭЗүй.Ерөнхий анги. УБ.1999 он. 66 дах тал, Ж.Болдбаатар. ЭЭЗүйн тулгуур ойлголтууд. УБ.2002 он.16 дах тал,

[11] Уголовный кодекс ФРГ. Москва. Изд Юридический Колледж МГУ.1996



# НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТНЫ ЗАРИМ АСУУДАЛ

*Я.Цэлмэн ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн ахлах багш, агдаагийн ахмад*

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн[1] 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт "Нотлох ажиллагаа нь хэргийг хуулийн дагуу, шударга, үндэслэлтэйгээр хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тогтоохын тулд нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаанаас бүрдэнэ" гэж заасан.

Нотлох ажиллагаа нь дээрх хуулийн заалтаас үндэслэн эрүүгийн хэргийг байж болох хамгийн үнэн зөвөөр шийдэхийн тулд бодит үнэнийг тогтоох хуульд нийцсэн үйл ажиллагаа гэж ойлгож болно. Бодит үнэнийг, өнгөрсөн үйл явдлыг хамгийн боломжит байдлаар тогтоож чадах нотлох баримтын тусламжтайгаар сэргээн дүрслэх нь шийдвэр гаргахад туйлын чухал байна.

Үндсэндээ бол нотлох ажиллагааг болж өнгөрсөн гэмт хэргийн талаар танин мэдэх сэтгэхүйнээдрээтэй үйл явц гэж ойлгох нь зүйтэй юм.

Процессын хуулиар нотлох ажиллагааг явуулах эрх бүхий албан тушаалтан гэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч /шүүх/ хэмээн тогтоож өгсөн.

Харин нотлох ажиллагааг 4 үндсэн хэсэгт хувааж өгсөн байна. Гэхдээ ингэж шууд 4 үндсэн хэсэгт зааглаж ялгах нь түүнийг хэрэгжүүлэгчийн хувьд өөр өөрөөр ойлгогдох харьцангуй шинжтэй. Тухайлбал, тухайн хэрэгт ач холбогдолтой нотлох баримт цуглуулж байгаа гэдгийг үнэлэхгүйгээр дүгнэх боломжгүй бөгөөд үнэлэхийн тулд зайлшгүй шалгах шаардлагатай болно. Нотлох баримтыг шалгахын тулд гарцаагүй бэхжүүлэх ёстой.

Дээрх дөрвөн нотлох ажиллагааны үе шатаас гадна өөр үе шат онолын хувьд байх шинжтэй юм. Үүнд "илрүүлэх" буюу нотлох баримтыг цуглуулахын өмнөх шат бол илрүүлэх байх ёстой гэсэн томъёолол юм. Энэ нь нотлох баримтууд бүгд ил байдаггүйтэй холбоотой.

Илрүүлэхийн үгийн утгын авч үзвэл илрэхийн үйлдүүлэхийнхэв, ил болгох, нууцыг илрүүлэх, хэрэг илрүүлэх[2] хэмээсэн байна. Иймээс үгийн утгын хувьд илрүүлэх нь гарцаагүй нотлох ажиллагааны үе шат мөн юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олжт огтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайдтооцохгүй байх явдлыг хангахад оршино" гэж заасан. Процессын хуулийн зорилтод аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж гэж тодотгон заасан нь нотлох ажиллагааны үе шат илрүүлэхээс эхэлнэ гэсэн санааг баталж буй хэрэг мөн.

Аливаа нотлох баримт ямагт үлддэг гэх бөгөөд түүнийг илрүүлэх нь чухал юм. Бүх нотлох баримт ил байдаггүй нь үнэн бөгөөд түүнийг илрүүлэх нь тухайн ажиллагааг явуулж буй ажилтны мэдлэг, туршлага, ур чадвараас зайлшгүй шалтгаална. Өөрөөр хэлбэл зарим гэмт хэрэг үйлдэгдсэн даруйдаа илэрсэн байхад олон жилийн дараа илэрдэг гэмт хэрэг ч байна. Учир нь тухайн гэмт хэргийн ул мөр, нотлох баримтыг хэдий хугацаанд илрүүлснээс л хамаарна. Иймээс нотлох ажиллагааг цуглуулах ажиллагаанаас шууд эхлүүлэх нь хэр тохиромжтой вэ гэдэг асуудал тулгарч байна.

Гэмт хэргийн талаарх нотлох баримтыг илрүүлэх нь тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээд болон бусад нотлогдвол зохих зүйлийн талаар тодорхой болгох, мөн нотлох дараагийн ажиллагааны үндсийг тавина.

Нотлох ажиллагаа бүр өөрийн онцлогтой. Мөн тэдгээрийн нийтлэг шинж нь:

- Процессын хуульд заасан хугацаагаар хязгаарлагдсан
- Хууль цаазын тодорхой шийдвэр гарахад чиглэгдсэн
- Процессын хуулиар эрх олгогдсон албан тушаалтнууд явуулдаг
- Хуульд заасан аргаар явуулдаг зэрэг болно.

Нотлох баримтыг илрүүлэх нь шүүхийн өмнөх шатны буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ихэвчлэн явагдах ба зарим судлаачид нотлох баримтыг цуглуулах ажиллагаа нь – илрүүлэх, - хураан авах гэсэн хоёр үйлдлээс бүрдэнэ[3] гэж тайлбарласан байдаг.

Тэгвэл цуглуулах нь өөрөө бэхжүүлэх ажиллагааны нэг үйлдэл болно. Ийм байдлаараа өөр хоорондоо уялдаа холбоотой шинжээр нь нэгнийх нь үйлдэл болгох юм бол үндсэндээ шууд нотлох ажиллагаа гэж нэрлэж, дотор нь ялган зааглах ач холбогдол нь сулрах юм.

Нотлох баримтыг илрүүлэх

[1] Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002. №6

[2] Монгол хэлний товч тайлбар толь. Я.Цэвэл. УБ.,1966 он

[3] Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ хот.,2003 он

ажиллагаа нь өөрөө олон шинжлэх ухаантай уялдана. Тухайлбал, хүний энгийн мэдрэхүйгээр илрүүлэх боломжгүй зүйлсийг техник хэрэгсэл ашиглан илрүүлэх боломжийг криминалистикийн техник зүйн шинжлэх ухаан олгодог.

Нотлох ажиллагаа нь өөрөө Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гол цөм байдаг. Гэхдээ нотлох ажиллагааг хаанаас нь хэрхэн явуулах вэ гэдэг нь тухайн албан тушаалтны туршлага, арга барил, тухайн гэмт хэргийн криминалистик шинжээс шууд хамаардаг. Учир нь сэжигтэн, яллагдагч нь оргон зайлах боломжтой, гэмт хэрэг үйлдсэн ул мөрөө баллах, зэвсэг хэрэгслээ нуух, мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах зэрэг шинж илэрсэн тохиолдолд хамгийн түрүүнд тухайн сэжигтэн яллагдагчыг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад шаардлагатай нотлох баримтыг илрүүлэх нь чухал.

Илрүүлэх ажиллагааг нотлох ажиллагааны нэг бүрдэл хэсэг мөн гэхээс гадна, хамгийн чухал ажиллагаа гэж ойлгох нь зүйтэй.

Далайн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад гэмт хэргийн нотолгоог явуулахдаа нотлох баримтыг илрүүлж тогтоосны дараа түүнтэй холбогдуулан иргэний эрх, эрх чөлөөнд халдах гэсэн зарчмыг барьж ажилладаг.

Манай улсын тухайд бол Зөвлөлт холбоот улсын үеэс уламжлан ирсэн иргэнийг сэжигтэн, яллагдагчаар тогтоож сэтгэлзүйн хүчтэй нөлөөлөл үзүүлж, өөрсдийнх нь мэдүүлгээр нотлох баримт хийх зарчмыг голлож ирсэн.

Дээрх зарчмын хүрээнд баригдаж нотлох баримтыг илрүүлэх гэдэг ойлголтыг сулруулсан нь одоогийн энэ байцаалтан дээр тулгуурладаг процессын ажиллагааны суурь болсон.

Манай улсын одоо мөрдөгдөж байгаа эрүүгийн процессын хуулиар нотлох ажиллагаа нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг тогтоох, түүнд ял оногдуулахад чиглэгдэж байгаа.

Гэтэл гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлыг барагдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нуугдмал эд хөрөнгө, гэмт хэргийн шууд ба шууд бус хохирогчийн талаар нотлох баримтыг илрүүлэх ажиллагаа дутмаг байгаагаас иргэдийн төрд итгэх итгэл суларч гэмт хэргийн илрүүлэлт, түүнийг нотлох ажиллагаа зохих түвшинд хүрэхгүй болсон.

Нотолгооны онол, эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг судлаачид цуглуулах ажиллагааг илрүүлэх ажиллагаатай нэг ажиллагаа гэж үзсээр ирсэн. Энэ талаар судлаач Б.Галдаа: Нотлох баримтыг цуглуулах /илрүүлэх/[4] гэж үзсэн бол судлаач Б.Ганболд "..нотлох баримт цуглуулах гэдэг нь гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх баримт сэлт, мэдээлэл түүний эх сурвалжийг эрж хайх, олж илрүүлэх.."[5] гэж үзсэн байдаг.

Энэ нь ч аргагүй юм. Учир нь одоогийн мөрдөгдөж байгаа эрүүгийн процессын хуульд дээр дурьдагдсанаар нотлох ажиллагааны 4 үе шат байна гэсэн заалт юм. Судлаач нар үүнд баригдаж байгаа боловч илрүүлэх гэдэг ажиллагаа байгааг хүлээн зөвшөөрсөн байна.

Яагаад илрүүлэх ажиллагаа заавал бие даасан нотлох ажиллагааны нэг үе шат болох ёстой юм бэ гэдэг нь хүний эрхийг хуулиар хөндөхтэй холбоотой асуудал юм.

Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагын бүрэн эрхт гишүүний хувьд НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх ёстой.

Мөн бид уламжлалаа, түүхээ, Монгол хүнээ сайн судлах ёстой. Олон улсын жишиг процессын хуулийг орчуулан хэрэглэх нь дэлхий нийттэй эрх зүйн тэгшитгэлд орох ач холбогдолтой боловч үндэсний аюулгүй байдлын хувьд дотоодын эрх зүйн шүүлтүүртэй байх нь туйлын чухал.

Монгол улсад гэмт хэргийн талаарх нотлох баримтыг илрүүлэх эрх зүйн орчин туйлын ойлгомжгүй, цэвэр мэргэжлийн түвшиний зохицуулалтгүй байсаар байна.

[4] Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал, Б.Галдаа, УБ хот., 2008

[5] Нотолгооны онол, Б.Ганболд, УБ хот.,2007

# МОНГОЛ УЛС БОЛОН ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ЗААСАН ЭД ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ АЖИЛЛАГАА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)



*Г.Жалбуу*
*ОХУ-ын Дотоод хэргийн яамны Омскийн академийн адъюнкт*

Улс орнуудад эрүүгийн хэрэг үүсэх явцад эд хөрөнгө битүүмжлэх өөр өөрийн гэсэн онцлогууд байдаг бөгөөд энэ нь тухайн улсын түүх, улс төр,эдийн засгийн гадаад ба дотоод хүчин зүйл нөхцөлүүдээс хамаарч байдаг. Тэр дундаа хөрш зэргэлдээ орнуудын хувьд бие биедээ улс төр эдийн засаг, соёлын нөлөө үзүүлдэг төдийгүй үндэсний хууль эрх зүйн хөгжилд ч тэр нөлөөлөх нөлөөлөл ихээр ажиглагддаг. Дээрх байдлаар хөрш орнуудын хууль адил төстэй байдаг гэдгийг тайлбарлаж болох юм. Улс орнуудын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны онцлог шинж чанарыг судлах нь Монгол улсад тус институцийг хөгжүүлэхэд хувь нэмэр болох юм. Иймээс газар нутгийн хувьд ОХУ болон БНХАУ-ын дунд, хоёр их гүрнээр хүрээлүүлэн оршиж буй манай улсын хувьд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тухайн улс орнуудын хуультай харьцуулсан дүн шинжилгээ хийх бүрэн боломж бололцоо нээлттэй байдаг нь анхаарал татаж байна.

Монгол улсын хувьд илүүтэйгээр ОХУ-тай түүхэн нөхцөл байдлаар холбогддог. ЗХУ-ын тусламжтайгаар Азийн төвд орших манай улс тусгаар тогтнолоо олж авсан бөгөөд удаан хугацаанд ЗХУ-тай хамтарч хөгжин дэвшсэн түүхтэй. ЗХУ-ын бутрал нь Монгол улсын хувьд олон талт гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх нөгөө талаас Орос-Монголын харилцаа хөндийрөх нөхцөл болсон гэж судлаачид үздэг. Өнөөгийн байдлаар хоёр улс найрсаг харилцаатай оршиж байна. Энэ нь хоёр улсын хуулийн байгууллагууд тэр дундаа эрэн сурвалжлах, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, прокурор, шүүх зэрэг хуулийн байгууллагууд хоорондын туршлага судлах, хамтран ажиллах үндэс нь болж байгаа юм.

Тус нийтлэлд ОХУ болон Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаатай холбогдсон асуудалд судалгаа, харьцуулалт хийлээ. Уг судалгаа нь хөрш орны дээр дурьдсан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ижил төстэй болон ялгаатай талуудыг олж тогтоох, хөгжлийн хандлагыг судлах, харьцуулалт хийж тухайн улсын хууль тогтоомжийн чиг хандлагыг тодорхойлж судлахад оршино.

ОХУ болон Монгол улсад явагдаж байгаа улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүдээс үүдэж эрх зүйн систем тэр дотроо эрүүгийн байцаан шийтгэх системийг өөрчлөн шинэчлэх шаардлага тулгарч байна. Түүнчлэн хүмүүнлэгийн зарчим, хүний эрхийг дээдлэх хэм хэмжээ, хүний эрхийг хамгаалах асуудлыг дэлхийн жишиг стандартад нийцүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны журмын талаар цогц ойлголтыг бий болгох, хоёр улсын хоорондын тэр дундаа нутаг дэвсгэрийн хувьд хил залган оршиж буй улсуудын хооронд эрүүгийн байцаан шийтгэх системийг хэрэглэх өвөрмөц арга замыг боловсруулах шаардлагатай байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаануудаас эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь өөрийн гэсэн онцлогтой, өвөрмөц хэлбэртэй явагддаг ажиллагаа юм. Эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа нь албадан хийгддэг албадлагын шинж чанартай учир түүний мөн чанар, хэрэглэх үндэслэл ОХУ болон Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн аль хэсэгт хамаарагдах талаар хэвлэл мэдээллийн хуудаснаа багагүй хэлэлцүүлэг маргаан өрнөсөн байдаг.

Эд хөрөнгө битүүмжлэх асуудлыг судлахын тулд **“эд юмс, эд хөрөнгө”** гэсэн ойлголтын утгыг зөв ойлгож хэрэглэх нь зүйтэй юм.

Эд юмс-бодит, нүдээр харагдах эд зүйлс бөгөөд хохирогчийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг[1] хэлэх ба түүнд учирсан хохирлыг эд хөрөнгөд учирсан хохирол гэж ойлгож болно.

**“Эд”** гэдэг нь “эдэлж хэрэглэж болох юм эдлэл”, “хөрөнгө” гэдэг нь “хүний хийгээд улс нийгэмд хамаарагдах өмч, үнэ бүхий зүйлийн нийт нэр” хэмээх утгыг Монгол хэлэнд тус тус илэрхийлдэг[2].

Харин **“эд хөрөнгө”** гэдэг нь “эд юм” гэдэгтэй утга нэг агуулгыг илэрхийлэх бөгөөд “юм” гэдэг нь Монгол хэлний аливаа бүх зүйлийг ерөнхийлөн нэрлэх үг юм[3].

Монгол улсын Иргэний хуульд[4] “аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө” гэж тодорхойлсон байдаг.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны ойлголтод

[1] Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дах хэсэг.
[2] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966., 716. 889 дэх тал
[3] Мөн бүтээлийн 289 дэх тал
[4] Монгол улсын Иргэний хуулийн 84 дүгээр зүйл

битүүмжлэгдсэн эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглодог. Өөрөөр хэлбэл худалдах, бэлэглэх, солих мөн бусдад гэрээслэхийг хориглоно. Энэ нь тухайн эд зүйлсийг хууль ёсны эзэмшигчид, түүний төрөл төрөгсдөд болон бусад этгээдүүдэд хүлээлгэн өгч бүрэн бүтэн байлгахыг шаарддаг. Хураагдан авсан болон албадан авсан эд хөрөнгийг харж хандуулан хамгаалалтанд нь өгсөн этгээд хууль бусаар нуун дарагдуулсан, бусдад дамжуулсан, болон үүнтэй адилаар банк санхүүгийн байгууллагуудаар хураагдсан мөнгөн тэмдэгтийг хууль бусаар дамжуулан ашигласных нь төлөө Монгол улсын Эрүүгийн хуулийн 244-р зүйлээр, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 312-р зүйл ангид зааснаар тус тус тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь албадлагын болон урьдчилан сануулах хэрэглүүр болдог бөгөөд уг хэрэглүүрийн гол зорилго нь байцаан шийтгэх ажиллагааны талуудын хууль бус үйлдлийг анхааруулах зорилготой юм[5]. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны зорилго нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол болон гэмт хэргийн шинжтэй эд зүйлийг цаг алдалгүй олж илрүүлж хохирогчийн хохирлыг барагдуулах, улсад оруулах ёстой орлогыг тодорхойлоход мөн оршино.

Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн яллагдагчийн хувьд сайн дурын шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл энэ шатанд түүний хувьд гэм буруутай нь нотлогдоогүй тул хэрвээ сэжигтэн, яллагдагч гэм буруугаа ухамсарласан болон хохирогчийг энэрч өрөвдсөн сэтгэлээр өөрөө сайн дураараа хохирол төлж болдог[6].

ОХУ-д "Иргэн бүр эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, тэдгээрийг захиран зарцуулах эрхтэй[7]" гэж хуульчлан зааж өгсөн байдаг бол Монгол улсын хувьд "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө[8]" гэж заасан байдгаас харахад уг эрхийг шүүхийн шийдвэр болон бусад хууль тогтоомжийн дагуу хязгаарлаж болохыг тусгайлан хуульчлан зааж өгсөн.

2014 оны ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг албадлагын арга хэмжээ болгон хуульчлан тогтоосон[9]. Энэхүү ажиллагаа нь сэжигтэн яллагдагчийн Үндсэн хуулийн дээр дурдсан эрхийг нь хязгаарладаг. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг албадан хийхээр заасан байдаг бол Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой ажиллагаанд тусгаж өгсөн байна.

2002 оны Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134-р зүйлд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг Эрүүгийн процессын тодорхой ажиллагаа болгон хуульчилсан. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг ерөнхийд нь зохицуулсан боловч эд хөрөнгө битүүмжлэх үндэслэл, түүний үнэлгээг тогтоох журам, эд хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэрийг гүйцэтгэх, битүүмжлэгдсэн эд хөрөнгийг хадгалах болон чөлөөлөх, ямар ямар эд хөрөнгийг битүүмжилж болох талаарх процессын ажиллагааг нарийвчлан тусгаагүй.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг ашиглахгүйгээр эд хөрөнгийн нэхэмжлэлийг хангах болон эд хөрөнгийг хураах шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй. Өнөө үед шүүх хурал болохоос өмнө байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт явдлаар учирсан эд материалын болон сэтгэл санааны хохирлыг арилгахад авч болох цорын ганц арга хэмжээ нь энэ юм. Учирсан хохирлыг улсаас нөхөн төлүүлэхийг хангах болон гэмт хэргээс хохирогчийн эрхийг хуулиар хамгаалах тухай ОХУ-ын Үндсэн хуулийн 52-р зүйлд заасан хэм хэмжээг биелүүлэх нь эд хөрөнгө битүүмжлэх замаар хэрэгждэг. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн 104-р зүйлийн 104.1 дэх хэсэг болон 104-р зүйлийн 104.2 дах хэсэгт заасан эд хөрөнгө хураах мөн тус улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 73-р зүйлийн 73.1-ээс 8 дах хэсэгт заасан заавал тогтоох ёстой нөхцөл байдлуудын жагсаалтанд орсон байдаг. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйлд заасан эд хөрөнгө битүүмжлэх заалт нь шүүхийн журам болон эзэмшигчийн эд хөрөнгийг хамгаалах тухай тус улсын Үндсэн хуулийн заалттай нийцдэг. Дээрх ажиллагааг явуулах үндэслэл нь тодорхой зүйлээс шалтгаалдаг. Үүнд: Эд зүйл нуун дарагдуулах, хөдлөх хөрөнгийг зарахаар зарлал тараасан, нэхэмжлэлийн дагуу хохирлыг сайн дураараа барагдуулахаас зайлсхийсэн болон татгалзсан, дуудсан цагт ирэхээс зайлсхийсэн болон бодит үнэнийг тодруулахад саад болсон зэрэг асуудлуудаас үүсдэг. Гэвч практикт энэхүү үндэслэл нь тодорхой биш мөн хэрэгждэггүй. Зөвхөн шүүхийн шийдвэрийн дагуу гаргадаг.

Монгол улсын хувьд "Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хураах болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний төлөө эд материалын хариуцлага хүлээвэл зохих хүмүүсийн

[5] Прасковьин Д.А. Обеспечение гражданского иска: правовая природа и система средств.
М., 2006. 112 с.
[6] Мөн бүтээлийн 30 дах тал
[7] ОХУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт
[8] Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дах заалт
[9] ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйл., 2014., 79-80 дах тал

эд хөрөнгийг битүүмжлэх үүрэгтэй"[10] мөн "эд хөрөнгө битүүмжлэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулна"[11] гэж заасан байдаг бол ОХУ-д эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь зөвхөн шүүхийн шийдвэрээр явагддаг бөгөөд "хэн ч өөрийн эд хөрөнгөө шүүхийн шийдвэргүйгээр хязгаарлуулахгүй, хасуулахгүй байх эрхтэй"[12] гэж хуульчилан зааж өгсөн.

Үүнээс үзэхэд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл нь Монгол улсад прокурорын зөвшөөрлөөр харин ОХУ-д шүүхийн шийдвэрээр хийгддэгээрээ ялгаатай.

**Эд хөрөнгө битүүмжлэх үндэслэл:**

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны үндэслэл нь баримтат мэдээлэл дээр тулгуурладаг. Энэ нь тодорхой этгээд гэмт хэрэг үйлдсэн тухай, уг гэмт хэргийн улмаас хохирол учирсан тухай, хохирлоо барагдуулахын тулд иргэний нэхэмжлэл гаргасан, заавал хураан авч улсын орлого болгохоор заасан ял шийтгэлтэй гэмт хэрэг байх тухай асуудал байдаг. Эсхүл бусад нэхэмжлэл гаргуулж авахаар шаардсан болон гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгө, эд зүйлсийг хураалгуулахаар цагдаагийн байгууллагад хандсаныг дээрх баримтат мэдээлэл гэдэгт хамруулж ойлгож болно.

Эд хөрөнгө битүүмжлэхэд тодорхой эрүүгийн хэрэгт хамааралтай нотлох баримт шаардагдах бөгөөд эдийн болон сэтгэл санааны хохирол нь тухайн ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл юм[13]. Мөн нэхэмжлэгч цагдаа, прокурор, шүүхэд тухайн хохирлыг барагдуулахыг хүссэн нэхэмжлэлтэйгээр хандана.

[10] Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1 дэх заалт

[11]Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3дэхзаалт

[12] ОХУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дах заалт

[13] Аршба Г.В., Гирько С.И., Николюк В.В. Наложение ареста на имущество: учеб.-практ.
пособие. М., 2004. 89 с.

Үүнээс гадна сэжигтэн, яллагдагч нь эд хөрөнгийг нуун далдлах, хаяж гээх, бусдад дамжуулах, зарж борлуулж болзошгүй нөхцөл байдал илэрвэл эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хийх шаардлагатай үндэслэл бий болох юм. Тухайн үндэслэл нь эрүүгийн хэргийн нотлох баримтан дээр тулгуурлана. (Жишээнь: эд хөрөнгийг нуух гэж оролдох, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах зар өгөх, дуудсан цагт хүрэлцэн ирэхгүй байх, өөрийн хүслээр хохирлыг төлж барагдуулахаас зайлсхийх болон бусад). Эдгээр үндэслэлүүд нь ОХУ-ын Үндсэн хуулийн цэцийн гаргасан тайлбарт тодорхой заагдсан байдаг.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэгт авдаг дэлгэрсэн үр ашигтай арга хэмжээ юм. Эд хөрөнгө битүүмжлэх үндэслэлийг дараах байдлаар авч үзэж болох юм.

Үүнд:

- Иргэн иргэний нэхэмжлэл гаргах. Энэ нь уг хүн өөрөө эсвэл хуулийн этгээд нь тухайн хүнд биеийн болон эд хөрөнгийн, сэтгэл санааны хохирол учруулсантай холбоотойгоор гаргана. Иргэний нэхэмжлэлд гэмт хэргийн хамтран оролцогчид ижил хариуцлага хүлээнэ. Тиймээс нэхэмжлэлийг хангахад гэмт хэргийн хамтран оролцогчдын эд хөрөнгийг нэхэмжилсэн эд хөрөнгийн нийт үнэлгээнээс хэтрүүлэхгүйгээр битүүмжилж болно.

-Эрүүгийн хэргийн бусад эд хөрөнгийн нэхэмжлэл гаргах. Үүнд процессын болон шүүхийн зардал хамаарна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлээгүйх нь төлөө шүүхээр мөнгөн нэхэмжлэл гаргуулах болон мөнгөн торгууль оногдуулах зэрэгт.

- Монгол улсын Эрүүгийн хуулийн 49-р зүйл болон ОХУ-ын Эрүүгийн хуулийн 104-р зүйл 104.1 дэх хэсэгт заасан эд зүйл нь сэжигтэн яллагдагч болон бусад этгээдэд шилжсэн байгаа нь битүүмжилж хураан авах шаардлагатай хуульд заасан үндэслэл байвал. Тухайлбал Монгол улс болон ОХУ-ын эрүүгийн хуульд тусгайлан заасан гэмт хэргийг үйлдэн олж авсан эд зүйлс болон мөнгөн тэмдэгтийг хураан авч бэхжүүлэх хууль ёсны эзэмшигчид нь эргүүлэн өгөх ёстой.

Хоёр улсын практикт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар эрүүгийн хэргийг мөрдөн шалгахдаа эрүүгийн хэргийн нотлох баримт болон сэжигтэн, яллагдагчийг илрүүлэхэд гол анхаарал, хүчээ хандуулж ажилладагаас болж иргэний нэхэмжлэл, шүүхийн шийдвэрийг хангах, хохирогчийн хохирол барагдуулах асуудал орхигддог. Монгол улсын Эрүүгийн хуулийн 49-р зүйл болон ОХУ-ын Эрүүгийн хуулийн 104-р зүйлийн 104.1 дэх хэсэгт заасан хураагдах ёстой эд хөрөнгө, иргэний нэхэмжлэл болон бусад эд хөрөнгийн нэхэмжлэл дэх шүүхийн шийдвэрийг хангах битүүмжлэн хураан авах ёстой эд хөрөнгө мөн өөрийн ажиллаж байгаа эрүүгийн хэргийн эрэн сурвалжлагдаж байгаа эд хөрөнгө зэрэг дээр уг ажиллагааг хугацаа алдалгүй авч байх шаардлагатай юм.

Судлаач миний бие 2014 онд ОХУ, Монгол Улсын нийт 120 мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нараас санал асуулга авсан ба оролцогчдын 95% нь хариулахдаа эхлээд сэжигтэн яллагдагчийн гэм бурууг нотлосон нотлох баримтийг олж авахад анхаарах ёстой ба дараа нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны төгсгөлд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хийх хэрэгтэй гэж хариулжээ. Мөн эд хөрөнгийг илрүүлэх, битүүмжлэхэд төдийлөн анхаарахгүй байгаа нь тухайн хэрэгт холбоотой этгээд нь мөрдөн байцаах байгууллагаас эд хөрөнгөө ямар нэгэн аргаар нуух, зарах эрсдэлийг бии болгож байгааг анхаарах хэрэгтэй.

Мөн судалгаанд оролцогчдын 64.6 хувь нь иргэний нэхэмжлэл гаргаагүй байхад эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийдэггүй гэж хариулсан нь зөвхөн иргэний нэхэмжлэлийг хангахын тулд уг

ажиллагааг хийж байгааг харж болно. Мөн 95 хувь нь хүний оюуны өмчийг битүүмжилж байгаагүй гэсэн бол эрүүгийн хэргийг түтгэлзүүлсэн тохиолдолд эд хөрөнгийг битүүмжлэх тогтоол хүчингүй болох уу? гэсэн асуултанд оролцогчидын 72 хувь нь тогтоол хүчингүй болно гэж хариулсан нь дээрх ажиллагааны тогтоолыг ямар үндэслэлээр хүчингүй болгох асуудлыг хуульд тодорхой заагаагүйг харуулсан юм.

Хэрэг бүртгэх албаны 2002-2006 онд битүүмжилсэн хөрөнгийн хэмжээг гэмт хэргийн улмаас учирсан хохиролын хэмжээтэй харьцуулахад жилд дунджаар 2.7%, нөхөн төлүүлсэн хохиролын хэмжээтэй харьцуулахад 3.2%-тай тэнцэхүйц хэмжээний хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна[14].

Үүнээс харахад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагааны явцад иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах ажиллагаанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хариуцлагагүй ханддаг буюу эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа маш хангалтгүй түвшинд хийгддэг. Өнөөгийн практикт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг цаг алдахгүй, хангалттай сайн хийж гүйцэтгэхгүй ихэвчлэн хохирол ихтэй, онц дуулиантай хэргүүдэд хийж байгаа нь нууц биш юм.

Түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг тухай бүрд нь тогтоохгүй орхих, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын болон иргэний хариуцагчийн хөрөнгийг олж илрүүлэн, шаардлагатай үед цаг алдалгүй битүүмжлэн, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авахгүй байх зөрчлүүд байсаар байна[15].

Тухайн цаг үед хэрэгт холбогдох эд хөрөнгийг битүүмжлээгүйгээс шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй, хохирогчийн хохирол барагдуулах асуудлыг улсаас хангах хуулийн заалт биелэгдэхэд хүндрэлтэй болдог. Дээрх асуудлаар хүний эрхийг хангах Европын шүүх нь нэг бус удаа сануулга өгч байсан[16].

Иймээс Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйл болон Оросын холбооны улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115-р зүйлийг судлаад дараах дүгнэлтэнд хүрч байна.

Сэжигтэн яллагдагчийн эд хөрөнгө битүүмжлэх процессын ажиллагаанд албадлагын арга хэмжээ ашиглах эрх зүйн дүрэм журам нь хоёр улсын хууль эрх зүйд адил төсөөтэй байна. ОХУ-ын хувьд Мөрдөн байцаах ажиллагаа хийгдэж эхлэх үеэс эхлэн эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа давхар хийгдээд явдаг бол Монгол улсад заавал эрүүгийн хэрэг үүссэний дараа хийгдэж байгаа нь эргээд сэжигтэн, яллагдагчид хууль бусаар олж авсан эд хөрөнгөө нуун далдлах, бусдад дамжуулах, хохирол барагдуулахад шаардагдах эд зүйлсийг зарж борлуулах боломж олгож байна. Энэ нь дээрх сэдвийг гүнзгийрүүлэн судалж эрүүгийн байцаан шийтгэх хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгааг харуулж байгаа юм. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хугацаа алдахгүй хийх нь шүүхийн шийдвэрийг хангах, хохирол барагдуулах, улсад оруулах ёстой орлогыг бий болгоход маш чухал ач холбогдолтой зүйл билээ.

Монгол улсад эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр зөвхөн прокурорын зөвшөөрөлтэй хийгддэг. Үүнээс харахад Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дах хэсэг нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дах хэсэгт заасан иргэний эд хөрөнгө эзэмших өмчлөх эрхийг ноцтой зөрчиж байна.

ОХУ-ын Эрүүгийн процессын шинжлэх ухааны судлаачдын явуулсан судалгааны үр дүнг харвал эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны үндсэн агуулга болох тухайн процессын ажиллагааны дүрэм, журам түүнийг биелүүлэх эрх зүйн хэм хэмжээ, эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хэрэглэх дотоод дүрэм нь адил төсөөтэй байна. Иймд хоёр орны хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой ажиллагаа болох сэжигтэн яллагдагчийн эд хөрөнгийг битүүмжлэх процессын ажиллагааны эрх зүйн тогтолцоог улам боловсронгуй болгоход чиглэгдсэн иж бүрэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаадлагатай.

Мөн тухайн асуудлыг онолын талаас хангалттай боловсруулаагүйгээс гэмт хэрэгт шүүн таслах ажиллагааны зорилтыг хангах явцад хуульд заасан иргэний эрх, эрх ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах талаар хуульд тодорхой тусгаагүй байгаа нь энэ талаар нарийвлан судалгааг явуулах шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын өгсөн саналыг нэгтгэн үзүүлбэл, Эрүүгийн хэрэг шүүхээр орж шийдэгдтэл ямар нэг хэрэг дээр эд хөрөнгө битүүмжлэхажлыг хойшлуулшгүй хийдэг байх. Дээрх ажиллагаанд прокурор, их хэмжээний хохиролтой хэрэгт шүүгч болон түүний туслахыг оролцуулан тус тусдаа тэмдэглэл хөтлөх. Эд хөрөнгө битүүмжлэн хариуцуулах этгээд, тусгай байгууллага байлгах шаардлагатай байдаг. Үнэлгээг тогтоох шинжилгээний байгууллагыг төрөлжүүлж, мэргэшүүлэх нь маш чухал ач холбогдолтой.

Хувийн үнэлгээний байгууллагаар эд хөрөнгө битүүмжлэхэд мөнгө авдаг. Одоо хүртэл залилангийн хэрэг дээр шинжээчийн дүгнэлтээ авч чадаагүй байна. Энэ асуудлыг шийдүүлэх.

Битүүмжилсэн хөрөнгө хадгалагдах явцад үнэлгээ багасаж

[14] Гэмт хэргийн улмаас учирсан хохирол “Сургалтын гарын авлага” УБ., 2008. 114 дэх тал

[15] Гэмт хэргийн улмаас учирсан хохирол “Сургалтын гарын авлага” УБ., 2008. 31 дэх тал

[16] Шейфер С.А. Следственныедействия. Основания, процессуальныйпорядокидока зательственноезначение.М.,2004. С. 22.

ихсэх дохиолдол их гардаг. Үүнийг хохирол барагдуулахад бодитой тооцох буюу дахин үнэлэх ажиллагаа эрх зүйн орчин дутмаг байдаг. Битүүмжлэгдсэн хөрөнгийг хаана байршуулах, хадгалалт хамгаалалтын асуудлыг боловсронгуй болгох. Тодорхой зааж өгсөн улсын нэгдсэн байгууллагатай болох.

Эд хөрөнгийн маргааны шинж чанартай эрүүгийн бүх хэргүүдэд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хийх шаардлагатай. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны талаар хуулинд нэмэлт хийж боловсронгуй болгох шаарлага байгаа. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны үндэслэл тодорхой бус байна. Хуульд маш тодорхой болгох. Эд хөрөнөгө битүүмжлэх ажиллагааны асуудал нь хуульд дутагдалтай, ойлгомжгүй байдлаар туссан нь дээрх таслан сэргийлэх тодорхой арга хэмжээг практикт хэрэглэхэд хүндрэлтэй байдагаас төдийлөн хийгээд байдаггүй. Тиймээс эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хийж битүүмжилсэн эд хөрөнгөө хаана ямар журмаар хадгалах, хамгаалах асуудлыг тодорхой болгох. Битүүмжилсэн эд хөрөнгийн үнэлгээг хаана ямар байгууллагаар хийлгэх асуудал нь хуульд тодорхой биш. Үнэлгээний хувийн байгууллагуудаар эд хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн тохиолдолд түүний зардлыг хаанаас гаргах нь тодорхойгүй үүнийг тодорхой болгох шаардлагатай.

Ном зүй:

**Нэг. Хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992-2009 он
2. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002 он
3. Монгол Улсын Иргэний хууль 2012 он
4. Монгол улсын хууль. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2010 он.
5. ОХУ-ын Үндсэн хууль. 2014 он
6. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2014 он
7. ОХУ-ын Иргэний хууль 2014 он

**Хоёр. Ном бүтээл**

1. Төрийн мэдээлэл. Улаанбаатар хот. 2002 он. №6
2. Б.Т. Безлепкин “ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар”2012 он
3. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг, хууль зүйн үндэсний төв “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол” сургалтын гарын авлага. УБ хот, 2008 он
4. Шейфер С.А. Следственные действия. Основания, процессуальный порядок и доказательственное значение. . М., 2004 г.
5. Аршба Г.В., Гирько С.И., Николюк В.В. Наложение ареста на имущество: учеб.-практ. пособие. М., 2004 г.
6. Прасковьин Д.А. Обеспечение гражданского иска: правовая природа и система средств.М., 2006 г.
7. Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он.

# КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

## ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХЭД БИЧИЛ МӨРНИЙ ШИНЖИЛГЭЭ, ФИЗИК- ХИМИЙН СПЕКТР АНАЛИЗЫН АРГУУД

*Х.Түвшин-Эрдэнэ: ШШҮХ-н Тусгай шинжилгээний хэлтсийн физикийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, цагдаагийн хошууч*

**Гэмт хэрэгтэй тэмцэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын үүрэг**

Монгол Улсын төр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн ардчилсан нийгмийн эрх зүйн үндсийг цаашид боловсронгуй болгох зорилгоор 2012 оноос эрх зүйн шинэчлэлийн дараагийн давалгааг эхлүүлэн шүүх, шүүхийн тогтолцоо, гэмт хэрэгтэй тэмцэх ба хууль сахиулах тогтолцоо, захиргааны үйл ажиллагаанд хүний эрхийн баталгаа ба хууль дээдлэх ёсыг гүнзгийрүүлэх чиглэлд өргөн хүрээний шинэчлэлийг өрнүүлж байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Шүүхийн шинжилгээний лабораториудыг шинэчлэх ажил идэвхтэй явагдаж шинжлэх ухааны үндэслэлтэй шинжилгээний дүгнэлт гаргах, өндөр мэдрэмжит багаж технологиудаар шинчлэх ажил хийж байна.

ШШТХ-ийн **4 дүгээр зүйлд** хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хараат бус байх,.шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийнэ гэж гол зарчмуудыг тусгасан байдаг.

ШШҮХ-ийн Тусгай шинжилгээний хэлтэснь 2013 оны статистик мэдээгээр 9635 шинжилгээ хийсэн бөгөөд үүнийг төрөл чиглэлээр нь авч үзвэл хими, биологийн шинжилгээ зонхилох хувийг эзэлж байна.

2012-2014 оны хугацаанд химийн лабораторид хар тамхи, мансууруулах бодис тогтоох хийн хроматограф-масс спектрометр / VARIAN GS-MS / багажыг энэ жил авахаар гэрээ хийгдсэн бол физикийн лаборатори **DoseRAE2 цацраг хэмжигч** багаж ашиглах болсноор рентген спектрометрийн ашиглалт, хамгаалалт, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, цацрагтай ажиллагч шинжээчдийн хэр хэмжээний тун авч байгааг тогтоох боломжтой болсон бол физикийн лабораторит хэт ягаан туяаны спектрометрийг шинжилгээнд ашиглахаар бэлтгэл ажиллуудыг хийж байна.

Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засаг өсөлт буурч хүндхэн байгаа гэсэн хамтын ажиллагааны гадаа, дотоод байгууллагын санхүүжилтээр х/ч Х.Түвшин-Эрдэнийг “Цөмийн шинжилгээ зүйн чиглэлээр” Тайланд улсын Бангкок хотод, химийн шинжээч а/х Золзаяаг “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг илрүүлэх хийн хроматографи болон масс-спектрометрийн судалгааны чиглэлээр”Португаль улсын Мадейра аралд зохион байгуулагдсан Олон улсын хор судлаачдын холбооны 51 дүгээр тайлан уулзалторолцжээ.

Цаашид нарийн мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэн шинжээчдийг богино болон урт хугацаанд мэргэшүүлэх, магистер, докторын сургалтанд гадаад өндөр хөгжилтэй оронд сургах шаардлага үүсч байна.

Лабораторийн шинжилгээ судалгааны ажлын цар хүрээ, үр дүн, чанар, найдвар, үнэмшлийг сайжруулахад цөмийн технологийн ашигласан болон цөмийн технологийн бус орчин үеийн өндөр мэдрэмжит багажит шинжилгээний аргыг өргөн нэвтрүүлэх, ялангуяа одоо ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн сайжруулах, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх хэрэгцээ шаардлага улам өсөн нэмэгдэж байна.

**Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа**

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт”, “шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх” тусгаснаар хууль сахиулах байгууллагуудын хүрээнд хамтын ажиллагааны нягт харилцан хамааралтай зохион байгууллалттай ажиллах хэрэгтэй юм.

Аливаа улсын хууль зүйншинэчлэл нь олон улсын сайн туршлагыг судлан нутагшуулах замаар хийгдэж болох тухай манай улсын эрдэмтэд, хуульчдын судалгааны ажлаас судлаж үзэхэд тодорхой туссан байна.

Монгол Улсад ийнхүү өрнөж буй шинэчлэлийг гадны олон улсын туршлагыг харьцуулан судлаж үзэхэд илүүдэхгүй бөлгөө.

Шүүх, прокурорын байгууллагын хамтын ажиллагаа- Гэмт хэрэг илрүүлэхэд шинжээчийн дүгнэлтэнд шинжлэх ухааны үндэслэл байгаа эсэх хууль зүй үндэслэл байгаа эсэх талаар өөрийн анализ дүгнэлт гаргаж нотлох баримт хүрээнд шинжлэн судлах ГХТГ, Мөрдөн байцаах байгууллагын хамтын ажиллагаа – шүүх химИ, физикийн шинжээчид хамтран ажиллаж гэмт хэрэг илрүүлэхэд нотлох баримтыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэхжүүлэн, шинжилгээний процесс, шинжилгээний шинлэг арга замыг эрэлхийлэх, шинжээчийн хараат бус, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, шинжлэх ухааны үндэслэлттэй дүгнэлтэнд хүргэх боломжоор хангахад ёс зүйн хэм хэмжээг баримтлан хамтран ажиллах

ХСИС-ийн хамтын ажиллагаа - Шинжлэх ухаан, технологийн олон улсын хөгжлийн хандлага, төрийн бодлогын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, технологи дамжуулах, нутагшуулах, үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлого боловсруулах

Дотоод, гадаадын эрдэм шинжилгээ, сургалт-үйлдвэрлэлийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтарсан судалгаа хийх, үйлдвэрлэлд

технологи нэвтрүүлэх

Гадаад орны сургууль, олон улсын байгууллагуудын хамтарсан төсөл хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, техник, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохиох байгуулах

Суурь шинжлэх ухаан болох хими, физик, биологийн шинжлэх ухааны хичээлийн багц цагийг шинжээч, болон хууль сахиулах их сургуулийн сонсогчидод оруулах

**Тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд**

***1. Хэсэг. Бичил нотлох баримтын онлын тухай***

Гэмт хэрэг илрүүлэхэд өнөөдөр тулгамдаж байгаа бичил объектын /үс, шил, утасны ширхэг, барилгын материал, хөрс, шороо, биологийн эд эрхтэн, будаг, бусад үл мэдэгдэх бодис/ тогтоох шинжилгээ буюу гэмт хэргийн нотлох баримт болох бичил нотлох баримтын ерөнхий онлын ойлголтыг авч үзье.

***1.1 Биет нотлох баримтын концепци***

Шүүхийн шинжилгээний зарчим нь гэмт хэргийн үйлдэл, эсвэл ерөнхийдөө хүний санаачилсан үйл явдал нь өөрөө мэдээ баримтыг бий болгож байдаг. Энэ мэдээ баримт нь бүрэн бус боловч хүний ул мөр байдаг ба үйл явдлууд үйл хөдөлгөөнд суурилсан байх ба үр дүнд нь байгаль орчныг өөрчилдөг. Эдгээр өөрчлөлтүүд нь байгалийн хуулийг дагах хандлагатай болно. Үүний тулд тэд шинжлэх ухаанч байдлаар судлах болдог. Обектууд шилжсэн, эвдэрсэн, тэмдэг гарсан бөгөөд материалууд өөрчлөгдсөн, дамжигдсан байж болно.

Л.Паул Кирк-ийн 1953 онд хэвлэгдсэн "Гэмт хэргийн мөрдөн шинжилгээ" гарын авлагат биет нотлох баримтын талаар дурдахдаа: Хаагуур алхсан, хаана хүрсэн, хаашаа явсан ч санамсаргүйгээр чимээгүй нотлох баримт түүний эсрэг үйлчилж байдаг. Зөвхөн түүний хурууны хээ эсвэл хөлийн мөр биш түүний үс, хувцасны утас, хагарсан шил, түүний үлдээсэн тэмдэгүүд, шалбахай, цус болон үрийн шингэн энэ бүгд нь түүнийг хэлгүй гэрчилэх болно. Эдгээр нь нотлох баримт болохыг мартаж болохгүй. Тухайн агшины сэтгэл хөдлөлд автаж будилуулж болохгүй. Энэ нь хүний гэрч байдаг учраас оргүй биш. Энэ бол бодит нотлох баримт юм. Биет нотлох баримт нь буруу байх боломжгүй, худал мэдүүлэх аргагүй, бүгд оргүй байх боломжгүй. Зөвхөн тайлбар-боловсруулалт нь алдаатай байж болно. Зөвхөн судалж, ойлгохдоо буруу ойлгож үнэ цэнийг бууруулж болно.

Бичил мөр нэр томьёог тодорхойлоход, хязгаар тогтооход хүндрэлтэй байдаг. Зарим үед энэ нэр томьёоны баталгаажилт болон тогтсон хэрэглээ нь тохиромжгүй байдаг. Гэвч бүрэн утга төгс, тохирсон олон хувилбарт нэр томьёонд хүрэхэд хүндрэлтэй байдаг. Тэс өөр хоёр ухагдахуун бичил мөрний концепцид түлхүүр утга болдог. Нэг ухагдахуун нь хэмжээтэй холбоотой. Материалын жижиг хэмжээ нь бичил гэсэн үгэнд хамаарах бөгөөд шүүхийн шинжилгээ, судалгааны нотлох баримт нь ихэвчлэн жижиг хэмжээтэй байдаг. Иймд бичил ухагдахуун нь тохиоромжтой юм шиг гэвч хэмжээ бол тодорхойлогч шинж чанар биш юм.

Нэг тохиолдол дээр харьцангуй том хэмжээтэй материал бичил нотлох баримт болох боломжтой. Мөн бичил гэдэг үг нь мөн ул мөр, нэгэн зүйл алга болсоны дараа үлдэх ул мөр гэсэн утгыг илэрхийлж болно. Тэр ор мөргүй алга болсон байна гэдэг шиг. Энэ нь бичил нотлох баримтын бусад цар хүрээтэй илүү дөхөж очих бөгөөд материалын солилцоо эсвэл хэв загварын үйлдвэрлэл эсвэл хоёулангаас нь үүсэх харилцан нөлөөллийн төсөөллийг агуулсан байдаг. Энэ асуудал нь нотлох баримтыг шилжүүлэх гэсэн нэр томёонд тусгагдсан. Бичил нотлох баримт нь өргөн уудам хүрээг хамарсан байдаг боловч бүх биет нотлох баримт нь бичил нотлох баримт биш нь тодорхой юм. Док.Кирк-ийн иш татсанаас дээр бичигдсэн болон цаашид илэрхийлсэнээр биет нотлох баримт нь юу ч байж болно. Бичил нотлох баримтын салбар нь ямар нэгэн зүйлийг арай явцуу авч үзнэ.

Товчхондоо хэлэхэд бичил нотлох баримт нь хэргийн газарт үлдээсэн шинж тэмдэг болон шилжиж буй материалын үр дүн юм. Тэдгээр нь үйл явдлыг дахин сэргээх болон боломжит уялдаа холбоог үнэлэхэд хэрэглэгддэг.

Логикийн хуулиар цус болон шингэн толбо зэрэг бие физиологийн нотлох баримтууд нь бас бичил нотлох баримт болдог. Гэвч хэвийн үед бичил нотлох баримтыг лавлан хэлэлцдэггүй, учир нь энэ асуудал нь бусад эх үүсвэрүүдэд тусгайлан нарийвчлан боловсруулсан байна. Ерөнхий төсөөллөөр бол толбо зэргийг бичил нотлох баримтын ангилалд авч үзэх хэрэгтэй байдаг. Физиологийн эдгээр толбо нь зөвхөн нийтлэг практикт ордог болохоор их өөр бөгөөд бие даасан, тэдгээрийн шинж чанарыг тогтооход шинжилгээний тоног төхөөрөмж ашигладаг.

***1.2 Бичил нотлох баримтын хэрэглээ***

Шүүхийн шинжилгээнд бичил нотлох баримт нь 3 өөр хэлбэрээр хэрэглэгддэг.

Үүнд: мөрдөн байцаалтын хэрэгсэл байдлаар, ассоциатив нотлох баримт байдлаар, хэрэг явдлыг дахин сэргээх байдлаар хэрэглэгддэг. Эдгээр хэрэглээний хамгийн бага хэрэглэгддэг нь бичил нотлох баримтын эрт шат дахь судалгааг чиглэлийн дагуу үнэлэхэд ашиглах явдал юм. Энэ нь мөн тагнуулын үйл ажиллагааг хамарна.

**Мөрдөн байцаалтын хэрэгсэл**

Бичил нотлох баримтын чадварлаг шинжилгээ болон мэдлэгтэй тайлбар-боловсруулалт нь угаасаа мөрдөн байцаалтанд илүү хэрэгтэй мэдээлэл өгөхөд өндөр боломжийг олгодог. Энэ боломж нь янз бүрийн шалтааны улмаас практикт ховорхон тохиолддог. Эдгээрээс зарчмын хувьд бичил нотлох баримтын шинжилгээ болон тайлбар-боловсруулалтад мэргэшсэн шинжээчид ховор мөн ихэнхи шүүх ажиллагааны явцад шинжээчдийн оролцоо бага байдаг. Бичил нотлох баримтын тайлбар-боловсруулалтаар бий болсон мөрдөн байцаалтын хэрэгсэл эсвэл тангуулын үйл ажиллагааны жишээ загвар нь газарзүйн байрлалыг тогтоох, материалын гарал үүслийг тодорхойлох, материалын үйлдвэрлэгдсэн өдрийг тогтоох, сэжигтнийг устгах

мэдээллээр хангах, сэжиглэгдэх буй хүмүүсийн тоог хязгаарлах болон сэжигтнийг мөрдөхөд дөхөм болох зэргийг хамжуулсан байж болно.

**Ассоциатив нотлох баримт**

Бичил нотлох баримтын одоогийн практикт ихэнхдээ ассиоциатив нотлох баримт хэлбэрээр хэрэглэгддэг. Энэ тохиолдолд энэ нь гэмт хэргийн газар болон хувь хүн хоорондын холбоо, эсвэл хүмүүсийн хоорондын холбоог мөрдөн шалгахад хэрэглэгддэг. Иймээ хөндлөнгийн шүүгчид үнэтэй мэдээлэл өгдөг.

***1.3 Хэрэг явдлыг дахин сэргээх,***

Трэйс нотлох баримт нь хэрэг болсон газар хэрхэн үйл явдал өрнөсөнийг ухаж ойлгоход мэдээлэл өгдөг. Энэ нь автын ослын мөрдөн шинжилгээнд нийтлэг гарч ирдэг нөхцөл байдлаар харагддаг. Авто хэрэгсэл, хэргийн газар, хохирогч, авто машины будгийн үлдэгдэл зэргийн уялдаа холбоог мөрдөхдөө хэргийн газарт геометрийн дэлгэрэнгүй мэдээллийг судалж гаргана. Авто хэрэгслийн цаана трэйс нотлох баримтын олон жишээ хэрэг явдлыг дахин сэргээхэд ашиглагддаг.

**Хууль зүйн нотлох хэрэгсэл**

Бичил мөр нь биет нотлох баримтын маш өргөн хүрээний ангилалд хамаарна. Ямар ч материал биет нотлох баримт болох боломжтой юм. Энэ нэр томьёо нь хуулийн болон шинжлэх ухааны хоёр талын утгыг агуулдаг. Хуулийн нөхцөл байдалд бодит обектыг хамруулдаг. Үүнийг шүүхэд авч ирэх бөгөөд албан ёсоор эд мөрийн баримт байдлаар нотлох баримт болдог бол бичил мөр нь шинжлэх ухааны талаас биет нотлох баримтыг бүрдүүлэхэд хуулийн хэрэгжилтийн явц дахь нотлох баримтад оруулах шаардлагагүй.

Гэмт хэргийн газрыг судлаж, тус газраас ирсэн ямар нэгэн обект болон материал (хохирогч болон сэжигтэн) нь мөрдөх ажиллагааг тодруулж өгөх талтай бөгөөд шинжээчдийн таамаглалаар биет нотлох баримт болно. Мөрдөн байцаалтын явцад тэдгээр нь хэрэгт ач холбогдолтой болох нь мэдэгдмэгц биет нотлох баримт болно. Нотлох баримтыг таньж мэдэх процесс нь илүү комплекс, хүч сорьсон үйл явдал бөгөөд энэ процессыг чухал хэсэг гэж авч үздэг. Энэ нь нилээд их шинжлэх ухааны мэдлэг чадвар, туршлагыг шаарддаг. Бичил мөрийг илрүүлж нотлох баримтанд тооцоход гэмт хэргийн газар болон лабораторид ажиллах мөрдөн байцаагч, шинжээчдийн маш нарийн нямбай ажиллагаа шаарддаг.

**2. Хэсэг. Бичил нотлох баримтыг илрүүлэх, шинжилгээ хийх техник хэрэгслийн тухай**

2.1 Гэмт хэргийн газраас бичил мөрийг илрүүлэх хэргийн газарт ашиглагдах техник хэрэгсэл

Цахилгаан соронзон долгионы спектрийн янз бүрийн мужуудад байгаа үл үзэгдэх гэрлийн цацаргыг ашиглан хэргийн газраас нүдэнд үл үзэгдэх объектуудыг илрүүлэхэд гадаадын олон оронд хэт ягаан болон хэт улаан гэрлийн өндөр чадалтай багажнууд, лазер гэрэлтүүлэг, зөөврийн түргэвчилсэн анализын багажнуудыг сүүлийн жилүүдэд ашиглаж байна. Хавсралт- /1-10/

1.2 Бичил нотлох баримтанд шинжилгээний хийх хими, физикийн спектр анализын тухай

Бичил объект болох үс, шил, утасны ширхэг, барилгын материал, шороо, биологийн эд эрхтэн, будаг хөрс, ус, агаар, биологи болон хүнс, тэжээлийн бүтээгдэхүүн зэрэг хуурай, шингэн, хатуу дээжин дэх элементийн агуулга тодорхойлох бүрэн ойлтынрентген–флуоресценцийнспектрометр / TRXFA/, атом шингээлтийн спектрометр /AAS/, болон индукцын холбоост плазмын масс спектрометр /ICP-MS/, хий, шингэний хроматограф-масс спектрометр /VARIAN GS-MS, LQ-MS, /, хэт ягаан туяаны спектрометр зэрэг өндөр мэдрэх чадвартай багаж тоног төхөөрөмжүүдийг шинжилгээ судалгааны ажилд ашиглагдаж байна. Хавсралт- /10-20/

**Дүгнэлт**

Шүүхийн шинжилгээний хими, физикийн лабораторийн одоо ашиглаж буй тоног төхөөрөмжийг орчин үеийн өндөр технологид суурилсан багаж төхөөрөмжөөр шинэчлэх, лабораторийн нарийн мэргэжлийн шинжээчдийг тодорхой үе шаттайгаар өндөр хөгжилтэй гадаад орнуудад бэлтгэх шаардлага байна.

Дээрхи нөхцөл байдлуудыг харгалзан техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчнийг сургаж дадлагажуулах талаар ОУАЭА-ийн техникийн хамтын ажиллагааны төсөлд бид саналаа явуулсан.

Бичил обьектын үс, шил, утасны ширхэг, барилгын материал, шороо, хөрс, ус, агаар, биологи болон хүнс, тэжээлийн бүтээгдэхүүн зэрэг хуурай, шингэн, хатуу дээжин дэх элементийн агуулга тодорхойлох бүрэн ойлтын Рентген–флуоресценцийн спектрометр / TRXFA/ 10-9 % мэдрэх чадвартай, атом шингээлтийнспектрометр/ AAS/болон индукцын холбоост плазмын масс спектрометр /ICP-MS/, хий, шингэний хроматограф-масс спектрометр /VARIAN GS-MS, LQ-MS, /, хэт ягаан туяаны спектрометр зэрэг өндөр мэдрэх чадвартай багаж тоног төхөөрөмжүүдийгшинжилгээнд ашигласнаар дараах үр дүнд хүрнэ.

- Бичил мөрөөр гэмт хэрэг илрүүлэх боломж бүрдэнэ
- Хими, физикийн өндөр мэдрэг спектр анализыг шинжилгээ судалгаанд ашиглах
- Шүүхийн шинжилгээний лабораториудад цөмийн технологийг өргөн хүрээтэй нэвтрүүлэх боломж бүрдэнэ.
- Өндөр мэдрэх чадвартай тоног төхөөрөмж ашигласанаар маш бага дээжинд шинжилгээ хийх боломжтой болно.
- Шинжлэх ухаан технологийн дэвшлийг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах болно.
- ШШҮХ –ийн лаборатори нь бусад өндөр хөгжилтэй орнуудын лабораторийн түвшинд хүрнэ.
- Гадаад орнуудын эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах боломж бүрдэж, судлагаа шинжилгээ ажил шинэ шатанд гарч ирнэ.
- Лабораториуд нь олон улсын шинжилгээний арга,аргачлал нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

## ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

# ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАДАНХААРАХ АСУУДАЛ

*З.Дашдаваа: ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, докторант, цагдаагийн хурандаа*



Анх байгаль, зэрлэг ан амьтны аюул заналаас өөрийгөө хамгаалах шинжтэй байсан аюулгүй байдлын хэрэгцээ нь аажмаар өргөжиж, эрх, хууль ёсны ашиг сонирхол, эд хөрөнгө, үзэл бодол, шашин шүтлэг зэрэг үнэт зүйлсийг хамрах болсон бөгөөд хүний нийгэм хөгжиж, аж үйлдвэржилтийг дагасан төвлөрөл бий болсноор шинэ агуулгаар илэрхийлэгдэх болжээ.

“Аюулгүй байдал” гэдэг нь судалгааны хүрээнээс хамаарч харилцан адилгүй бүтэцтэй учраас нарийн тодорхойлоход бэрх юм. Английн судлаач Ричард Уллман аюулгүй байдлыг дан ганц цэргийн аюул заналаар хязгаарлах нь бодит байдалтай нийцэхгүй хэмээгээд “Ард иргэдийн амьдралын түвшинг богино хугацаанд бууруулах аюултай нөхцөл байдал үүсэх, эсвэл төрийн болон төрийн бус байгууллагуудын баримтлах бодлого тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ мэдэгдэхүйц хязгаарлагдсан нөхцөлд үндэсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүснэ” хэмээн тодорхойлсон байна. Аюулгүй байдлын тухай асуудлыг онолын үүднээс Академич С.Нарангэрэл: “Аюулгүй байдал гэдэг нь тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал юм[1]” гэж тодорхойлжээ.

[1] С.Нарангэрэл. “Эрх зүйн толь бичиг”. УБ., 2007. 54 дэх тал

1990 оны ардчилсан хувьсгалын үрээр бид нийгмийн нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжээд даруй 25 гаруй жилийг ардаа орхисон байна. Социалист тогтолцооны үед аюулгүй байдал гэдгийг зөвхөн цэрэг, арми, батлан хамгаалах хүчин чадалтай холбож ирсэн ба энэ хугацаанд урьд нь мэдэгдэхгүй байсан нийгмийн цоо шинэ харилцаа шууд үүсч таньж мэдэхгүй, заримыг нь хожуу таньж байгаагаас алдаж оножирсэн.

Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд баталж, түүний үндсэн дээр 1994 онд Улсын Их Хурал 56 дугаар тогтоол гаргаж анхны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг, нийгмийн хөгжил цаг үеийн өөрчлөлттэй уялдан Улсын Их Хурал 2010 онд 48 дугаар тогтоол гаргаж 2 дахь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тус тус баталсан.

Улсын Их Хурал 2010 онд 48 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1-д: “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ”, 1.1.4-т: “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн”[2], 1.1.5-д: “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна” хэмээн тус тус заасан. Харин уг дифинитив хэм хэмжээг агуулгын хувьд ижил боловч хүчин чадлын хувьд дээрдүүлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1-д: “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”[3] гэжээ.

[2] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.4 дэх хэсэг.

Дээрх баримт бичгийн 3.3-т: шинээр “Дотоод аюулгүй байдал” гэсэн шинэ хэсэг нэмж “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, Үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн”[4] гэж заагаад 3.4 дэх хэсэгт “Хүний аюулгүй байдал” нь “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн”[5] гэж тус тус тодорхойлжээ.

Мөн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг ... хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд ... гүйцэтгэнэ”[6] гэж үүрэг болгосон байна.

Энэ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг нэг тогтолцоо / систем/ гэж үзвэл “Цагдаагийн байгууллагын аюулгүй байдал” нь түүнийг нэг хэсэг дэд тогтолцоо гэж ойлгож болно. Цагдаагийн байгууллага өөрийн аюулгүй

[3] Монгол Улсын Үндэсний байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх
[4] Монгол Улсын Үндсэсний аюулгүй байдлын үзэл баримталын 3 дугаар зүйлийн 3.3 дах
[5] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримталын 3 дугаар зүйлийн 3.4 дэх
[6] “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх хэсэгт

байдлыг хэрхэн хангаж байгаа байдалтай үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал холбогдоно.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын тухай ойлголтыг түүний хуулиар хүлээсэн үүрэгтэй нь холбон үзвэл гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх гадаад, дотоод орчин бүрдсэн байдлыг "Цагдаагийн байгууллагын аюулгүй байдал" хэмээн тодорхойлж болно.[7]

Цагдаагийн байгууллагын удирдлагаас албаны аюулгүй байдлын асуудалд онцгой анхаарч, анх удаа Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 351 дүгээр тушаалаар /код 113/ Дотоод аюулгүй байдлыг хангах журмыг баталж, аюулгүй байдлыг хангах ерөнхий чиглэлийг тогтоож өгсөн.[8] Тухайлбал, Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, санхүү /төсвийн хөрөнгө/-ийн аюулгүй байдлыг хангах, "галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, барилга, байгууламж /объект/-ийн аюулгүй байдлыг хангах тус тус тусгасан байна.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын амин чухал зүйл бол цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдал юм. Судлаачид өөр өөрийн байр сууринаас цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлыг хувийн аюулгүй байдал, үйл ажиллагааны аюулгүй байдал, цагдаагийн албан хаагчийн ажиллах нөхцлийн аюулгүй байдал зэргээр ангилж үздэг. Энэ бүгдээс үзэхэд, манай улсын хувьд цагдаагийн албан хаагчийн ажиллах нөхцлийн аюулгүй байдал нэн чухал зүйл болж байна.

Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн хөгжлийн явцад цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг тасралтгүй шинэчилж, боловсронгуй болгож ирсэн. Цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, зэвсэг, зэвсэглэмж, хувцас, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, албаны нууцлал зэрэг хангагдсан байдал зэрэг нь цагдаагийн байгууллагын ажиллах нөхцлийн аюулгүй байдалд хамаарна.

Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2013 онд Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулж, "Цагдаагийн албаны тухай"[9] хуулийг баталсан бөгөөд тус хуульд цагдаагийн байгууллага, албан хаагчийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх талаар дараах байдлаар зохицуулалт хийсэн. Үүнд: Цагдаагийн байгууллага, албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ.[10] Албан хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ.[11]

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх албан хаагчид галт зэвсэг олгох, албан хаагч нь галт зэвсгийг биедээ авч явах эрхтэй[12] гэж тус тус заасан.

Академич С.Нарангэрэл: "Агсамж гэж цэрэг, цагдаагийн албан хаагч бүрийн нэг бүрийн иж бүрэн хувцас, хэрэглэл, зэвсэглэл"-ийг хэлнэ[13] гэж тодорхойлсон байна.

Цагдаагийн албаны тухай хуулийг цагдаагийн байгууллага, албан хаагч нь үйл ажилагаандаа баримтлан ажиллаж байгаатай холбогдуулан 2010 онд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын Ерөнхий прокуроортой хамтран "Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх зааварт хүчингүй болсон бөгөөд улмаар Хууль зүйн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтран баталсан 2014 оны А/126 тоот тушаал"[14]-ыг мөрдөн ажиллаж байна. Тус тушаалаар баталсан зааварт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах албаны галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт болон тэдгээрийг албан хаагч хэрхэн, ямар аргачлалаар хэрэглэхийг тусгайлан заасан ба Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн галт зэвсэг, тусгай хэрэгслийн заалтын үзэл баримтлалд нийцүүлсэн байна.

Аюулгүй байдал, хамгаалалтын үйл явцаас хожимдож, хоцрох, анхаарал, болгоомжлол, албаны сонор, сэрэмж алдах нь аюул заналд өртөх эрсдлийн хувь хэмжээг нэмэгдүүлдэг.

Аюулгүй байдлыг бүрдүүлэгч олон талт жижиг бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн зохион байгуулж, нэг тогтолцоонд оруулснаар аюулгүй байдлыг зохих түвшинд нь хангах бололцоо бий болно. Үүнээс үзэхэд, байгууллагын болон албан хаагчийн аюулгүй байдлыг бүрдүүлэгч гол хүчин зүйл нь чадавхи, боломж юм.

Зарим нам, эвсэл, иргэний нийгмийн байгууллага ээлжит сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлсэн 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдлыг санах нь зүйтэй. МАХН-ын төв байрны урд зохион байгуулсан жагсаал, цуглаан нь даамжирч нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг бий болгож, энэ үеэр 523 цагдаагийн албан хаагчэрүүл мэндээрээ хохирсон. Тухайн үед хуулийн байгууллагуудын албан хаагчид, удирдах ажилтнуудын ажлын идэвхи санаачлага, мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлага дутмаг, ажил хариуцах тодорхойэзэнгүй, тулгарсан асуудал бэрхшээлийг шуурхай шийдвэрлэх бололцоогүй байсан нь бодит үнэн. Цагдаагийн албан хаагчийн хүч, хэрэгсэл мөхөсдөж удирдлагын ухаан дутаж, эсэргүүцлийн золиос болсон.

Иргэд цагдаагийн албан хаагчдыг өөрсдийгөө хамгаалж

[7] Цагдаагийн Ерөнхий газар."Цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал 2012". УБ., 2013. 21 дэх тал

[8] ЦЕГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс. "Аюулгүй байдал 1". УБ., 2013. 5 дахь тал

[9] Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл 2013 №14

[10] Цагдаагийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дах заалт

[11] Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт

[12] Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дах заалт

[13] С.Нарангэрэл "Эрх зүйн толь бичиг" 2008 он

[14] ХЗС-ын 2014.07.10-ын өдөр баталсан "Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар"

чадахгүй олноороо гэмтсэн явдлаас улбаалан тэднийг албан үүргээ гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл хангалтгүй гэж үнэлж байна.

Цагдаагийн албан хаагчид гэмт хэрэг, зөрчлийн тухай дуудлага хүлээн авч, хэргийн газарт тэнд ямар аюул отож байгаа, хэдэн хүн байгааг мэдэхгүй ганцаараа эсвэл хоёулаа очиж байна. Эндээс үзэхэд, цагдаагийн албан хаагчид эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байна.

Хөдөө орон нутагт хэсгийн төлөөлөгч, цагдаа нар хуулийн дагуу ажиллах нөхцөл бүрдээгүй, эрх зүйн зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн, согтуурсан, танхайрсан этгээдийг түр саатуулах зориулалтын байргүйгээс албан контортоо, гэртээ саатуулснаас зарим цагдаагийн албан хаагч гэмт хэрэгт холбогдож байна. Энэ нь эрхэлж буй ажил нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох нөхцлийг бүрдүүлж байгааг харуулж байна.

Мөн цагдаагийн байгууллагаас 2013 онд үйл ажиллагааны эрх зүйн орчны үнэлгээний чиглэлээр хийсэн судалгаанд оролцсон 4874 албан хаагчдын санал асуулгын дүнгээс үзэхэд, цагдаагийн албан хаагчийн ажиллах нөхцөл, ажлын байрны нөхцөл хангалтгүй гэсэн дүгнэлт гарчээ.

Энэ нь 1960 оноос 59 цагдаагийн албан хаагчид үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан, сүүлийн 3 жилд халдлагад өртөж хохирсон 894 үйлдэл бүртгэгдсэний 641 буюу 71 хувьд нь захиргааны арга хэмжээ авч, 253 үйпдэл эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.Энэхугацаанд халдлагад өртөж хохирсон 894 цагдаагийн албан хаагчийн 451 буюу 43.5 хувь нь офицер, 506 буюу 56.5 хувь цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн байгаа бөгөөд тэдний 49.8 хувь нийслэлд үйл ажиллагаа явуулдаг цагдаагийн газар, хэлтсүүдийн албан хаагч, 50.2 хувь нь орон нутгийн цагдаагийн байгууллагын албан хаагчид байжээ.

Цагдаагийн алба хаагчдаас 34 нэр төрлийн техник, хэрэгслийн хангалтын талаарсудалгаа авахад судалгаанд оролцогчдын 30 хүрэхгүй хувь нь хангагдсан, 50% нь техник, хэрэгсэл огт байхгүй,10% нь хангалт хийгдээгүй гэснээс үзэхэд,цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг техник, хэрэгслийн хүрэлцээ хангалтгүй байна.

Албан хаагчид нэг бүрийн тусгай хэрэгслээс гав, бороохой, гар чийдэнгээр 70 орчим хувь нь хангагдсан байх ба техник, уналгын хэрэгслийн хангамжийн тухайд туйлын хангалтгүй буюу 20-40 хувь байгаа бол компьютер, мэдээллийн техникийн хангамжийн тухайд компьютер, принтер зэрэг оффисийн техник хэрэгсэл 60-70хувийн хангамжтай байхболовч бусад мэдээллийн хэрэгслийн хангамж 45-аас доош хувьтайбайна.[15]

Эндээс үзэхэд, “Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдал гэдэг ньгэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх албан үүргээ биелүүлэхтэй холбогдуулан болзошгүй эрсдэл, хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас цагдаагийн алба хаагч түүний гэр бүлийн гишүүд хамгаалагдсан болон албан үүргээ биелүүлэх баталгаа, ажиллах нөхцөлөөр хангагдсан байдлыг ойлгож болохоор байна.

Иймд цагдаагийн албан хаагчдын аюулгүй байдал нь нэн түрүүнд албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадвар. сэтгэл зүй, албан болон хувийн бэлтгэл, үйл ажиллагааны хувьд эрх зүйн зохицуулалтаар хамгаалагдсан, үүрэг гүйцэтгэх, ажиллах нөхцлөөр бүрэн хангагдсан байдал зэргээс шалтгаалан албан хаагчийн аюулгүй байдал хангагдахаар байна.

Мөн цагдаагийн албан хаагчгүйгээр цагдаагийн байгууллага нийгмийн өмнө хүлээсэн чиг үүрэг, зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжгүй.Иймд цагдаагийн албан хаагч, түүний эрх зүйн байдлыг тодорхойлж, ажиллах нөхцлийн аюулгүй байдлыг хангах асуудал нь цагдаагийн байгууллагын төдийгүй төрөөс анхаарах гол асуудлын нэг болж байна.

Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлын ойлголтыг Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27.1.4-т “Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн нь тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллагаар хамгаалуулах”хэмээн заасан нь албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад учир дутагдалтай байна.

Иймд Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлын ойлголтыг өргөн хүрээтэй хуульчлах нь зүйтэй.

Судалгааны үр дүндээ үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна:

1. Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад төрийн зүгээс онцгойлон анхаарах, албан хаагчдын зэвсэг, тусгай хэрэгсэл, уналгын хангалтыг цаг тухай бүр хийх,
2. Цагдаагийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчийн ажлын байр, зэвсэг, тусгай хэрэгсэлд тавигдах стандартыг баталж, мөрдүүлэх,
3. Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор цагдаагийн байгууллагаас албан хаагчийн үйл ажиллагааны стандартыг шинэ хуульд нийцүүлэн өөрчлөх,
4. Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албан хаагч гэж хэн байхыг тодорхойлсон хэм хэмжээ байхгүй байгаа нь албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, аюулгүй байдлыг хангах зэрэг олон талт харилцаанд нэгдмэл бус байдал бий болгох талтайг харгалзан түүнийг нэмэлтээр оруулах,
5. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас нь хохирсон, хөдөлмөрийн чадвараа алдсан, албан хаагчдад олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх,
6. Албан хаагчдын албан үүрэг гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах чиглэлд анхаарч, чадамжид суурилсан давтан мэргэшүүлэх зорилтод сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулах,
7. Цагдаагийн байгууллагын албан хаагчдын албаны нууцлалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зэрэг болно.

[15] Монгол Улсын Хууль зүйн яам, Хууль сахиулах их сургууль, Цагдаагийн ерөнхий газар. “Цагдаагийн алба хаагчийн ёсзүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэчлэл” сэдэвт судалгааны тайлан. УБ., 2013. 37дахь тал



# ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

*Б.Баянмөнх: ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн дэд профессор, докторант, цагдаагийн хошууч*

1990 онд Монгол Улсад өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр дүнд Монгол Улсын нийгмийн байгуулал бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж, өнөөдөр дэлхий нийтийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн хөгжил дэвшлийн голдирлоор хөгжиж байна.

Энэ бүхний эрх зүйн үндэс нь 1992 оны Монгол Улсын "Үндсэн хууль"[1]-ийн үзэл санаагаар баталгаажсан бөгөөд түүний дагуу Монгол Улсын эрх зүйн тогтолцоог шинэчлэх, шинэтгэх үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон улсын гэрээ, конвенци, хууль тэдгээрт нийцүүлэн, цагдаагийн төв байгууллагаас гаргасан үйл ажиллагааны журам, түүнчлэн бусад эрх зүйн баримт бичгүүд нь, цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, бид үүнийг цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин гэж ярьж ойлгодог болсоор багагүй хугацаа өнгөрсөн.

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй 90 гаруй хуулийн 166 гаруй зүйл, хэсгээр /зарим хууль бүхэлдээ, зарим хуулийн зүйл, хэсгийг оролцуулан/ цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажил, хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулж байна.[2]

1993 оноос хойш цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар батлан мөрдүүлж ирсэн 400 гаруй журам, заавруудын сул тал нь хичнээн хуульд нийцүүлэн гаргасан, ямар харилцааг зохицуулж байгаа талаар бүртгэл тооцоогүй явж ирсэн нь тэдгээрийн заавал мөрдөгдөх шинж утга, агуулга, ач холбогдлыг бууруулж, эцсийн дүндээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны технологи алдагдахад нөлөөлөх нэг сөрөг хүчин зүйл болж байсан.

Өнөөдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хүн амын нягтрал болон үйлдвэржилт, эдийн засгийн байдал, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамааран аймаг, нийслэлд Цагдаагийн газар, хэлтэс, сум, дүүрэгт Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн нэг маягийн зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн нийтийн хэв журам хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий газруудын үйл ажиллагаа зарим талаараа давхцах байдал ажиглагдаж эхэлсэн. Тухайлбал, хөдөө орон нутагт олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий тасаг, нэгж байхгүйгээс нийтийн хэв журам хамгаалах тасаг дээрхи чиг үүргийг хамтад нь гүйцэтгэж, ачаалалтай ажилладаг.

2. Зарим чиг үүргийг бусад байгууллагууд руу шилжүүлсэн боловч бодит байдал дээр хэрэгжихэд хүндрэлтэй байдал үүссэн. Тухайлбал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хэв журам хамгаалах тасаг шинэ "Цагдаагийн албаны тухай хууль"-аар хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих захиргааны хяналтын үүрэг байхгүй, энэ чиг үүрэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба руу шилжсэн боловч өнөөг хүртэл цагдаагийн хэсгийн байцаагч нар хяналтаа тавьсаар байна.

3. Хуучин дотоодын цэрэгт ажиллаж байсан бие бүрэлдэхүүн шууд олон нийтийн аюулгүй байдлыг хангах газарт шууд шилжин ирж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн. Тухайлбал, дотоодын цэрэгт ажиллаж байсан бие бүрэлдэхүүн цагдаагийн байгууллагын харъяанд шилжин ирж, зарим тохиолдолд хэв журмын албаны үүрэг гүйцэтгэх болсоноор тэдний эрх зүйн мэдлэг, ур чадвар дутагдаж, цагдаагийн албаны нэр хүнд унах нөхцөл байдал үүссэн.

4. Бусад хууль тогтоомжоор цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн үүргүүд өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа. Нөгөө талаар, цагдаагийн байгууллагад хуулиар хүлээлгэсэн үүргүүд дээр нэмэгдээд нутгийн захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын өгсөн үүрэг даалгавар, дүрэм журам ихээр гарах болсонтой холбоотойгоор гүйцэтгэж байгаа үүргийн цар хүрээ тодорхой хэмжээгээр тогтвортой байгаа мэт боловч хуучин хэвэндээ байна гэж үзэх үндэстэй юм.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь 2013 онд шинэчлэн батлагдсан "Цагдаагийн албаны тухай хууль"[3]-д нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр дараах хэм хэмжээг тусгасан байдаг байна.

[1] Төрийн мэдээлэл. 1992. №1

[2] Монгол улсын Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн Ерөнхий газар. "Цагдаагийн алба хаагчийн ёсзүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэчлэл". Судалгааны тайлан. УБ., 2013. 36. дахь талд.

[3] Төрийн мэдээлэл. 2013. №29

Тухайлбал:

- 13.5.5-д зааснаар, нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий нэгж нь "нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах" үүргийг хүлээдэг байна. Энэ нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нутгийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааны нэг хэлбэр, эрх зүйн үндэс болж байгаа бөгөөд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагаас зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй олон төрөл ажилд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч, мэргэжлийн удирдлагаар хангадаг байна.
- 19.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд, хариуцсан нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх журам тогтоож, түүний хэрэгжилтийг хангуулахыг, тухайн нутаг дэвсгэр харьяалах цагдаагийн байгууллагад хуулиар хүлээсэн үүргийнх нь хүрээнд даалгаж болно.
- 19.7. Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагыг удирдах талаар энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Эдгээр зүйл заалтууд нь, нутгийн удирдлагын байгууллагаас цагдаагийн байгууллагад үүрэг даалгавар өгч, биелэлтэнд нь хяналт тавих эх үндсийг нь тавьж өгсөн байна.

Гэвч нутгийн захиргааны байгууллагаас нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад эрх хэмжээнийхээ хүрээнд хүлээлгэж байгаа зарим үүрэг даалгавар нь, цагдаагийн байгууллагад хуулиар хүлээсэн үүргийнх нь хүрээнээс гадуур үүрэг даалгавар өгөх явдал гарсаар байгаа нь нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр хүндрэлийг бий болгож байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад эрх хэмжээнийхээ хүрээнд хүлээлгэж байгаа зарим үүрэг даалгавар нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээс гадуур, үл харъяалах шинжийг агуулж байна. Тухайлбал Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн даргаас цагдаагийн хэлтсийн даргад гаргасан хүсэлтийг онцлон авч үзэж болох байна.

"Албан хүсэлтийн тухай

Дүүргийн хэмжээнд 1 жилд 500-аад хүн нохойд уруулж, сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирол амсч улмаар галзуу өвчин тусах аюул тулгардаг.

Гэтэл, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, нохойгоо уядаггүй айл өрхөд хариуцлага тооцдоггүй, нохойнд хазуулж хохирсон хүн бүхий л эрсдэлээ өөрөө үүрч олон хоног халуурч өвдөж шаналж байхад нохойны эзэн нь "Хохь чинь" гээд гэдийж суудаг байдлыг таслан зогсоох цаг болжээ. Саяхан дүүргийн 1 дүгээр хорооны Баянзүрхийн 1-ийн 633 тоотын айл нь 10-аад нохойтой, нохой нь хүн хазаж шархдуулсан боловч эзэд нь огт тоохгүй, хашааныхаа хаалгыг ч хаадаггүй хэвээр байна.

Энэ мэт нохойнд хазуулж уруулсан хүмүүсийн гомдол байнга ирдэг боловч Цагдаагийн байгууллагын зүгээс дорвитой хийсэн ажилгүй явж ирсэн байдалд дүгнэлт хийхийг хүсч, дараах хүсэлтийг илгээж байна.

Үүнд: Иргэдийг нохойнд уруулахаас хамгаалах ажил өрнүүлж, нохойгоо уядаггүй айл өрхийн судалгаа хийж, иргэний үүргээ биелүүлдэггүй иргэнд хариуцлага тооцон ажиллаж дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна уу.

Дүүргийн Засаг дарга санаачлага гарган нохой устгах цэг байгуулж иргэдийн хүсэлтийн дагуу тодорхой ажлууд эхэлж байгааг та бүхэн дэмжиж иргэдийг нохойны аюулаас салгах ажил өрнүүлэхийг хүсье"[4] гэсэн албан хүсэлт байна.

Гудамж талбай, олон нийтийн газраар эзэнгүй явж байгаа олон нохойг цагдаагийн алба хаагч хэрхэн яаж хяналт тавьж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар тусгайлсан үүрэг байхгүйг онцлон хэлж болохоор байна.

Түүнээс гадна, Цагдаагийн төв байгууллага болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлагаас өгч байгаа үүрэг, чиглэл, тушаалууд зарим талаараа үндсэн чиг үүргээс гажсан үүрэг чиглэл өгөх явдал байсаар байна.

Тухайлбал, Нийслэлийн цагдаагийн газрын даргын 2014 оны 01-р сарын 07-ны өдрийн 14/24 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийн 2 заалт байна. Уг албан тоотодзаагдсан үүргүүдээс

- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газартай хамтран шатамтгай бодис, хийн түлшхэрэглэдэг орон сууцны нэгдүгээр болон суурин давхарт нийтийн хоолны зориулалтаар үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын газ болон хийн баллоны байрлуулалт, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, дүнг танилцуулах;
- Баригдаж буй барилгуудад гэмт хэрэг, зөрчил давтагдан гарсаар байна. Иймд барилга, байгууламж барих үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж ажиллах талаар албан мэдэгдэл өгч хариуг авч ажилла гэсэн 2 үүрэг даалгаврыг онцгойлон авч

[4] Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга А.Ганболдын 2014 оны 3-р сарын 24-ны өдрийн 1/41 тоот албан хүсэлт болно.

үзэж байна.

Энэхүү үүрэг даалгаврууд нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хийж гүйцэтгэх ажил биш, харин мэргэжлийн хяналтын газрын ажил үүргийн хуваарьт багтах ажил бөгөөд энэ нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажилд ачаалал өгч байна гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга 2014 оны 01 дүгээр 28-ны өдөр, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, хэсгийн дарга нарт дараах үүрэг чиглэл өгч эргэж танилцуулахаар болсон байна. Тухайлбал уг чиг үүргийн:

1. Чоно, нохойд ноцуулсан өвчтөний талаарх мэдээллийг хүлээн авсан бол хүн эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэж, хүн хүчийг дайчлан галзуурсан нохой, чоно, үнэгийг олж, устгах арга хэмжээг цаг алдалгүй авч, хэрэгжүүлэх;
2. Хот суурин газарт харъяалах эзэнгүй золбин нохой, муурыг устгах ажлыг зохион байгуулах;

Галзуурсан чоно, нохой, мал амьтан устгах гэсэн үүргийг цагдаагийн байгууллагад өгөхгүй байх, харин тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагад нь өгч байх асуудлыг нухацтай авч үзэх цаг болж гэж судлаачын хувьд үзэж байна.

Түүнээс гадна, цагдаагийн байгууллагын ажил үүрэгт огт хамааралгүй үүрэг чиглэлийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, түүний удирдлагаас өгөх явдал байсаар байгаа нь, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлэхэд багагүй хүндрэл бэрхшээлийг бий болгож байна.

**Дүгнэлт:** Нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх явцад, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл нилээдгүй байдаг нь энэхүү судалгааны ажлаар тогтоогдож байна. Тухайлбал нийтийн хэв журам, олон нийтийн хэв журам хамгаалах албадын төдийгүй бусад тэс өөр үүрэг чиглэл хариуцдаг агентлаг байгууллагуудын үйл ажиллагаатай давхардал бий болдог, үүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтанд ч давхардал үүсдэг, хоёр албаны үйл ажиллагааны хамрах хүрээг тогтоож өгсөн боловч бодит байдал дээр төдийлөн хэрэгжиж чаддаггүй байна.

Тиймээс нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх гарцыг дараах байдлаар тогтоох боломжтой гэж судлаачын хувьд үзэж дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд: Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн албадын үйл ажиллагааны хамрах хүрээг нарийвчлан тогтоох;

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг чиг үүрэгтэй уялдуулан дахин шинэчлэх;

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад өгч байгаа үүрэг даалгаврыг, эх сурвалжаас нь хамааран ангилан, дүн шинжилгээ хийж, удирдлагын түвшинд асуудлыг авч үзэж, үндсэн чиг үүрэгт үл хамаарах өгөгдсөн үүргүүдийг зааглан авч үзэх;

Нутгийн захиргааны байгууллагын удирдлагад цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн онцлог шинж, учир холбогдлыг тайлбарлан таниулах замаар нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад өгч байгаа үүрэг даалгаврын заагийг нарийвчлан тодорхойлж өгөх

## ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ БА ОНОЛ ПРАКТИК

С.Эрдэнэболор
Отгонтэнгэр их сургуулийн ОУЭЗТ-ийн эрхлэгч



Төр, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны харилцан хамаарлаас харахад төрөөс өөрийн чиг үүргийг нийгмийн бус институтэд шилжүүлэх асуудал нь төрийн онолын харьцангуй шинэлэг ойлголт байна. Төр өөрийн чиг үүргийг “иргэний санаачлага бүхий засгийн газрын бус байгууллагад”[1] шилжүүлэх үзэл санаа нь дараах онолуудаар дэмжигддэг байна.

***Нийтийн сайн сайхан ба хэрэгжилтийн алдаанд тулгуурласан онол*** /Public goods or performance failure theory/ - Иргэд өөрсдийн эрх ашиг сонирхлоо төрийн байгууллагаар хамгаалуулах эрхтэй. Харин бодит байдалд иргэд төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмж, үйл ажиллагааны үр дүнд сэтгэл хангалуун бус байдаг хийгээд энэхүү сэтгэл хангалуун бус байдлын үед төрийн бус байгууллагын оролцоог өргөтгөх ёстой гэсэн агуулга бүхий онол юм. Судлаач Вэйсброд өөрийн бүтээлдээ “Засгийн газар болон зах зээл нь хүн бүрийн нийтлэг ашиг сонирхолд үйлчилж, тэдний хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байх тэр үед Засгийн газрын бус байгууллага бий болсон” хэмээн бичсэн бол[2] судлаач Броун, Кортен нар *“Төрийн үйл ажиллагааны алдаа нь засгийн газрын бус байгууллага үүсэн бий болох нөхцлийг бүрдүүлдэг”*[3] хэмээн тодорхойлжээ. Мөн судлаач Анхиер “Төрийн бус байгууллагууд нь нийтэд үйлчилгээ үзүүлэх үүргийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай” гэснийг дурьдах нь зүйтэй.[4] Энэхүү онолоор төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь хэд хэдэн давуу талтай хэмээн үздэг. Тухайлбал: Тэд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ нэр төрд дулдуйдаж, ашиг орлогыг харгалздаггүйн дээр үйл ажиллагаагаа олон нийтийн дэмжлэг, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг тул үйл ажиллагаагаа бага зардлаар төлөвлөн хэрэгжүүлдэг. Төрийн үйл ажиллагаа нийгэм, эдийн засгийн макро түвшин хэрэгждэг бол төрийн бус байгууллагын үйлчилгээ нь тодорхой хувь хүн, гэр бүлд чиглэсэн микро түвшинд хэрэгждэг онцлогтой. Түүнчлэн төрийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй иргэд засгийн газрын бус байгууллагад хандан өөрсдийн эрүүл мэнд, боловсрол болон бусад нийтлэг хэрэгцээгээ хангаснаар засгийн газрын бус байгууллага нь иргэдийн итгэлийг илүү хүлээсэн, итгэмжлэгдсэн шинжтэй байдгаараа үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой байдаг байна.[5]

***Хамтын ажиллагааны харилцан хамаарлын онол*** /theory of partnership and interdependence/ - Төрийн болон засгийн газрын бус байгууллага нь “зөрчилдөөн”, “харилцан хамаарал”, “хамтын ажиллагаа”-ны зохист харьцааны үндсэн дээр хэрэгждэг бөгөөд тэдгээр нь өөр хоорондоо ажил мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлага, мэдээлэл, хөрөнгийн эх сурвалжаа харилцан солилцох байдлаар хамтран ажиллаж болно. Энэхүү онол ёсоор засгийн газрын бус байгууллага нь нийгмийн тодорхой зорилтыг хангахыг тулд төртэй хамтран ажиллах хэдий ч төрийн аливаа зорилгоос өөрийгөө хамгаалах механизмтай байхыг шаарддаг.

Иргэний ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах зорилго бүхий бидний нийгмийг бүтээн амьд болгох гол арга зам нь иргэний төрийн үйл ажиллагаан дахь иргэний эерэг оролцоог нэмэгдүүлэх явдал мөн билээ. Төрийн бүх эрх мэдэл ард түмний гарт байх бөгөөд энэ эрх мэдлээ өөрийн сонгосон төлөөллийн байгууллагаар дамжуулах буюу шууд оролцооны зарчмаар хэрэгжүүлэх эрхийн боломжийг үндсэн хуульдаа тусгаж өгсөн манай улсын хувьд төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нэг салаа мөчир болох цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд “Иргэний зөвлөл[6]” гэсэн нэр томъёо тодорхой орон зайг эзлээд төдийлөн удаагүй байгаа билээ.

Иргэний зөвлөлийн чиг үүрэгтэй ойролцоо буюу нэршлийн хувьд ижил төстэй байгууллагуудын талаар судлан үзэхэд манай улсын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл[7], Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөл[8] зэрэг чиг үүргийн хувьд ойролцоо байгууллагуудаас гадна НИТХ-ын Байгаль орчин, экологийн

[1] A non-governmental organization NGO, also often referred to as “civil society organization” or CSO) Төрийн бус байгууллага, мөн ихэвчлэн иргэний нийгмийн байгууллага гэх

[2] Weisbrod, B. (1977): Towards a Theory of the Voluntary Nonprofit Sector in Three Sector Economy, pp 51-76

[3] Brown, L.D & Korten, D.C (1991), Working More Effectivelywith Non-Governmental Organizations. Washington D.C.: World Bank

[4] Brown, L.D & Korten, D.C (1991), Working More Effectivelywith Non-Governmental Organizations. Washington D.C.: World Bank

[5] Anheier, H.K (1990): Private Voluntary Organizations and the Third World: Case of Africa

[6] Williamson, O. (1945): The Economic Institutions of Capitalism, New York, Free press

[7] Судлаачаас -Иргэний зөвлөл хэмээх байгууллага нь орон нутгийн өөрийн удирдах байгууллагын дэргэд иргэний санаачлага бүхий засгийн газрын байгууллага байх нь зүйтэй юм.

[8] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлиг

хороо, Ногоон байгууламжийн дэд хорооны дэргэд “Монголын байгаль орчны Иргэний зөвлөл” ТББ[9] “Эрүүл мэндийн иргэний зөвлөл” ТББ зэрэг нийгмийн салбарын чиглэлээр байгуулагдсан ажээ.

Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шинэ хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яам Америкийн Нэгдсэн Улсын Азийн сантай хамтран Улаанбаатар хотын эрүү, хэв журмын нөхцөл байдал хүнд, алслагдсан, хүн ам ихтэй Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн дөрвөн хороонд «Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа» туршилтын төслийг хэрэгжүүлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтмол үйл ажиллагаатай «Иргэний зөвлөл» бий болж, тухайн газруудад гэмт хэргийн гаралт 6-28 хувиар буурсан үр дүн гарсан[10] байдаг.

Олон нийтийн дэмжлэг, хүндлэлийг олж олон нийтийн санаа бодол, тэдний дэмжлэгт тулгуурласнаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэндээ хүрч, амжилттай ажилладаг талаар олон улсын судлаачид дүгнэсэн байдаг. Иргэний зөвлөл нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, сургалт, үйл ажиллагаандаа орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгуулагдсан байгууллага байхаар хууль санаачлагчид үзжээ. Энэ нь 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын их хурлаас баталсан Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны үйл ажиллагааны зарчмыг “иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах” гэж тодорхойлсонтой шууд холбоотой бөгөөд энэ зарчмыг хэрэгжүүлэх чухал зүйл болсон юм. Энэ хуулиар иргэний зөвлөлийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулахаар хуульчилсан байна.

Иргэний зөвлөлийн гол чиг үүрэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад асуудлаар ил тод, нээлттэй, тунгалаг байж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэний зөвлөл, олон нийтийн хяналтад оруулах[11] явдал байдаг.

Аливаа асуудлын суурь үндсийг тогтоохдоо эрдэмтдийн үзэл номлол, онолын үндэслэлийг судлах нь ирээдүйн хөгжлийг тодорхойлох зайлшгүй хэрэгцээ шаардлага болно.

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохдоо эрдэмтдийн үзэл, онолын шалгуурын үндсэн дээр тогтоох нь зүйтэй юм. Манай улсын хувьд энэ асуудлаар Цагдаа ард иргэдийн хоорондын харилцааг сайжруулах тухай /ЦЕГ Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа.2004/ Цагдаа, иргэдийн хоорондын зай / ЦЕГ Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа.2004 Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ЦЕГ 2004 онуудад хийгдсэн судалгааг дурьдах нь зүйтэй.

Ингээд иргэний санаачлагын байгууллагын онолын үзэл баримтлалуудыг манай эрх зүйн зохицуулалтуудтай харьцуулан авч үзье.

Иргэний санаачлагын байгууллага нь анхлан байгуулагдахдаа нийгмийн олон салбарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хөгжлийн тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр нийгмийн эрэлтэд тулгуурласан нийлүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлдэг /supply side/ байсан бол эдүгээ засгийн газрын бус байгууллага нь төрийн болон орон нутгийн удирдлагын байгууллага, зарим тохиолдолд тив, дэлхийн болон олон улсын төрийн бус байгууллагын үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт тухайлсан асуудлыг тусгуулахаар шаардах, тэдгээрийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих зэргээр /demand side/ ажиллах болжээ.[12]

Английн судлаач Лэвисын бичсэнээр иргэний санаачлага бүхий Засгийн газрын бус байгууллага нь үндсэн гурван чиг үүрэгтэй.[13] Үүнд:

***Хэрэгжүүлэгчийн чиг үүрэг*** – Иргэний санаачлагын байгууллага нь улс, үндэстэн, хүн амд хэрэгцээтэй байгаа боловсрол, эрүүл мэнд, санхүү, хөдөө аж ахуй болон хүний эрхийг хангах олон салбарт туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг нь түүний чухал чиг үүрэг болно. Тухайлбал. ИЗД-н 5.1.2. б/цагдаагийн алба хаагчдын сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад мэргэжилтэн, шинжээч, судалгааны багаар дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;

***Хөгжлийн хөдөлгөгч хүч*** - Иргэний санаачлагын байгууллага нь төр, засгийн газар, орон нутгийн удирдлагын байгууллага, иргэдийн боловсруулсан шинэлэг санаа, дэвшилтэт үйл ажиллагааг материаллаг болон материаллаг бусаар, шууд болон дам байдлаар дэмжин ажилладаг байна. Жишээ нь: ИЗД-н 5.2. а/ тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг

[9] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 120 дугаар зарлиг

[10] Монголын байгаль орчны иргэний зөвлөл /МБОИЗ/ нь 2008 онд “Байгаль орчны төрийн бус байгууллагуудын улсын анхдугаар зөвлөгөөн”-өөс үүсгэн байгуулагдсан, 21 аймагт салбар зөвлөлтэй, улсын хэмжээнд 700 гаруй төрийн бус байгууллагын гишүүнчлэлтэй шүхэр байгууллага юм.

[11] Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт «ОЛОН НИЙТ-ЦАГДААГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА» хөтөлбөр

[12] Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт **“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” 5 дугаар зүйл** 5.1.3.

[13] John Clark, The Relationship between the State and the Voluntary Sector, www.Ise.ac.uk

боловсруулахад санал өгөх;

***Хамтран ажиллах чиг үүрэг***– Иргэний санаачлагын байгууллага нь өөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улс орны төр засаг, хувийн хэвшлийн болон хандивлагч, донор байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажилладаг. Жишээ нь: ИЗД-н 5.1.4.б/ цагдаагийн байгууллагын Төрийн албаны салбар зөвлөл, Ёс зүйн хороотой мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

Харин Америкийн эрдэмтэн Симмон П.Ж "Засгийн газрын бус байгууллагаас суралцах нь" хэмээх бүтээлдээ засгийн газрын бус байгууллага нь дараах үндсэн чиг үүрэгтэй байна хэмээн бичжээ. Үүнд:

***Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох* /setting agenda/** -засгийн газрын бус байгууллага нь нийгэм, иргэдтэй илүү ойр хамтран ажилладаг болохын хувьд нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг ил болгон төр, засгийн газрын бодлогод тусгуулж, нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь: ИЗД-н 5.2. е/ цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, эрүүл мэнд, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

***Хэлэлцээрийн үндсэн дээр үр дүн бий болгох***- засгийн газрын бус байгууллага нь асуудлыг шийдвэрлэж, тодорхой ажлын үр дүн бий болгохын тулд олон талын хэлэлцээр, зөвшилцөл, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг. Жишээ нь: ИЗД-н 5.2. в/ цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд иргэд, төрийн бус байгууллагын түншлэл, итгэлцлийг сайжруулах, гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоож, туршлага судалж, хэрэгжүүлэх;

***Бодлогод нөлөөлөх*** - төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчийн шийдвэрт нөлөөлөх, лоббын шахалт үзүүлэх нь төрийн бус байгууллагын чухал чиг үүрэг болно. Жишээ нь: ИЗД-н 5.1.1.в/"Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт заасны дагуу Иргэний зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон цагдаагийн төв байгууллагын дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тус тус санал, зөвлөмжөө хүргүүлнэ."

***Шийдэл боловсруулах*** - ялангуяа олон улсын, тив дэлхийн чанартай төрийн бус байгууллагууд нь асуудлыг шийдвэрлэх шийдэл боловсруулах, уг шийдлээ бүс нутаг, улс оронд хэрэгжүүлэн ажилладаг. Жишээ нь: ИЗД-н 5.2.е/цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцлийг бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, эрүүл мэнд, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

Эрдэмтэн Иан Кларке засгийн газрын бус байгууллага ба иргэн нь төртэй харилцах харилцаанд дараах үндсэн 3 чиг үүрэг гүйцэтгэнэ хэмээн тодорхойлсон байна.[14]

Нөхөх чиг үүрэг (complementing role)

Шинэтгэлийн чиг үүрэг (reforming role)

Эсрэг хяналтын чиг үүрэг (opposing role)

Орчин үед оршин байгаа төрийн бус байгууллагуудын төр харилцах харилцааны шинж чанараас нь хамааран дараах үндсэн гурван төрөлд ангилан авч үзэж байна.[15]

***Нэгдүгээрт:*** Засгийн газрын бус байгууллага нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ төрөөс шууд хамааралтай байж, төрөөс урьдчилан боловсруулсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх санхүүжилт нь төрөөс шууд хамааралтай байдаг. Энэ төрлийн засгийн газрын бус байгууллага нь бодлого боловсруулагчдын ямар ч шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд үнэн зөв мэтээр тайлбарлан таниулах, ажлын үр дүнг сайшаан дэмжих зэргээр иргэний нийгмийг нэр төдий илэрхийлэн, улс төрийн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

***Хоёрдугаарт:*** Засгийн газрын бус байгууллага нь төртэй харилцахдаа сөргөлдөх, өрсөлдөх /хянах/ үндсэн бодлогыг баримтлах /Зайр, Кень болон Пиночентын дэглэмийн үеийн Чили улс / Хүний эрх, эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлсийг таягдан, зүй бус арга замаар үйл ажиллагаа явуулдаг төр, засаг, албан тушаалтны үйл ажиллагааг хурцаар шүүмжлэх, төрийн үйл ажиллагааг эрс шинэчлэх зорилгоор байгуулагдсан иргэдийн итгэлд суурилсан олон тооны хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд эдгээрт хамаарна.

***Гуравдугаарт:*** Засгийн газрын бус байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ төрийн байгууллагатай идэвхтэй хамтран ажилладаг. Ийнхүү хамтран ажиллахдаа гэрээний үндсэн дээр үнэнчээр хамтран ажиллах, асуудлыг улс төржүүлэхгүй байх, саналын зөрүүтэй үед хамтран хэлэлцэж асуудлыг шийдвэрлэх, төрийн бус байгууллагын зорилт, зорилгоо үл ухамсарлахаас сэрэмжлэх зэрэг зарчмыг баримталдаг.

**Дүгнэлт, санал**

Иргэний зөвлөлийн эрхзүйн байдлыг талаарх Цагдаагийн албаны хууль болон Хууль зүйн сайдын 2014 оны 06 дугаар сарын08-ны өдрийн А/89 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан **Иргэний зөвлөлийн дүрэм дахь эрхзүйн зохицуулалт нь онолын хувьд байвал зохих зохицуулалтууд тодорхой хэмжээгээр тусгагдсан**

[14] Lewis. D. (2007).The Management of non-governmental development organizations (2nd edition). London. Routiedge.
[15] Мөн тэнд

**байгаа дүгнэлтийн эхэнд сайшаан тэмдэглэмээр байна.**

Дээр дурьдсанаар Иргэний зөвлөлийг нийгмийн бүхий л салбар чиглэлд байгуулагдаад эхлэвэл хэрхэх вэ?, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөл зэрэг ойролцоо төрлийн байгууллагуудыг нэгэн зэрэг ажиллуулах нь тэдгээр байгууллагыг санхүүжүүлэх болон төсөв хүндрэлтэй байгаа өнөө үед хэр оновчтой вэ?Тэдгээр байгууллагын үйл ажиллагааг нэгтгэж, үйл ажиллагааг өргөжүүлж болох эсэх? гэсэн асуултууд өөртөө тавих шаардлага гарч ирж байна.

Судлаач иргэн хүний зүгээс дараах зүйлсийг санал болгож байна.

1. Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа нь цагдаагийн албаны тухай хуулиар биш өөр хуулиар, тухайлбал Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын нэгжийн тухай хуульд байх нь илүү оновчтой. Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа өргөжүүлжзөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд “иргэний гүүр” болон оролцох бус хяналт шалгалт явуулдаг төрийн байгууллагын ажиллагаанд туслан оролцох зүйтэй гэж үзэж байна.

2. Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа явуулах журамд анализ хийж үзвэл “Иргэний зөвлөл” хяналт талдаа давамгайлсан, идэвхгүй чиг үүрэгтэй болсон байна гэж дүгнэгдэхээр байна. Тухайлбал: тулгамдсан асуудлыг тодорхойлох, бодлого боловсруулах, шийдэлд нөлөөлөх чиг үүрэг төдийлөн тусгагдаагүй үлдсэн байна. Үүнийг нарийвчлан оруулж үйл ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй болов уу.

3. Засгийн газрын бус байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт холбогдуулан судалсан судлаачдын төрөлжүүлэн ангилалтыг монголынхоо хөрсөнд оновчтой ашиглаж “Иргэний зөвлөл”ийн эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг төрөлжүүлж, нарийвчлан журамлан зохицуулах нь тухай институтын практик үр нөлөөг дээшлүүлэх учиртай.

**Ном зүй**


1. John Clark, The Relationship between the State and the Voluntary Sector, www.Ise.ac.uk

2. Lewis. D. (2007).The Management of non-governmental development organizations (2nd edition). London. Routiedge

3. Giske C. Lillehammer, State-NGO relationships in transitional democracies: The case of CPA-ONG- a government center for the advancement of NGOs in Benin, April 2003

4. Weisbrod, B. (1977): Towards a Theory of the Voluntary Nonprofit Sector in Three Sector Economy, pp 51-76

5. Brown, L.D & Korten, D.C (1991), Working More Effectivelywith Non-Governmental Organizations. Washington D.C.: World Bank

6. Anheier, H.K (1990): Private Voluntary Organizations and the Third World: Case of Africa



# ХУУЛЬ БУС ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

*Ш.Чулуун: ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч*

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн нэг бол хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах явдал юм.

Монгол улсын иргэн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг ба энэ эрхийг нь Монгол улсын Үндсэн хуульд тодорхой зааж өгчээ. Тухайлбал:Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно[1]гэсэн ба Жагсаал цуглаан хийх журамын тухай хууль[2]-иар тодорхой зааж өгсөн байдаг бөгөөд тус хуулийг зөрчин явуулж байгаа үйл ажиллагаа нь хууль бус үйлдэл юм.

Ардчилсан нийгэмд хүний эрхийг дээдэлдэг хэдий ч эрхээ эдлэхдээ бусад хүний эрхийг бас зөрчиж болохгүй юм.

Иргэдийн тайван замаар жагсаал цуглаан хийх, эрхийг ашиглан зөвшөөрөгдсөн газарт хуулийн дагуу явуулах бус, хууль зөрчих улс төр хийх, бусдыг хууль бус халдлагад өдөөн турхирах, бусдын болон төрийн тангараг өргөсөн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, бусдын болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр, хууль бусаар халдах, олон нийтийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн гажууд үзэгдэл гарсаар байна.

Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийнхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон тохиолдолд цагдаагийн байгууллага аймаг, нийслэлийн засаг даргын захирамжаар албадан тараана[3] гэж хуулинд тодорхой заасан байна.

Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан, иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал[4] гэнэ гэж тус тус холбогдох хуулинд нарийвчлан тусгаж өгсөн байна.

**Жагсаал, цуглаан хийхийг хориглох газрыг хуулинд дараах байдлаар тусгаж өгсөн байна. Үүнд:**

- Нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал
- цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар
- радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар
- олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах
- эмнэлгийн байгууллага
- Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт[5] гэж тус тус заасан байна.

Жагсаал, цуглааныг зохион байгуулах субъектээс дараах зорилгыг агуулсан жагсаал, цуглаан хийхийг мөн хуулиар хориглосон байна.

- Дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах
- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох
- Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийх
- Зохих журмын дагуу бүртгэгдсэн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийх
- Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно[6] гэж тус тус заасан байна.

Дээрхи нөхцөл байдлыг дүгнэж үзвэл хэдийгээр эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсан хэдий ч жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосон газар, хууль бус зорилго агуулсан,

[1] Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16 дахь заалт
[2] Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль. УБ.1994.ТМ.,№3
[3] Үндсэн хуулийн 25-р зүйл 2.2 дахь хэсэг
[4] Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 3-р зүйл
[5] Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 7-р зүйл
[6] Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 8-р зүйл

эсвэл эрх бүхий субъектээс зөвшөөрөл аваагүй жагсаал, цуглаан зохион байгуулж явуулах ажиллагаа нь өөрөө хууль зөрчсөн үйлдэл буюу хууль бус жагсаал, цуглаан юм.

Цагдаагийн байгууллага нь хуульд заасан журмын дагуу зохион байгууллагдаж байгаа жагсаал, цуглааны үед хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу хэв журмын хамгаалалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж оролцогчдын аюулгүй байдлыг гадны гэмт халдлагаас хамгаалж, хэв журам сахиулан ажиллах үүрэгтэй байна.

Мөн нөгөө талаас хууль бусаар зохион байгуулж байгаа жагсаал, цуглааныг албадан тараах үүрэгтэй байна. Энэхүү үүргийг нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль[7], Цагдаагийн албаны тухай хууль[8]-д тус тус тусгайлан заасан байна.

Өөрөөр хэлбэл хуульд заасан хүч, арга хэрэгсэл хэрэглэн жагсаал цуглааныг албадан тараах тухай Засаг даргын захирамжийг биелүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ юм.

Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхдээ цагдаагийн байгууллага нь “Шуурхай удирдлагын штаб” байгуулж ажиллана[9]. Шуурхай удирдлагын штабыг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилно.

Штаб нь суурин болон зөөврийн радио станц, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, сүлжээнд холбогдсон телефон утас, чанга яригч, зурагт, дуран, гэрэлтүүлэгч хэрэгсэл, цахилгаан үүсгүүр, бусад шаардлагатай техник хэрэгслээр хангагдсан байна.

Штабын байранд хууль тогтоомж, журам, заавар, тушаалын эмхтгэл, бэлэн байдлын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд, зураглал, газрын зураг, хүч, хэрэгслийн тоо, нөөцийн мэдээ, шаардлагатай алба хаагчдын холбоо барих утасны жагсаалт, радио холбооны дуудлага зэргийг бэлэн байлгана.

Мөн штабын дэргэд ажлын хэсэг ажиллаж, дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, хамгаалалтад ажиллаж байгаа анги, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан мэдээ, мэдээллийг цаг, минутаар баримтжуулах, зураглал үйлдэх, бичиг баримт төлөвлөх зэрэг удирдлагаас өгсөн бусад үүргийг гүйцэтгэнэ[10]гэж үйл ажиллагааны чиглэлийг нь нарийвчлан тусгаж өгсөн байна.

Жагсаал цуглааныг албадан тараахад цагдаагийн байгууллага, алба хаагч нь зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал бий болсон үед хуулинд заасан үндэслэл журмын дагуу албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх эрхтэйбайна.

Энэхүү эрх зүйн зохицуулалтыг нь Цагдаагийн албаны тухай хууль[11], Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль[12], Хууль зүйн сайдын А/126 тоот тушаалд[13] тус тус зааж өгчээ.

Олон улсын болон дотоодын хууль тогтоомжоор цагдаагийн албан хаагч жагсаал, цуглааныг албадан тараахдаа хуулинд заасан үндэслэл журмын дагуу хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн тусгай хэрэгсэл хэрэглэн зогсоох боломжийг зохицуулсан байдаг.

Тусгай хэрэгсэл нь хүний амь насанд аюулгүй ангилалд багтах боловч хэрэглэх журам, зааврыг зөрчиж буюу хэтрүүлэн хэрэглэвэл хүний амь нас, эрүүл мэнд хохирно гэдгийг ямагт санах хэрэгтэй. Тиймээс тусгай хэрэгслийг тусгайлан боловсруулж баталсан журам, нарийн заавар, удирдамжийн дагуу хэрэглэх ёстой[14].

Жагсаал цуглааныг албадан тараахад цагдаагийн байгуулллага нь албаны зэвсэглэмжинд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгслийг хэрэглэдэг бөгөөд тэр дундаа олон хүмүүсийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, баривчлах саатуулах үедээ олон хүнд нэг зэрэг нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэдэг байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллага нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг албаны үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэжнөхцөл байдлыг хяналтдаа авах зорилгоор хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг хэлэх ба дараах төрөлтэй. Үүнд:

- Олон хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч
- Утаан хөшиг үүсгэгч
- Усан хөөрөг
- Бусад тусгай хэрэгсэл

Олон хүнд зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч: Энэ нь хоёр буюу түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа,нулимсны булчирхайг цочроодог /хий, шингэн төлөвтэй байдаг/

Олон хүнд зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч: Энэ нь хоёр буюу түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, хоолой боох үйлчлэлтэй байдаг /шингэн, хий төлөвтэй байдаг/

Усан хөөрөг: Энэ нь усыг өндөр даралтаар хүчтэй цацаж сөрөг үйлдлийг сарниулна.

Утаан хөшиг үүсгэгч: Энэ нь үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно/

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг заавал тодорхойлно. Үндэслэлтэй шаардлага байгаа тохиолдолд тусгай хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараа, тактикийг сонгоно.

Түүнчлэн олон хүнд нөлөөлөх

---

[7] Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14-р зүйлийн 3 дахь хэсэг
[8] Цагдаагийн албаны тухай хуулийн 2-р бүлгийн 11-р зүйлийн 11.1.7 дахь заалт
[9] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-400 400.6
[10] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 400.14 дэх заалт
[11] Цагдаагийн албаны тухай хуулийн 6-р бүлгийн 28, 8-р бүлгийн 33-р зүйлийн 33.6 дахь хэсэг
[12] Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-21-р зүйл
[13] ХЗС-ын А/126 тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
[14] 1990 оны НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмуудын 1 дүгээр зүйл

тусгай хэрэгслийг хэрэглэх талаар прокурорын байгууллагад урьдчилан мэдэгдэх хэрэгтэй[15].

Хууль бус жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага нь албадан тараахдаа нэн түрүүнд хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон жагсаал, цуглаан хийх эрх, үндсэн хуульд заасан хүний амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хангах чиглэлийг баримтлан ажилладаг.

Иймээс жагсаал, цуглаан хийж буй этгээдүүд нь эрхээ хэтрүүлэн хэрэглэх тохиолдол нь хүний эрхийг хуулийн дагуу зөрчиж байгаа явдал юм.

Түүнчлэн тусгай хэрэгслийг хэрэглэхдээ удирдах албан тушаалтны байнгын хяналтанд байж гагцхүү зайлшгүй шаардлагатай үед ашиглагдах ёстой. Тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа нарийн бүртгэл хөтөлж хууль бусаар буюу хяналтгүйгээр, өөр зорилгоор ашиглах явдлаас зайлсхийх хэрэгтэй.

Хууль бус жагсаал, цуглааныг тайван замаар хохирол багатай зохицуулан тараах нь цагдаагийн байгууллагын удирдлагын нэн тэргүүнд тавих зорилго байдаг.

Цагдаагийн алба хаагчид нь аливаа хууль бус жагсаал цуглааныг албадан тараах үед ажиллахдаа хамгаалах тусгай хэрэгслийг бүрэн гүйцэд ашиглах хэрэгтэй. Шаардлагтай тохиолдолд олон хүнд зэрэг нөлөөлөх усан хөөрөг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, утаан хөшиг үүсгэгчийг ашиглахад бэлэн байлгана.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхдээ дор дурдсан үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэхээр НҮБ-ийн эрх зүйн баримт бичиг болон дотоодын эрх зүйн актуудад тусгасан байна. Тодруулбал:

Олон улсын эрх зүйн зохицуулалт нь[16]:

- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд бодит хохирол учрах аюул
- Өөр арга, хэрэгсэл хэрэглэх нь үр дүнгүй буюу зайлшгүй нөхцөлд
- Хүч буюу тусгай хэрэгсэл хэрэглэх нь хуулийн биелэлтийг хангахад чиглэсэн байх

Монгол улсын эрх зүйн зохицуулалт нь[17]:

- ✓ нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох;
- ✓ нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох;
- ✓ байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- ✓ хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- ✓ цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;
- ✓ **цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон;**
- ✓ хүнийг барьцаанд авсан;
- ✓ ялтан,цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугатсан;
- ✓ галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- ✓ хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;
- ✓ хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

***Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө дараах анхааруулга[18] өгдөг.***

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг биелүүлэх, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ.

Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Гэхдээ тухайн ажиллагаа, бүлгийг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр урьдчилан анхааруулахгүй хэрэглэж болно[19].

***Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үед дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.***

**Эсэргүүцлээ зогсоох хугацаа өгөх:**

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь анхааруулга өгсөний дараа тэдэнд сайн дураараа тарж явах боломжоо олгоно. Энэ нь уг жагсаалыг сонирхогч иргэд, хөндлөнгийн хүмүүс тусгай хэрэгсэлийн нөлөөнд өртөхөөс сэргийлнэ. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхааруулга өгөхөөс гадна тэдгээр жагсаалд оролцогчид, сонирхогчдыг чөлөөтэй тарж явах боломжоог олгож гарах, явах гарцыг нээсэн байна.

Хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх[20]

Тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа зорилго нь тухайн эсэргүйцлийг няцаах, хяналтандаа авах, таслан зогсооход чиглэгдсэн байдаг тул аль болох бага хор уршиг учруулах. Эсэргүүцэл зогссон үед дахин хэрэглэхгүй

[15] Хууль зүйн сайдын А/126тоот тушаал 2-р хавсралт“Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
[16] НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмуудын 4, 9 дүгээр зүйл,
[17] Хууль зүйн сайдын А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
[18] НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмуудын 10 дугаар зүйл
[19] Хууль зүйн сайдын А126т/тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
[20] 5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

байх

Хүний амь нас, нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж илүү их хохирол учруулахгүй байх[21]

Хэдийгээр тухайн эсэргүүцэгч этгээд чулуу, мод, шил, төмөр шидсэн бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдсан ч гэсэн түүнийг барисан тохиолдолд иргэдийн урд гаргасан үйлдэлд өширхөх маягаар зодох, дэглэх үйлдэл хийж болохгүй. Түүнчлэн эмх замбараагүй байдалд оролцоогүй энгийн буюу хөндлөнгийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг баримтлах.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа эмнэлгийн туслалцааг гэмтэж бэртсэн хүн бүрт яаралтай үзүүлж шаардлагатай арга хэмжээ авах[22] **/өмнө үйлдсэн үйлдэлээс үл хамаарна/**

Тухайн этгээдийн жагсаал, цуглаан дээр гаргасан авир байдлыг үл харгалзах ба хохирсон хэнд ч болов туслах /цагдаа, үймээн гаргагч, жагсагч, жирийн иргэн, сонирхогч г.м/.

Тусламж шаардлагатай хүнд газар дээр нь анхны тусламж үзүүлж, эмнэлгийн байгууллагад хүргэх арга хэмжээг цаг алдалгүй авах, хордсон хүн амьтан гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах, иргэдэд зөвлөгөө өгөх[23]

Дээд буюу удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх

Тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар өгөгдсөн үүргийг хэрхэн биелүүлсэн талаар шуурхай удирдлагын штабт илтгэнэ.

Бэртэж гэмтсэн хүнийн ар гэрийхэн болон ойр дотны хүмүүст нэн даруй мэдэгдэх[24]

Жагсаал, цуглаанд оролцогчид болон иргэд нь хэдийгээр хууль бус үйлдэл хийж хэрцгий авирласан байлаа тусгай хэрэгсэлийн нөлөөлөлд өртөж гэмтэж бэртсэн бол цагдаагийн байгууллагаас уг этгээдийн хэн болохыг тогтооож, ар гэрийнхнийх нь хаяг, утасны дугаарыг тодруулан түүний ар гэр, хамаатан садан, найз нөхдийн аль нэгэнд яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна. Уг хүний талаар ямар шийдвэр гарч хаана байгааг нь мөн дуулгана

**Хүч хэрэглэсний дараа үзүүлэх эмнэлэгийн анхны тусламж**

Цагдаагийн байгууллагын алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг бусдад хүч хэрэглэсэн тохиолдолд наад захын эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай.

Ер нь ямар ч осол аюул тохиолдсон үед анхны тусламжийг зөв, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлэх явдал нь цагдаагийн ажилтны мэдлэг, ур чадварын нэг үзүүлэлт мөн.

Анхны тусламж гэдэг нь аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлэгийн тусламж иртэл гарын доорх материалыг ашиглан өөртөө болон нөхөртөө, бусад хүнд үзүүлэх тусламжийг хэлнэ.[25] Өөрөөр хэлбэл эмнэлгийн мэргэжлийн бус жирийн ард иргэдийн өөртөө болон нөхөртөө үзүүлж байгаа тусламжийг анхны тусламж гэж нэрлэх ба үүнийг эмнэлгийн мэргэжлийн түвшинд үзүүлж байгаа анхны тусламжаас ялгаж ойлгох хэрэгтэй.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр:

- Амь насыг аврах
- Осол гэмтлээс шалтгаалсан бусад хүндрэлүүдээс сэргийлэх
- Эдгэрэлтийг түргэсгэх
- Эмчилгээний зардлыг бууруулах
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох

зэрэг эерэг үр дагаврыг бий болгоно.

Хууль бус жагсаал цуглаанд нас, хүйс харгалзахгүй олон тооны хүмүүс оролцож байдаг тул тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа дээрх арга хэмжээг түргэн шуурхай авах нь цагдаагийн алба хаагчийн хариуцлагатай ажиллагааюм.

**Дүгнэлт**

Цагдаагийн байгууллага нь хууль бус жагсаал, цуглааныг албадан тараахдаа холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох сөрөг дагавараас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн албаны тусгай хэрэгслийг хэрэглэхдээ ашиглах аргачлал болон холбогдох аюулгүйн арга хэмжээг баримтлан ажиллах шаардлагатай билээ. Энэ нь алба хаагчийн эрх зүйн баталгааг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

НҮБ-ийн байгууллагаас гаргасан холбогдох олон улсын гэрээ, конвенцийг албаны үйл ажиллагаандаа хэвшүүлж баримтлан мөрдлөг болгон ажиллах нь хүний эрхийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж түүний баталгаа нь болж өгнө.

**Санал**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримталж байгаа хууль тогтоомж, эрх зүйн акт болон НҮБ-ийн хүний эрхийн талаархи конвенц, эрх зүйн баримт бичгийн талаар нэгдсэн сургалтыг холбогдох байгууллагатай хамтран алба хаагчдад зохион байгуулж тэдний эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэх

Цагдаагийн албаны үйл ажиллагаанд ашигладаг нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх ур чадварыг алба хаагчдад эзэмшүүлэх

Бусад улс орны цагдаагийн байгууллага нь хууль бус жагсаал, цуглааныг хэрхэн ямар байдлаар албадан тараадаг, ингэхдээ ямар арга хэмжээ, зарчим баримталдаг талаархи туршлагыг нь судлах, түүнд тулгуурлан дотоодын үйл ажиллагаандаа өөрчлөлт, шинэчлэлт хийх

[21] 5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

[22] 5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

[23] Хууль зүйн сайдын А/126тоот тушаалын 2-р хавсралт "Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар"

[24] 5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

[25] Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх журам ЦБҮАЖ-код-207

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

# СОВРЕМЕННЫЕ ПРОБЛЕМЫ ОБЕСПЕЧЕНИЯ ПЕНИТЕНЦИАРНОЙ БЕЗОПАСНОСТИ

*Пантелеев Виктор Александрович – доцент кафедры уголовно-исполнительного права Владимирского юридического института ФСИН России, кандидат юридических наук, доцент полковник внутренней службы в отставке*

Актуальность данной темы подтверждается тем, что пенитенциарная безопасность обеспечивается применением в соответствии с действующим законодательством физической силы, специальных средств и оружия. Вместе с тем, правовые основы указанных мер воздействия, по мнению автора, требуют дальнейшего совершенствования. В местах лишения свободы растет концентрация лиц, осужденных за тяжкие и особо тяжкие преступления, что в свою очередь повышает потенциальный уровень опасности и агрессивности данной среды. Формы и методы преступной деятельности, в том числе в местах лишения свободы становятся все более изощренными. В настоящее время сохраняется тенденция к активизации групповых противоправных действий осужденных, направленных на дестабилизацию деятельности исправительных колоний (ИК). По-прежнему криминальные лидеры в местах лишения свободы и вне их пытаются распространять «воровские традиции», организовывать и координировать противоправные действия осужденных, оказывать воздействие на представителей администрации.

Принятый 7 февраля 2011 года Федеральный закон № 3-ФЗ «О полиции» (далее Закон «О полиции») существенно расширил правовые основания применения сотрудниками органов внутренних дел физической силы, специальных средств и огнестрельного оружия. Как известно данный закон прошел процедуру широкого обсуждения. Часть 2 статьи 21 указанного закона предусматривает применение сотрудниками полиции 14 видов специальных средств. Ранее в Законе РФ от 18 апреля 1991 г. № 1026-1 «О милиции» (далее Закон «О милиции») разрешалось использование 10 видов специальных средств. Думается, что в недавно принятом отечественном Законе «О полиции» учтено многообразие современных форм и методов преступной деятельности и содержатся эффективные правовые механизмы противодействия. Анализ данного закона и его проецирование на общественные отношения, возникающие в сфере исполнения уголовных наказаний, позволит поднять соответствующие правовые институты на более высокий уровень, адекватный современным реалиям и криминальным угрозам.

В феврале 2012 года автором проведено исследование указанных проблем среди сотрудников учреждений и органов уголовно-исполнительной системы из 28 регионов Российской Федерации: Республики: Дагестан Мордовия, Тыва, Чеченская Республика, Пермский край, Архангельская, Астраханская, Владимирская, Воронежская, Ивановская, Калужская, Костромская, Курганская, Курская, Московская, Мурманская, Нижегородская, Оренбургская, Орловская, Пензенская, Псковская, Рязанская, Свердловская, Смоленская, Тамбовская, Тульская, Ярославская области, г. Москва.

На вопросы анкеты по исследованию проблем применения и использования физической силы, специальных средств и оружия ответили более 60 практических работников различного уровня; от руководителей исправительных учреждений (ИУ) до рядовых сотрудников отделов безопасности, режима и охраны.

Участие сотрудников в контртеррористических и специальных операциях обусловливает необходимость наличия в арсенале сотрудников УИС широкого спектра специальных средств. Одним из таких специальных средств должно стать средство принудительной остановки транспорта[1], способствующее эффективной нейтрализации действий злоумышленников (освобождение заложников, задержание преступников, остановка транспорта, начиненного взрывчатыми веществами и т.д.). Данное средство не предусмотрено в Законе Российской Федерации от 21 июля 1993 г. № 5473-1 «Об учреждениях и органах, исполняющих уголовные наказания в виде лишения свободы». По всей видимости, законодатель не включил данное средство в закон ввиду того, что учреждения уголовно-исполнительной системы и органы внутренних дел, на тот момент находились в составе одного министерства, у последних оно имелось на вооружении[2], а в правоприменительной деятельности учреждений и органов уголовно-исполнительной системы было востребовано редко. Находясь в составе одного министерства, сотрудники УИС в необходимых случаях могли в любое время без дополнительных согласований «позаимствовать» данное средство. В настоящее время такое «заимствование» требует соблюдения определенного количества административных процедур, занимающих время и силы,

---

[1] В частности ст. 14 Закона Российской Федерации от 18 апреля 1991 г. № 1026-1 «О милиции» предусматривала в соответствующем перечне средства принудительной остановки транспортных средств.

[2] В частности ст. 14 Закона Российской Федерации от 18 апреля 1991 г. № 1026-1 «О милиции» предусматривала в соответствующем перечне средства принудительной остановки транспортных средств.

что в условиях скоротечности специальной операции может быть недопустимо. Особенно острая ситуация может сложиться в исправительных учреждениях, находящихся в удаленности от органов внутренних дел, когда из-за согласований и перевозки может быть потеряно «драгоценное» время. В условиях специальной операции, такая удаленность может крайне негативно сказаться на ее эффективности.

Автор предлагает включить в ст. 30 данного Закона РФ пункт 7, наделяющий сотрудников УИС правом применять специальные средства: «для остановки транспортного средства при пресечении массовых беспорядков, групповых нарушений общественного порядка осужденными и лицами, содержащимися под стражей, а также задержания лиц совершающих или совершивших преступления», а также включить в перечень специальных средств – средства принудительной остановки транспорта. При проведении анкетирования сотрудники УИС за данное предложение высказались следующим образом: Да – 75,4 %, Нет – 4,9 %, Затруднились ответить – 19,7 %.

В условиях современной криминогенной ситуации, совершенствования форм и методов преступной деятельности, возникновения новых угроз, в том числе и террористических настоятельно возникает необходимость расширить перечень оснований применения огнестрельного оружия сотрудниками УИС. Пример, нападение на объекты уголовно-исполнительной системы в г. Нальчике в октябре 2005 года. В Законе РФ «Об учреждениях и органах, исполняющих уголовные наказания в виде лишения свободы» нет прямого указания на место, где возможно применение оружия сотрудником для задержания лица, оказывающего вооруженное сопротивление. Исходя из этого, можно предположить, что он как представитель власти, может применить оружие не только при осуществлении служебных обязанностей на территориях учреждений, исполняющих наказания, прилегающих к ним территориях, на которых установлены режимные требования, и на охраняемых объектах, но и в иных местах и ситуациях. Однако предположение не является конкретным правилом, регламентирующим данные правоотношения. В этой связи предлагается расширить перечень оснований использования огнестрельного оружия сотрудниками УИС.

Статья 31 Закона предполагает использование огнестрельного оружия для остановки транспортного средства, с использованием которого совершается побег осужденным или заключенным. На наш взгляд, в современных условиях указанного основания для принудительной остановки транспортного средства с использованием огнестрельного оружия явно недостаточно. Огнестрельное оружие для остановки транспортного средства сотрудниками УИС может использоваться в условиях контртеррористической и специальной операции, при внешнем нападении на объекты УИС и прилегающей к ним территории, а также в иных случаях, когда управляющее им лицо своими действиями создает угрозу жизни, здоровью граждан, объектам уголовно-исполнительной системы. Таким образом, видится целесообразным дополнить ст. 31 Закона РФ «Об учреждениях и органах, исполняющих уголовные наказания в виде лишения свободы» п. 2 в следующей редакции «для остановки транспортного средства путем его повреждения, если управляющее им лицо своими действиями создает угрозу жизни, здоровью граждан, объектам уголовно-исполнительной системы». С авторской позицией согласно большинство опрошенных нами респондентов. Так, 86,9 % согласились с включением указанной нормы в действующее законодательство, ответили отрицательно – 4,9 %, затруднились с ответом 8,2 %.

Статья 15 «Применение и использование огнестрельного оружия» Закона «О милиции» предусматривала использование огнестрельного оружия для обезвреживания животного, непосредственно угрожающего жизни и здоровью людей. Аналогичная норма предусмотрена и в Законе «О полиции», в статье 23 которого «Применение огнестрельного оружия» предполагается применение огнестрельного оружия для обезвреживания животного, угрожающего жизни и здоровью граждан и (или) сотрудника полиции. Анализ данных положений приводит авторов к выводу о наличии двух существенных проблем в деятельности учреждений и органов УИС. Первая проблема носит терминологический характер и заключается в том, что в недавно принятом Законе «О полиции» понятие «использование огнестрельного оружия» отсутствует. Вторая проблема заключается в том, что в Законе РФ «Об учреждениях и органах, исполняющих уголовные наказания в виде лишения свободы» ряд оснований для применения и использования огнестрельного оружия отсутствует, что не соответствует современным общественным отношениям в правоохранительной сфере.

Таким образом, тенденция современного законодательства в сфере правоохранительной деятельности заключается в отказе от термина «использование огнестрельного оружия», заменив его термином «применение огнестрельного оружия».

В этой связи автор полагает, что законодательство в сфере правоохранительной деятельности должно носить унифицированный характер, по крайней мере, в области юридических дефиниций. С этой целью предлагается исключить из Закона РФ «Об учреждениях и органах, исполняющих уголовные наказания в виде лишения свободы» термин «использование огнестрельного оружия».

## ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ОНОГДУУЛАХ ХАРИУЦЛАГА: 1921-1990 ОНЫ ҮЕИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ХҮРЭЭНД АВЧ ҮЗЭХ НЬ

*Н.Мөнхзул: ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

1921 онд Ардын хувьсгал ялжтухайн үед Монгол орон “социализм”-д хүрэх чиг баримжааг сонгон түүний онол, үзэл баримтлалын дагуу түүнд тохирсон нийгэм, улс төр, эдийн засгийн зохих тогтолцоог бүрдүүлэхийн тулд өөртөө тохирсон эрх зүйн үндсийг бий болгох зайлшгүй шаардлага бий болсон. Энэ л үүднээс нийгмийн харилцааг ерөнхийлөн зохицуулах хуульчилсан актуудыг шинээр батлан гаргажээ.

Шинэ эрх зүйн ололттой буюу түүхэнд гүйцэтгэсэн үүрэг нь дундад зууны үеийн нийгэм төрийн байгуулал, эрх зүйн журмыг халах зорилтыг хангахад чиглэсэн шинэ эрх зүйн хэм хэмжээгээр илэрч байсан юм. Тухайлбал, шүүн таслах ажиллагаатай холбоотой 1921 оны 07 дугаар сарын 30-ны Ардын засгийн газрын 8-р хурлаар Эрүү шүүлтийн тухай тогтоол гаргасан ба уг тогтоолын[1] аравдугаар зүйлд “Монгол хүн гэрээ, гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх ба хэрэв өчиг илрэхгүйд хүрвэл шүүлтийн зохисы нь үзэж хэвээр хэмнэн хэрэглүүлэхээр тогтов” гэснээр манжийн дарлалд байх үеийн хатуу ширүүн эрүү шүүлтийн үйлчлэл, албан тушаалтны үйлдлийг хязгаарласан.

1925 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын 42 дугаар хурлаар улс төр, эдийн засгийн онц аюултай гэмт хэрэг таслан шийтгэх эрхтэй цаг зуурын шүүхийг байгуулж Шүүх явдлын яамны дүрэм, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар 20 зүйл бүхий “Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийтгэх газрын түр дагаж явах дүрэм”-ийг батлан гаргаж мөрдүүлснээр төрийн албан тушаалтнууд гадны хүчний шууд оролцоотойгоор үндэсний сэхээтнүүдийг үй олноор хэлмэгдүүлж,[2] үүнийхээ төлөө ямар нэгэн хариуцлага хүлээгээгүй юм.

Гэсэн ч 1926 онд батлан гаргасан шүүх цаазын бичигт[3] аливаа албаны хүн эрх тушаалдаа эрдэж албаны үйл хэргийг саатуулах, боогдуулах, бусдын амгалан тайванг байдлыг алдагдуулах, ашгийг хичээж хууль зөрчих, айлган сүрдүүлж дарлах, аливаа хэргийг байцаах, шүүхдээ эрх хэмжээгээ хэтрүүлэх, албаны нэр хүндийг гутаах, шүүн таслах газрын түшмэд ашгийг хичээж шударга бус тогтоол гаргах, албан тушаалтан хууль бусаар нэг нэгнийг баривчлах, хэрэгтэнг дарлаж айлгах, өлсгөх зэргээр эрүү шүүлж хэрэглэж өчиг мэдүүлэг авах, нууц задруулах, албан үүргээ үл биелүүлэх, аливаа албан хаагчид ашгийг хичээж худалдаа арилжааны зэрэг албан тушаал дор үл нийцэх ажил явдал үйлдэх зэргийг гэмт хэрэгт тооцож хөрөнгө хураах, 10 төгрөгөөс дээш хэмжээтэй торгох, тушаалаас огцруулах БНМАУ-ын нутгаас хөөн зайлуулах, шүүхээс донгодох, гянданд хорих, зэрэг хариуцлагыг оногдуулахаар заасан байна.

Энэ цаазаар алба хаагчид элдэв арга хэрэглэн бусдаас эд хахууль авах тухай зөвлөлдөх, авах, энгийн бэлэг ба шагнал хэмээх зэргээр нэрийдэж эд хахууль авах зэрэгт гянданд хорих, хувийн хөрөнгө хогшлыг бүрэн буюу заримыг хураах тухай заагаад энэ хэргийн улмаас улсын санхүүд хохирол учруулах, урьд эд хахууль авч шийтгэгдсэн, олон удаа эд хахууль авсан боловч илрээгүй байсан, айлган хяхаж авсан зэргийг хүндрүүлэн авч үзэж байсан байна.

Мөн дээд тушаалын болон төв газраас томилсон түшмэд, шүүн таслах газрын түшмэд, байцаагч, ардын төлөөлөгчид, дотоодыг хамгаалах газрын эрх баригчид ба байцаагч, төлөөний хүмүүс, цагдан сэргийлэх газрын түшмэд цагдаа нар ба гяндангийн газрын алба хаагчид, манах сахих цэрэг, хуягууд болох аваас 5-10 жил хүртэл гянданд хорьж, эд хөрөнгийг албадан хураавааc зохино хэмээсэн нь албан тушаалын зэрэглэлтэй уялдуулан хариуцлага тооцохоор зохицуулжээ.

Тэрчлэн улсын ба ард олны хөрөнгө хогшлоор байгуулагдсан газрын тэргүүлэгчид ба тэдний орлогчид, мөнхүү газруудын төлөөний хүмүүс аливаа аж үйлдвэрийг муугаар явуулах ба ноогдсон албан тушаалыг хайхраагүйгээс уг газруудад хохирол учруулвал гянданд хорих, хувийн эд хогшлоос нөхөн төлүүлэх шийтгэл оногдуулахаар заасан байна.

Дээрхээс гадна 1928 онд “Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газрын дүрэм”[4]-ийг

---

[1] Б.Баярсайхан нар. Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон /1911-2008/. УБ., 2008. 50 дахь тал.

[2] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 234-235 дахь тал.
Тэрчлэн 1937-1938 онд лам нарыг үндсэнд нь, нам, засгийн болон Ардын хувьсгалт цэргийн дээд албан тушаалтнуудыг сорчлон баривчилж, хэлмэгдүүлсэн. Энэ үед гэмгүй иргэдийг улс төрийн хилс хэргээр баривчлах, хорих, цаазаар авах явдал жирийн үзэгдэл болсон байна.

[3] Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл /III боть/. УБ., 2010. 39 дэх тал

[4] Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн

баталжЦагдан сэргийлэх газрын албан хаагчдын сахилга журмын тухай 5-р бүлгээр:

- Цагдан сэргийлэх газрын албан хаагчид, ардын засгийн үндсэн бодлого ба тогтсон хууль дүрмийг ёсчлон дагаж, тус газар орон ба ард олныг сахин хамгаалж, амгалан аж төрүүлэх явдлыг чухал зорилт болгох бөгөөд элдэв хорлолтой, харшлалтай зүйлийг эрхбиш урьдаас сэргийлэн мэдэж, ард олонд хохирол хөнөөл болгохгүйг нэн чухалчилбал зохино.
- Аливаа гажуу самуун явагчдыг ятган хориглож, гэмт явдлыг үл үйлдүүлэхийг хичээвэл зохино.
- Хааяа бусад хүнтэй тэмцэлдэх хэрэг тохиолдвол эрхбиш урьханаар ятган ухуулбал зохино. Дэмий уурсах буюу гар хөдөлгөн жанчих, хараах зэрэг зүй бусаар явж хэрхэвч үл болно.
- Санамсаргүй гэнэт түргэн чухал хэрэг учир тохиолдож, гамгүй шулуун шударга өөр бусдын бие, хөрөнгөнд хорлолтойгоор халдах эсэргүүцэх этгээд гарваас юуны өмнө шаламгайлан урагш давшиж, тушаал сахилгыг хүндэтгэн гүйцэтгэвэл зохино. Ухран зайлсхийж хэргийн тухай алдагдуулахад хүргүүлж хэрхэвч үл болно.
- Аливаа чихээр сонссон ба нүдээр үзсэн явдалд хэрэв цагдан сэргийлэх тушаалын хэрэгт холбогдохыг нь бол магадыг хянаж тухай бүр зохих газраа тодорхойлон мэдүүлбэл зохино хэмээн цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд хориглох

Явдал хичээлийн тухай зургадугаар бүлгээр:

- Цагдан сэргийлэгчид тус тусдаа цэвэр ичимтгийгээр биеэ сахиж явбал зохино. Ашигт шунахайрах буюу эд хөрөнгө сүйтгэж, өр ширэнд нэхэмжлэгдэх зэргээр тушаал нэрийг гутаах явдлыг машид цээрлэвэл зохино.
- Уулж согтуурах буюу бусадтай мөрийцэж наадах зэргээр зүй бус явж хэрхэвч болохгүй.
- Бусдыг төлөөлөн мөнгө зоос зээлдэх буюу завсар дор батлах ба зарга зальхайн хэрэгт хамааран холбогдох зэргийг бүрмөсөн цээрлэвэл зохино.
- Өөр өөрийн тушаалын доторхи явбал зохих элдэв хэрэгт бусдаас гавьяа эрж, тал бэлэг нэхэмжлэх буюу юм хүлээн авч хэрхэвч үл болно.
- Цагдан сэргийлэх газрын албан хаагчид сахилга дүрмийг зөрчиж зүй бус явах буюу эд хахууль авбал цаазны бичигт заасан ялын аль нэгэн хүндийг нь баримтлан шийтгэгдэнэ гэсэн нь сахилгын зөрчлийн төрлүүдийг тодорхойлж түүнд шүүх цаазын бичгийн холбогдох заалтын хүнд хариуцлагыг оногдуулахаар заажээ.Хэдийгээр дүрмээр зарим албан тушаалтны сахилга, ёс зүйн талаар заасан боловч оногдуулах хариуцлага нь эрүүгийн хариуцлага байхаар зохицуулсан нь тодорхой тэр дундаа цагдаагийн албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэлийг нилээд тодорхой зааж өгснийг харуулж байна.

1934 оны шүүх цаазын бичгийг батлахдаа өмнөх заалтуудад нэмж албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэн, урвуулан, албаны үүргээ эс гүйцэтгэх, албан тушаалтан хуурамч бичиг баримт үйлдэх, албаны хувьд мэдсэн задруулж үл болох нууцыг задруулах зэрэг үйлдлийг шинээр нэмж, буудан алах, хорих, албадан ажил хийлгэх, улс төрийн болон хувийн зарим эрхийг 1-5 жил хасах, нутаг зайлуулах буюу, нутаг зааж суулгах, албан тушаалаас огцруулах буюу ажлаас хөөх, донгодох буюу олон нийтийн өмнө буруутгах, хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах, мөнгө торгох, учруулсан гэм хорыг арилгах хариуцлагыг оногдуулахаар заасан нь хариуцлагын төрөлд зарим өөрчлөлт оруулсан нь харагдаж байна.

1940 онд Монгол улс нь шинэ Үндсэн хуулийг баталсан бөгөөд 1942 онд Эрүүгийн хууль батлагдахад албан тушаалын гэмт хэрэгт өөрчлөлт ороогүй байна. Харин 1961 оны эрүүгийн хуульд албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, албан үүргээ биелүүлэхгүй байх буюу хариуцлагагүй хандах, хээл хахуул авах, өгөх зуучлах, хуурамч бичиг баримт үйлдвэл хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, албан тушаал эрхлэхийг хориглох буюу олон нийтийн өмнө буруушаах, хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах зэрэг ял оногдуулахаар заасан байна.

Энэ хугацаанд мөн нийгмийн хөгжлийн шаардлагаар 1986 оны эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж албаны бүрэн эрхээ хэтрүүлэх, албан үүрэгтээ хайнга хандах, хээл хахууль авах, хуурамч баримт бичиг үйлдэх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах, гэм буруугүй хүнийг эрүүгийн хариуцлагад татах, илт хууль бусаар баривчлах, албадан саатуулах, хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал гаргах, мэдүүлэг өгөхийг албадах зэргийг гэмт хэрэгт тооцож эдгээр үйлдлүүдэд албан тушаал эрхлэх эрхийг хасах, хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, торгох, хөрөнгө хураах, хорих ялыг оногдуулахдаа нутаг заах зэрэг ял оногдуулахаар зохицуулсан байна.

Энэ хуульд шинээр орсон зохицуулалт бол “Шүүхээс гарсан шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан биелүүлээгүй бол 1500 хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэхээр зохицуулсан албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх нөхцлийг хязгаарласан зохицуулалт болсон байна.

Түүнчлэнэнэ үед БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэм батлагдаж сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэлийг[5] тодорхойлсноос гадна иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах баталгаа нь ажилтан алба хаагчдыг хууль бусаар ажлаас халсан, ажилд авахаас хууль бусаар татгалзсан үйл ажиллагааг арилгах явдал[6] гээд тус хуулийн 201-р зүйлд зааснаар ажлаас халсан тушаалыг

эмхтгэл /III боть/. УБ., 2010. 102 дахь тал

[5] БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль

[6] И.Дашням “Сахилга, хариуцлага, эрх зүй”. УБ., 1984. 45 дахь тал

хүчингүй болгож[7], 205-р зүйлд заасныг бусдыг хууль бусаар ажлаас халсан гэм буруутай албан тушаалтнуудад тэдний 3 сар хүртэл хугацааны цалингаар материалын хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Харин хөдөлмөрийн сахилгыг хангах нэг арга бол сахилга, дэг журам зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх явдал бөгөөд энэ хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон.

- Сахилгын арга хэмжээ /Сахилгын арга хэмжээ гэж дотоод журам, сахилгын дэг журмыг зөрчсөн ажилчин, албан хаагчдад үйлдвэр, албан газар, байгууллагын тушаал, шийдвэрээр ногдуулах арга хэмжээг хэлэх ба үүнд ажлаас хожимдох, таслах, технологийн журам зөрчих, ажлын цагт сэлгүүцэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан журмуудыг зөрчих буруутай үйл ажиллагаанууд багтана. Сахилгын арга хэмжээнд БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн 119-р зүйлд заасан сануулах, донгодох, хатуу донгодох, 3 сар хүртэл хугацаагаар бага цалинтай ажилд шилжүүлэх буюу албан тушаал бууруулах, ажлаас халах арга хэмжээнүүд багтана/.
- Олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ /Олон нийтийн шүүхэд шилжүүлэх дүрэмд заасан арга хэмжээ ногдуулах, МҮЭ, МХЗЭ-ийн зохих байгууллагаар хэлэлцэн, тэдгээрийн дүрэмд заасан арга хэмжээг хүлээлгэх зэрэг. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 7-р сарын 22-ны өдрийн 170-р зарлигт зааснаар ажлын нэг жилийн дотор 2-оос доошгүй удаа сахилгын арга хэмжээ авагдсан боловч хөдөлмөрийн сахилга дахин зөрчсөн, эсвэл ажлын 2 өдөр дараалан ажил тасалсан ажилчин, албан хаагчийг олон нийтийн шүүх хүлээн авч 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар уг ажлын газарт нь засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэж, цалингийн 5-15 хувийг суутган улс орлогод оруулах эрхтэй байдаг байна/.
- Бусад арга хэмжээ
  - o Олон нийтийн шүүхээс арга хэмжээ авагдсан боловч хөдөлмөрийн сахилгыг дахин ноцтой зөрчсөн мөн дараалан 2 өдрөөс дээш хугацаагаар ажил тасалсан, түүнчлэн албан байгууллагын ажлыг дүр зоргоороо орхиж явсан ажилчин, албан хаагчийг шүүх 1 жил 6 сар хүртэл хугацаагаар уг газарт нь засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэж, цалингийн 10-25 хувийг суутган улсын орлогод оруулах /энэ нь эрүүгийн ял шийтгэлийн нэгэн адил тооцогддог/
  - o Ажил тасалсан хоногийн тоогоор ээлжийн амралтыг хасах эсвэл ажил тасалсан цаг, өдрийн тоогоор цалин олговол зохих хугацааг хорогдуулах /энэ нь гэм буруутай ажилчин, албан хаагчдад хүлээлгэж буй хариуцлага биш юм/
  - o Ажил тасалж арга хэмжээ авагдсан хүмүүсийг ажил, албан тушаалд дэвшүүлэхэд, хөдөлмөрийн хамт олны үнэлэлт, хүсэлт, тодорхойлолт авах[8]

Албан хаагчийг төрийн албаны болон хөдөлмөрийн сахилга ноцтой зөрчсөний учир ажлаас халах нь сахилгын эцсийн арга хэмжээ болж байв.

Албан үүргээ зөрчсөн албан хаагчийн хүлээх сахилгын хариуцлагын арга хэмжээнүүд үндсэндээ ижил боловч Ардын хяналт шалгалтын хууль, улсын хяналтын болон сахилгын тусгай дүрэм зэрэгт үндэслэл, журмын хувьд өвөрмөц байдлаар тусгагдаж байжээ. Эдгээр нөхцөл байдалтай уялдан төрийн албан хаагчдад сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой байсан байна. Тухайлбал;

а/ дотоод дүрэмд заасны дагуу;

в/ сахилгын тусгай дүрэмд зааснаар арга хэмжээ авах гэж ангилагдаж байна.

Эдгээрээс тухайн үеийн онцлог зохицуулалт нь захирах захирагдах журмаар сахилгын хариуцлага хүлээлгэх явдал юм.

Энэ гол төлөв удирдах албан тушаалд хамааралтай бөгөөд ажлын газрын захиргаанаас биш, харин тухайн ажилтан шууд харьяалж захирах дээд байгууллагаас нь сахилгын шийтгэл оногдуулахыг хэлнэ. Үүний жишээ нь, Сайд нарын Зөвлөл яамны сайд, улсын хороо, өөртөө харьяалагдах бусад байгууллагын дарга болон тэдгээрийн орлогчдод сахилгын арга хэмжээ авч болохоор заасан зохицуулалтаас харагдах юм. Харин сахилгын тусгай дүрмийн хувьд төрийн албаны зарим салбарт эрх бүхий байгууллагаас баталсан сахилгын тусгай дүрэм дагаж мөрдөх нь бий. Тухайлбал; “Төмөр замын ажилчин, албан хаагчдын сахилга батын дүрэм”, “БНМАУ-ын зэвсэгт хүчний сахилга батын дүрэм”, “БНМАУ-ын шүүгчдийн сахилга батын дүрэм” гэх мэт байжээ. Тухайлбал, 1954 оны Шүүгчийн сахилга батын коллегийн дүрэм, 1970 оны БНМАУ-ын шүүгч нарын сахилга батын хариуцлагын дүрмийг дурдаж болох юм.

Энэ дүрмээр албан ажлын ямар нэгэн эндэгдэл, зан авирын зохимжгүй явдлууд нь шүүхийн нэр хүндийг гутаадагаар барахгүй, шүүн таслах явдал, улсын ашиг сонирхол, ард иргэдийн эрхэнд хор хүргэдэг учраас тийм явдлыг гаргасан шүүгчдэд хатуу хариуцлагыг хүлээлгэнэ гээд хөдөлмөрийн сахилга батыг гажуудуулсан хэрэгт, шүүхийн ардчилсан зарчмыг зөрчсөн, удирдлагын тушаал, даалгаврыг шуурхай биелүүлээгүй буюу шүүгчийн нямбай биш ажиллагаа хийгээд сахилга батгүй явдлын улмаас шүүх таслах ажилд гарсан дутагдлын хэрэгт, шүүгчийн алдар хүндэд зохимжгүй явдлуудыг үйлдсэн хэрэгт сануулах, донгодох, хатуу донгодох, хэрэв шүүгчийг ээлж

[7] БНМАУ-ыын Хөдөлмөрийн хуулийн 201-р зүйлд зааснаар Ардын шүүх хянан шийдвэрлэх ба 98-р зүйлд зааснаар хууль бусаар халагдсан ажилчин, албан хаагчдыг хуучин ажилд нь эргүүлэн тогтоож 3 сар хүртэл хугацааны цалинг олгох талаар шийдвэр гаргадаг.

[8] БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 7-р сарын 22-ны өдрийн 170-р зарлиг

байгаа тушаалдаа тохирохгүй гэж үзвэл, тэр шүүгчийг хуульд тогтоосон журмаар огцруулах тухай асуудлыг тавиулахаар шүүх яаманд мэдэгдэх хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Мөн сахилгын хариуцлага оногдуулах процессыг ч орхигдуулаагүй байна.

1970 онд уг сахилгын дүрмийн шинээр баталж шүүхийн ардчилал зөрчих, эрүү, иргэний болон байцаан шийтгэх хуулийг зөрчиж, социалист хууль ёс гажуудуулах, албан байгууллага, хөдөлмөрчдийн өргөдөл, гомдолд шуурхай бус хандаж чирэгдүүлэх үйлдлийг нэмж зөрчилд тооцон албан тушаалаас нь 6 сар хүртэл хугацаагаар огцруулж дорд тушаалын ажилд шилжүүлэх санал тавих гэж хариуцлагын төрлийг нэмэгдүүлсэн байна. Хариуцлага оногдуулахдаа гэм буруугийн хэр хэмжээ, уршиг, холбогдол зэргийг харгалзан үзэж хариуцлагын төрлөөс сонгож хэрэглэхийг заасан байна. Харин хариуцлага оногдуулах процесст төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна.

Хөдөлмөрийн хуулиар сахилгын хариуцлага хүлээлгэхээс гадна материалын хариуцлага хүлээлгэх зохицуулалт байсан. Үүргээ биелүүлэхдээ үйлдвэр, албан газар, байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилчин, албан хаагч шууд учирсан жинхэнэ хохиролын хэмжээгээр эд материальн хариуцлага хүлээх боловч тэр нь уг хүний нэг сарын цалингийн хэмжээнээс хэтэрч үл болно.

Нэг сарын цалингаас илүү хэмжээгээр зөвхөн хууль тогтоомжид заасан тохиолдолд оногдуулна. Мөн ажилчин, албан хаагчийн учруулсан хохирол гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоосон байвал, ажилчин, албан хаагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байх үед үйлдвэр, албан газар, байгууллагад учруулсан хохирлыг бүрэн хариуцуулахаар тусгай хууль тогтоолд заасан байвал, мөнгө буюу барааны холбогдолтой зүйл хариуцдаг тусгай жагсаалтад заасан албан тушаалын ажилтан, үйлдвэр, албан газар, байгууллага хоёрын хооронд уг ажилтан хадгалах буюу тогтоосон норм дээрээ нэмэн хариуцаж авсан үнэ бүхий зүйлээ дутагдуулбал эд материалын бүрэн хариуцлага хүлээхээр бичгээр тусгай гэрээ байгуулсан бол, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ тухайн хохирлыг учруулсан бол эд материалын бүтэн хариуцлага хүлээдэг.

Эд материалын хариуцлага хүлээлгэхэд сахилгын буюу олон нийтийн арга хэмжээ авахуулсныг харгалзан үздэггүй.

Олон нийтийн арга хэмжээ гэж олон нийтийн шүүхийн дүрэм[9], эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олны зөвлөлийн дүрмээр[10] хариуцлага оногдуулахыг хэлэх ба улс, олон нийтийн хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулагчид, ууж согтуурсан хүмүүс, ажлын цаг таслагчдыг урьдчилсан бүртгэлд авч хурлаараа хэлэлцдэг[11] бол олон нийтийн шүүхийн дүрмээр

- хүндэтгэх шалтгаангүйгээр ажил тасалсан, ажилд согтуу ирсэн, ажлаас хожимдсон, эрт явсан, түүнчлэн бусад хэлбэрээр хөдөлмөрийн сахилгыг зөрчсөн болон үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан
- хөдөлмөр хамгаалал / аюулгүй ажиллагааны арга техник, үйлдвэрлэлийн ариун цэвэр, хөдөлмөрийн эрүүл ахуй/-ын болон галын аюулаас хамгаалах тухай дүрэм, зааврын шаардлагыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
- түүхий эд, материалыг тогтоосон нормоос хэтрүүлэн зарцуулсан буюу гологдол бүтээгдэхүүн гаргасан, түүнчлэн эрхэлсэн ажилдаа хайхрамжгүй хандсанаар тоног, төхөөрөмж, машин, багаж хэрэгсэл зэрэг улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын эд хөрөнгийг эвдэж гэмтээсэн, үрэгдүүлсэн, малтай хайр гамгүй, хатуу харьцсан үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
- улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуйн төхник, суурь машин, тоног төхөөрөмж багаж хэрэгсэлболон эд хөрөнгийг хувийн хэрэгцээнд дур мэдэн ашигласан нь эрүүгийн хариуцлага хулээлгэхээргүй бол
- жижгээр танхайрсан, дамын худалдаа бага хэмжээгээр хийсэн, түүнчлэн иргэдийн амины үнэ багатай зүйлийг анх удаа хулгайлсан /буруутан, хохирогч хоёр нэг хамт олны дотор байх тохиолдолд/ хэргийг шүүх, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллага буюу сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас олон нийтийн арга хэмжээ авахуулахаар шилжүүлэн ирүүлбэл
- эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй
- эмэгтэйчүүдтэй буюу эцэг, эхтэйгээ зүй бусаар харьцсан гэр бүлийн дотор зохисгүй байдал гаргасан
- бусдыг доромжилсон, гүтгэсэн, гэмтэл учруулахгүйгээр зодсон, түүнчлэн бусдад хөнгөн гэмтэл учруулсан зэрэг үйлдлийг анх удаа үйлдсэн бөгөөд хохирогч нь шүүх, мөрдөн байцаах байгууллагад гомдол гаргаагүй бол
- нийтийн байр, орон сууцны ашиглалт, ариун цэврийн дүрмийн шаардлага зөрчсөн, түүнчлэн орон сууцны болон бусад барилга, нийтийн аж ахуйн байгууламж, тоног төхөөрөмж, мод, бут, сөөг, зүлгийг гэмтээсэн
- иргэдийн хооронд үүссэн 200 хүртэл төгрөгийн эд хөрөнгийн маргааныг олон нийтийн шүүхээр шийдвэрлүүлэхийг уг иргэд хүсвэл
- захиргааны журмаар торгууль оногдуулж зөрчилтэй хэргийг матөриаллаг эрх бүхий байгууллага, албан

[9] 1982 оны БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар батлагдсан дүрэм

[10] 1981 оны БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор батлагдсан дүрэм

11 шаардлагатай гэж үзвэл тэдний эцэг, эх, гэр бүлийн бусад гишүүд, хамт олны нь төлөөлөгч, удирдах хүмүүсийг урьж оролцуулна

тушаалтнаас олон нийтийн шүүхэд хэлэлцүүлэхээр шилжүүлсэн болнийгэмд хор аюул багатай хэргийг анх удаа үйлдсэн этгээдийн материалыг шүүх, прокурор, мөрдөн байцаах байгууллагаас хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн ирүүлсэн бол зэрэг үйлдэлд хамт олноороо буюу хохирогчоос олны өмнө уучлал гуйхыг үүрэг болгох, нөхөр ёсоор сануулах, хамт олны өмнө буруушаах, хэвлэлд нийтлэх буюу нийтлүүлэхгүйгээр донгодох, зөрчсөн хэрэгт холбогдолгүй бол 25-100 хүртэлтөгрөгөөр, хэрэв жижгээр танхайрсан, анх удаа бага хэмжээгээр дамын худалдаа хийсэн бол 50-200 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

Хөдөлмөрийн сахилга зөрчсөн этгээдэд олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ авахын зэрэгцээ дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу бага цалинтай ажилд шилжүүлэх буюу албан тушаал бууруулах, бусад арга хэмжээ авахуулах тухай саналыг үйлдвэр албан газар, байгууллагын захиргаанд тавих,хэрэв хууль тогтоомжоор олон нийтийн шүүхэд тусгайлан эрх олгосон бол хөдөлмөрийн сахилга зөрчсөн этгээдэд ажиллаж байгаа газарт нь хууль тогтоомжийн заасан хугацаагаар заасан хүмүүжүүлэх ажил хийлгэх арга хэмжээ оногдуулна.

Мөн хөнгөлөлттэй үнээр амралт, сувиллын газар явах бичиг, шагнал, урамшил олгохыг татгалзах, орон сууц олгох дараалын хойшлуулах тухай, түүнчлэн бусдыг хүмүүжүүлэх үүрэг бүхий буюу нийгмийн өмч хөрөнгийг хариуцсан этгээдийн гаргасан зөрчил нь үүрэгт ажилтай нь холбоотой бөгөөд цаашид уг ажилд хэвээр ажиллуулах найдваргүй гэж үзвэл зөрчил гаргагчийг ажлаас нь өөрчлөх тухай саналыг үйлдвэр, албан газар, байгууллагын захиргаанд тавьж болно.

Төрийн албан хаагчдын ангиллын хувьдажиллаж байгаа байгууллагын системээр АДХ-ын ажилтан, захиргааны байгууллагын ажилтан, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, мөн захиргааны салбар байгууллагын ажилтанг аж ахуйн удирдах байгууллагын ажилтан нийгэм, соёлын удирдах байгууллагын ажилтан, захиргаа-улс төрийн байгууллагын ажилтан гэх зэргээр ангилж бүлгэлжээ. Харин албан хаагчдыг тухайн байгууллагад эзэлж байгаа байр суурь албан ажлын хууль зүйн шинж чанарыг харуулахын тулд эрх хэмжээгээр нь

1/албан тушаалтан

2/туслах буюу техникийн гүйцэтгэх ажилтан гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваагдаж байжээ.

Өөрөөр хэлбэл өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ангилагдсан төрийн улс төрийн, захиргааны, үйлчилгээний гэх шууд ялгамжай тодорхойлсон ангилалт байхгүй, төрийн албаны иж бүрэн тогтолцооны тухайойлголт байгаагүй юм.

Гэсэн хэдий ч энэ үед зарим албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг хууль болон дүрмээр тодорхойлсон нь албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тогтолцоо бүрдэж эхэлснийг харуулж байна.

Мөн зөрчлийн шинж байдалтай уялдан хариуцлагын төрлүүд нь эрүүгийн шинжтэй байснаа сахилгын шинжтэй болж сануулах, донгодох, хатуу донгодох, 3 сар хүртэл хугацаагаар бага цалинтай ажилд шилжүүлэх буюу албан тушаал бууруулах, ажлаас халах, хохирлыг нөхөн төлүүлэх хэмээн өөрчлөгдөж ирснээс гадна хариуцлага хүлээлгэхтэй холбоотой процессын ажиллагааг дүрмээр тодорхойлж байсан байна.

ХАВСРАЛТ СУДАЛГАА

## ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Интернетийн хэрэглээ өсөхийн хэрээр хүн төрөлхтний харилцаа илүү ойр болжээ. World Wide Web нь нийтлэг, өргөн уудам орон зайг хамардаг хэдий ч цахим ертөнц хэмээх нэг хэсэгхэн газарт хэрэглэгчид бие биетэйгээ улам бүр ойртон харилцаж байгаа нь үүний нэг онцлог юм. Харин цахим ертөнцөд хэтэрхий олон цагийг өнгөрүүлж байгаа хүмүүсийн хувьд энэ нь цахим гэмт хэрэг гарах томоохон асуудал араасаа дагуулж байна. Хууль сахиулах байгууллагууд энэ хэрэгтэй тэмцэхээр хичнээн ажиллаж байгаа ч энэ хэрэг тасралтгүй өссөөр олон хүн хортой программ хангамж, оюуны өмчийн хулгай, хувь хүний мэдээллийн хулгай, хакер зэрэгт өртсөөр л байгаа.

Цахим гэмт хэргийн хохирогч болохгүйн тулд гол, чухал мэдээллээ хамгаалах хамгийн сайн арга нь интернетээр явуулж, ашиглаж байгаа мэдээллээ баталгаатай, аюулгүй байлгах программ болон техник хангамжийн нэгдсэн систем бүхий аюулгүйн хамгаалалт хэрэглэх явдал юм.

**Цахим гэмт хэргийн үүсэл**

1990-ээд оноос компьютер болон нийтийн сүлжээ дэлгэрч эхлэх үед системийн талаар илүү мэдээлэл олж авахын тулд хакерийн үйл ажиллагаа үндсэндээ эхэлсэн байдаг. Хакерчид хамгийн сайн хакерчин болохын тулд бие биетэйгээ өрсөлдсөнөөс болж цэргийн болон худалдааны байгууллагуудын маш олон сүлжээнд хохирол учруулжээ. Анхандаа тэдгээр хакерчдын оролдлого бүтэлгүй болж байсан ч хортой программтай болсноор энэ нь тэр дороо хаа сайгүй тархаж сүлжээ, системийг гэмтээн хэвийн хурдыг удаан ажиллагаатай болгож эхэлжээ. Хакерчид илүү мэдлэг чадвар хуримтлуулахын хэрээр бусдыг мэхэлж, луйвардан ашиг олоход тэр чадвараа ашиглаж эхэлсэн байна.

**Цахим гэмт хэргийн төрөл**

Интернетээр үйлдэж байгаа ямар ч гэмт хэрэг бол цахим гэмт хэрэг юм. Олон төрлийн цахим гэмт хэрэг байж болох бөгөөд хамгийн нийтлэг төрлүүдийг энд авч үзэж байна.

**Хакерийн үйл ажиллагаа:**

Энэ нь хувь хүний компьютерт халдан хувийн болон эмзэг чухал мэдээллийг авдаг нэгэн төрлийн гэмт хэрэг юм. АНУ-д хакерийн гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт тооцон ял эдлүүлдэг байна. Хакерийн үйл ажиллагаа явуулахын тулд хэрэгтэн хувь хүний компьютерт нэвтэрч болох олон янзын программ хангамжийг ашигладаг бөгөөд тэр хүний компьютерт зайнаас хандаж байгаа учраас мэдэгддэггүй.

**Оюуны өмчийн хулгай:**

Зохиогчийн эрхийг зөрчин, хөгжим, кино, тоглоом, программ хангамж зэргийг татаж авах нь оюуны өмчийн хулгайн цахим гэмт хэрэг болно. Программ хангамжийн хууль бус ажиллагааг дэмждэг хамтын эзэмшлийн вэб хуудаснууд олон гардаг бөгөөд тэдгээрийн ихэнхийг Холбооны Мөрдөх Товчоо хяналтандаа авч ажиллаж байна. Өнөөдөр хууль эрхзүйн систем энэ цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдэж байгаа бөгөөд хүмүүсийг хууль бусаар мэдээлэл татаж авахаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомж гарсан байдаг.

**Цахимаар ангуучлах:**

Сүлжээгээр захидал зурвас их хэмжээгээр хохирогчруу илгээх нь нэг төрлийн цахим заналхийлэл дарамт юм. Ангуучид нь хохирогчоо мэдэж байдаг бөгөөд ийм хэрэг хийхдээ интернет ашигладаг байна. Гэхдээ тэдний үйлдэл нь хүссэн үр дүндээ хүрэхгүй тохиолдолд хохирогчийн амьдралыг сүйтгэхийн тулд цахим ангуучлалаа онлайн бус нөхцөлд эхлүүлдэг.

**Хувийн мэдээллийн хулгай:**

Хүмүүс интернетээр банкны үйлчилгээ хийх, мөнгө шилжүүлэх зэрэг нь ийм төрлийн гэмт хэрэг гарах гол шалтгаан болдог байна. Тухайн хэрэгтэн ийм хэрэг хийхдээ хувь хүний нэрийг ашиглан онлайнаар юм худалдан авах эсвэл мөнгө завшихын тулд тэр хүний банкны данс, зээлийн карт, нийгмийн даатгал болон дебит картны мэдээлэл мөн бусад чухал мэдээллийг ашигладаг. Энэ нь хувь хүнийг санхүүгийн маш их алдагдалд оруулахаас гадна дансны бичилт түүхийг хорлон сүйтгэдэг байна.

**Хортой программ хангамж:**

Энэ нь сүлжээг тасалдуулахад интернетээр ашигладаг программ юм. Энэ программыг тухайн хохирогчийн системд нэвтэрч хэрэгтэй чухал мэдээллээ авах, тэр системийг гэмтээхийн тулд ашигладаг.

**Хүүхдийг уруу татах, өөртөө татах:**

Бага насны хүүхдүүдтэй чатлах замаар өдөж хоргоон садар самуунд уруу татах зорилготой цахим гэмт хэргийн бас нэгэн төрөл юм. Хүүхдүүдийг садар самуунд өртөхөөс сэргийлэх, энэ явдлыг багасгах зорилгоор АНУ-ын Холбооны Мөрдөх Товчоо хүүхдүүд харьцдаг чат өрөөг байнга хянадаг байна.

**Цахим гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл**

Хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, эрсдэл бага байгаа газарт нөхцөл байдлын давуу талыг ашиглахыг хүсч буй хүмүүсийг олж харах нь чухал. Энэ л цахим гэмт хэрэг гарах нэг хэлбэр гэсэн үг. Хэрэгтэй чухал мэдээллийг ашиглана гэдэг бол их том олз бөгөөд ийм хэрэгтэнийг олоход хэцүү.

Цахим гэмт хэрэг үйлддэг хэрэгтнүүд өөрсдийн мэдлэг чадвараа шударгаар ажиллахад хэрэглэхийн оронд аль болох амар хялбар аргаар хурдан ашиг олохын тулд бусдыг хуурч мэхлэх,

тэднийг ашиглах, тэднээс мөн хулгай хийхийг зорьдог.

Өнөөдөр цахим гэмт хэрэг нь бодит аюул занал болоод байгаа бөгөөд хуучны дээрэм тонуул, хулгай хийхээс огт өөр хэрэг юм. Маш энгийн арга замаар ямар ч биеийн оролцоогүйгээр энэ хэргийг тэд үйлддэг. Гэмт этгээдүүд энэ хэргийг алсын зайнаас үйлдэж болох бөгөөд хэрэг хийж байгаа улс орныхоо хууль сахиулагч байгууллагуудаас айх, санаа зовох шаардлага тэдэнд байдаггүй. Цахимаар хэрэг үйлдэгчид нь хүмүүсийг цахим худалдаа болон онлайн шилжүүлэг хийх үед нь ашигладаг байна.

**Цахим хэргийн үйлдэх ерөнхий ангилал**

Цахим гэмт хэргийг ямар байдлаар хэрэг үйлдэж хохирол учруулж байгаагаар нь дараах гурван янзаар ерөнхийд нь ангилж авч үздэг.

*1. Хувь хүнд халдах*

Цахим ангуучлал хийх, садар самууныг сурталчлах, хүний наймаа болон хохирогчдод хэтэрхий халамж анхаарал хандуулах зэрэг нь хувь хүнд халдаж байгаа хэрэг юм. Хууль сахиулах байгууллагууд нь энэ хэрэгт маш их анхаарал хандуулдаг ба гэмт этгээдийг олох, баривчлахын тулд олон улсын хэмжээнд хүчээ нэгтгэн ажиллаж байна

*2. Бусдын эд хөрөнгөнд халдах*

Бодит амьдрал дээр хулгай дээрэм хийхтэй адил цахим ертөнцөд ч хулгай дээрмийн хэрэг гардаг. Цахим ертөнцөд хэрэгтнүүд хувь хүний банкны мэдээллийг хулгайлж мөнгө идэх, онлайнаар их хэмжээний худалдаа хийхийн тулд бусдын зээлийн карт ашиглах, бусдын хөдөлмөрлөж олсон мөнгийг завших, байгуулллагын сайтад нэвтэрч хэрэгтэй мэдээлэл авахын тулд эсвэл системийг нь гэмтээхийн тулд хортой программ ашиглах зэргээр бусдын эд хөрөнгөнд халддаг. Онлайн бус ертөнцөд бусдын эд хөрөнгийг сүйтгэдэгтэй адил хортой программ нь компьютерийн программ хангамж, болон техник хангамжийг гэмтээдэг.

*3. Засгийн газарт халдах*

Дээр өгүүлсэн хоёр хэргээс тийм нийтлэг биш ч энэ хэргийг цахим терроризм гэж хэлж болно. Хэрэв амжилттай болох юм бол энгийн ард иргэдийн дунд сандрал, үймээн самуун дэгдээх аюултай. Гэмт этгээдүүд засгийн газар, төрийн байгууллагууд, цэргийн байгууллагуудын вэбсайтад нэвтэрч хакердах, суртал нэвтрүүлэг тараах үйл ажиллагааг явуулдаг. Эдгээр этгээдүүд нь бусад улс үндэстэний террорист бүлэглэл байж болох юм.

Аль ч ангилалд хэрэг үйлдэгч нь янз бүрийн арга ашиглаж болох ба ашиглаж байгаа аргууд нь өөр байдаг байна.

**Цахим гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх вэ?**

Цахимаар гэмт хэрэг үйлддэг ихэнх этгээдүүд бие биетэйгээ чөлөөт сүлжээгээр хамтарч ажилладаг. Бодит ертөнцөөс ялгаатай нь гэмт этгээдүүд бие биетэйгээ өрсөлдөж нэгнийхээ дээр гарах гэж тэмцдэггүй. Харин ч чадвараа сайжруулахын тулд хамтарч ажиллан, өөр шинэ боломж хайн бие биедээ тусалдаг байна.

Хууль сахиулах байгууллагууд цахим хэрэгтнүүдийг алдахгүй мөшгөхийг хичээдэг ч энэ нь нилээд хэцүү ажил гэдэг нь тодорхой юм. Хууль сахиулах байгууллагууд үр дүнтэй амжилттай ажиллахыг оролдож байгаа ч гэмт этгээдүүдийн хэрэглэж байгаа арга улам нарийсч, техник технолог маш хурдацтай хөгжин өөрчлөгдөж байна. Тиймээс худалдааны болон засгийн газрын байгууллагууд өөрсдийгөө хамгаалах өөр арга зам хайх хэрэгтэй.

Кросс-ДомэйнШийдэлийн аргуудыг ашиглах нь хамгийн сайн арга. Байгууллагууд кросс домэйны аюулгүй байдлын аргыг хэрэглэхдээ мэдээлэл солилцоо нь аюулгүй байдлын дүрмийг баримталдаг гэдэгт найдах боломжтой. Энэ нь гар болон автомат дамжуулалтыг хоёуланг нь баталгаажуулж, аюулгүй байдлын тусгай ангилал дотор гарч ирэх мэдээлэлд хандалт хийдэг программ хангамж, техник хангамж бүхий нэгдсэн систем ашиглах арга юм. Тус аргыг хэрэглэснээр сүлжээ болон системийг аюулгүй хэрэглэх боломжтой.

Кросс-ДомэйнШийдэл нь аюулгүй, баталгаа бүхий домэйн ашиглан бүх мэдээллийг нууцлах чадвартай учраас худалдааны болон засгийн газрын байгууллагууд нь гэмт этгээдүүд сүлжээрүү нь орж хэрэгтэй мэдээлэлд нь хандаж тандалт хийхээс сэргийлэн энэ аюулгүйн арга шийдлийг хэрэглэдэг байна.

Ашигласан материал:

1. http://www.crossdomainsolutions.com
2. http://www.datacenter.gov.mn/
3. http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/cybercrime/
4. http://hugduudhuu.blog.gogo.mn/read/entry2371

*Орчуулсан. ХСИС-ийн Төгсөлтийн дараах сургуулийн Гадаад хэл сургалтын багийн багш, цагдаагийн ахлах дэслэгч С.Алимаа*

*С.Гантулга*
*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГИЙН БҮТЦЭД ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН ӨНДӨР ЗАРИМ ГЭМТ ХЭРГИЙГ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ТУСГАСАН БАЙДАЛ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)**

| № | Монгол Улсын Эрүүгийн хуулийн төсөл | Монгол Улсын Эрүүгийн хууль (2002 он) | Шинэлэг байдал, өөрчлөлт | Эрүүгийн хуулийн төслийн ялын санкц | Ялын интервалын өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | **17.1 дүгээр зүйл.Хулгайлах**<br>1.Бусдын хөдлөх эд хөрөнгийг нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн;<br>2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлсан;<br>2.3.ноцтой хохирол учруулсан, эсхүл их хэмжээний эд хөрөнгийг хулгайлсан;<br>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн, | **145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах**<br>145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>145.2.Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй | - Хулгайлах гэмт хэргийг **хохирлын хэмжээ шаардахгүй** буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан.<br>- **түүх, соёл,** шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлсан үйлдлийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан,<br>- Энэ төрлийн гэмт хэргийг **давтан, бүлэглэж** үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан. Учир нь хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ялгүй тооцох хугацаа өнгөрөөгүй байхдаа дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хүндрүүлэн ял оногдуулдаг. Энэ нь тухайн хүний эрх зүйн байдлыг өмнө нь хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэж дордуулж байгаа нь Эрүүгийн хуулийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь | -**Үндсэн бүрэлдэхүүн:**долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | -Хорих ялын доод хэмжээ 7 хоногт болж багассан. Хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд хорих ял оногдуулдаггүй байсныг оногдуулахаар зааж, дээд хэмжээ таван жил болж нэмэгдсэн.<br>-Гэрийн хорионд байлгах ялын шинэ төрлийг нэмж, торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг үр нөлөө багатай ялын төрлийг хассан. |
| | | | | - **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:**хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | -Хорих ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, харин дээд хэмжээ 3 жилээр нэмэгдсэн.<br>-Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг үр нөлөө багатай ялыг төрлийг хассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | машин механизм ашигласан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг:<br>3.1.байнга тогтвортой үйлдсэн;<br>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>145.4.Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн заримтай харшилж байна.<br>- Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд **байнга тогтвортой үйлдсэн буюу энэ төрлийн гэмт хэргийг амьдрах эх үүсвэрээ болгож, тогтмол үйлдэх** талаар заасан. Энэ нь энэ төрлийн гэмт хэргийг байнга үйлдэж, амьдрах эх үүсвэрээ болгосон этгээдүүдэд үйлдлийн нийгмийн аюулын шинж чанарт тохирсон хүнд ял оногдуулах боломжийг олгоно.<br>- Практикт ихээхэн маргаан үүсгэдэг **энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан** гэснийг хассан. Учир нь үүнийг хулгайлсан зүйлийн хэмжээ, үнээр бус хохирогчийн амьдралд уг зүйлийн гүйцэтгэж байсан эдийн засгийн ач холбогдлыг шалган тогтоосон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс өгөх үнэлэмжээр тодорхойлдог. Иймээс учраас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектууд субъектив хандлага гаргах байдал ажиглагддаг байв.<br>- **Ялын интервалын хувьд уян хатан байдлаар төсөлд тусгасан.** Тухайлбал, Төслийн 17.1-т заасан хулгайлах гэмт | - **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:**таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 5 жилээр багасч, дээд хэмжээ 3 жилээр нэмэгдсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгт долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Энэ нь шүүх үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанар, хохирлын хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн болон гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруугаа ухамсарлаж буй байдал зэргийг харгалзан ял оногдуулах өргөн боломж нээж өгсөн.<br>- Ялын төрлийн хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд ач холбогдолтой,шинэ төрлийн **гэрийн хорионд байлгах**ялыг төсөлд шинээр тусгасан. Харин **албадан ажил хийлгэх, баривчлах** зэрэг үр нөлөө багатай, эдлүүлэхэд хүндрэлтэй ялыг төрлийг хассан. | | |
| 2. | **11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд санаатай халдах, хөнгөн хохирол учруулах**<br>1.Хүний эрүүл мэндэд санаатай халдсан, эсхүл хөнгөн хохирол учруулсан бол нэг зуун тооцооны нэгжээс нэг мянга гурван зуун гучин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо | **99 дүгээр зүйл. Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах**<br>99.1.Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавaас | - Хүний эрүүл мэндэд санаатай халдах, хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг нь **холимог бүрэлдэхүүнтэйгээр** хуульчилсан. Учир нь хүний эрүүл мэндэд халдсан үйлдлийг хохирол шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр, хөнгөн хохирол учруулсан үйлдлийг материаллаг | **Үндсэн бүрэлдэхүүн:**нэг зуун тооцооны нэгжээс нэг мянга гурван зуун гучин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл долоо | Торгох ялын доод хэмжээ 5 дахин, дээд хэмжээ 3 дахин багассан.<br>Гэрийн хорионд байлгах болон хорих ялын төрлүүд нэмэгдэж, баривчлах ял хасагдсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хоногоос гурван сар хүртэл хугацаагаар гэрийн хориond байлгах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>99.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. | бүрэлдэхүүнтэйгээр тус тус төслийн 11.6-ын 1-т заасан.<br>-Ингэж хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан нь **хүний бие махбодийн халдашгүй байдлыг хангахад** ихээхэн ач холбогдолтой. Учир нь бусдыг зодож, бие махбодид нь халдсан боловч гэмтэл учруулаагүй гэсэн шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээдэггүй байсан тогтолцоо өөрчлөгдөнө.<br>- Энэ гэмт хэргийг **давтан** үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан.<br>- **Ялын интервалын хувьд уян хатан байдлаар төсөлд тусгасан.**<br>- Ялын төрлийн хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд ач холбогдолтой шинэ төрлийн **гэрийн хориond байлгах** ялыг төсөлд шинээр тусгасан. | хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох ялын доод хэмжээ 50 дахин, дээд хэмжээ 5 дахин багассан.<br>Албадан ажил хийлгэх, баривчлах ял хасагдаж, хорих ялын төрөл нэмэгдсэн. |
| 3. | **17.3 дугаар зүйл.Залилах**<br>1.Хуурах, баримт бичиг, эд зүйл ашиглаж, эсхүл цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэн авсан | **148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах**<br>148.1.Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг | -Залилах гэмт хэргийг **хохирлын хэмжээ шаардахгүй** буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан.<br>- Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэгдэл шинж болох үйлдлийн аргыг диспозицид **дэлгэрэнгүй хуульчилсан** нь практикт иргэний эрх зүйн зөрчлөөс энэ гэмт хэргийг ялган зүйлчлэхэд ач холбогдолтой болсон. | **-Үндсэн бүрэлдэхүүн:**нэг зуун тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар гэрийн хориond байлгах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар | Торгох ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, харин дээд хэмжээ 3 дахин нэмэгдсэн.<br>-Гэрийн хориond байлгах, хорих ялын төрлийг шинээр нэмсэн.<br>-Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг үр нөлөө багатай ялын төрлийг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бол нэг зуун тоноцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, эсхүл бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг:<br>3.1. байнга тогтвортой үйлдсэн;<br>3.2.олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;<br>3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хорин дөрвөн мянган тооцооны нэгжээс жаран мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар:<br>-Бусдын эд хөрөнгийг энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан аргаар авсан хүн уг эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчид эргүүлэн өгсөн, бусад байдлаар | хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>148.2.Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>148.3.Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>148.4.Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт | - Энэ төрлийн гэмт хэргийг **давтан, бүлэглэж**, гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан.<br>- Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд **байнга тогтвортой үйлдэх** талаар заасан. Энэ нь энэ төрлийн гэмт хэргийг байнга үйлдэж, амьдрах эх үүсвэрээ болгосон этгээдүүдийн үйлдлийн нийгмийн аюулын шинж чанарт тохирсон хүнд ял оногдуулах боломж олгоно.<br>- Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд **олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар** үйлдсэн гэх аргыг зааж өгсөн нь практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, **"сүлжээний луйвар"** үйлдэж буй этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж бүрдүүлнэ.<br>- **Ялын интервалын хувьд уян хатан байдлаар төсөлд тусгасан.**<br>- **Хуулийн тайлбар хэсэгт** "Бусдын эд хөрөнгийг энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан аргаар авсан хүн уг эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчид эргүүлэн өгсөн, | хорих ял шийтгэнэ. | хассан. |
| | | | | - **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:**арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, харин дээд хэмжээ 2 дахин нэмэгдсэн.<br>Хорих ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, харин дээд хэмжээг найм болгож, 3 жилээр нэмэгдүүлсэн. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:**хорин дөрвөн мянган тооцооны нэгжээс жаран мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын хувьд доод хэмжээ нь 5 болж, 5 жилээр багассан, дээд хэмжээ нь мөн 12 жил болж, 3 жилээр багассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эд хөрөнгийн эрхийг сэргээсэн бол залилах гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй. | бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | бусад байдлаар эд хөрөнгийн эрхийг сэргээсэн бол залилах гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй" гэж хуульчилсан. Энэ нь энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, хохирол нөхөн төлүүлэлтийг хангах, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажлын ачааллыг багасгахад эерэгээр нөлөөлөх заалт болсон. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4. | **20.19 дүгээр зүйл. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах**<br>1.Бусдад хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл эд хөрөнгө устгаж, гэмтээж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний бие махбодийн болон өмч хөрөнгийн халдашгүй байдал, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаа, хүмүүсийн харилцааны тогтсон хэм хэмжээнд халдсан бол нэг зуун тооцооны нэгжээс нэг мянга гурван зуун гучин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэж, эсхүл эд хөрөнгө устгаж, гэмтээж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний халдашгүй, чөлөөтэй байх, эд хөрөнгө өмчлөх эрх, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаа, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | **181 дүгээр зүйл. Танхайрах**<br>181.1.Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>181.2.Энэ хэргийг:<br>181.2.1.догшин авирлаж;<br>181.2.2.нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэж;<br>181.2.3.урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд;<br>181.2.4.давтан;<br>181.2.5.бүлэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>181.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | -**"...нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн"** гэж хэт ерөнхий байдлаар хуульчилсан байсныг өөрчилж, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг **"Бусдад хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл эд хөрөнгө устгаж, гэмтээж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний бие махбодийн болон өмч хөрөнгийн халдашгүй байдал, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаа, хүмүүсийн харилцааны тогтсон хэм хэмжээнд халдсан бол"** гэж дэлгэрэнгүй хуульчилсан нь танхайрах зөрчил болон бусад төсөөтэй гэмт хэргээс энэ гэмт хэргийг ялган зүйлчлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон.<br>-Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан байдал "зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж үйлдсэн" гэснийг **"зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж"** гэж өөрчилсөн. Бааранд маргалдаад шар айрагны шил, гудамжинд газраас чулуу авч танхайрах үйлдэлдээ ашигласан бол гэмт хэрэг | **Үндсэн бүрэлдэхүүн:**нэг зуун тооцооны нэгжээс нэг мянга гурван зуун гучин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох ялын доод хэмжээ 50 дахин, дээд хэмжээ 8 дахин багассан.<br>Баривчлах ялын төрөл хасагдаж, хорих ялын хэмжээ 1-3 жил байсан бол **долоо хоногоосгурван сар**хүртэл болж багассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3.Энэ зүйлийн 1, 2-т заасан гэмт хэргийг зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, эсхүл бусдын эд хөрөнгийг дээрэмдэж, эсхүл галдан шатааж, эсхүл бусдын бие махбодид хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж, бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | төгсч, 5-8 жил хорих ял шийтгэж байгаа одоогийн хатуу эрх зүйн зохицуулалтыг өөрчлөхийг шаардсан олон нийт, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шаардлагаас үүдэж, өөрчилсөн. Төсөлд тухайн этгээд олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулахын тулд зэвсэг, **урьдчилан тусгайлан бэлтгэсэн** зэвсгийн чанартай зүйлийг хэрэглэж үйлдсэн байхаар заасан.<br>- нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэж үйлдсэн бол ял хүндрүүлэхээр заасан байсныг хассан, | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 2 жилээр багасч, дээд хэмжээ өөрчлөгдөөгүй.<br>Сонгох санкцтай болж гэрийн хорионд байлгах ялын төрөл шинээр нэмсэн. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:** хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жилээр багасч, дээд хэмжээ өөрчлөгдөөгүй. |
| 5. | **27.10 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих**<br>1.Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, | **215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих**<br>215.1.Жолоочхөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын бие махбодид хүндэвтэр | **-**Энэ гэмт хэргийн улмаас бусдад **үлэмж хэмжээний хохирол учруулсан** бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын хор уршгийг хассан. | **Үндсэн бүрэлдэхүүн:** нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар | Торгох ялын доод хэмжээ 5 дахин, дээд хэмжээ 2 дахин багассан.<br>Баривчлах ял хасагдаж, гэрийн хорионд байлгах ялын төрлийг нэмсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;<br>2.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн үйлдсэн;<br>2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан;<br>2.4.их хэмжээний хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасч, нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь насыг хохироосон | гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавaac тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>215.2.Энэ хэргийг согтуугаар үйлдсэн, бусдын бие махбодид хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>215.3.Энэ хэргийн улмаас бусдын амь нас хохирсон, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг дөрвөн жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод | -Энэ гэмт хэргийг **тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн үйлдсэн** бол хүндрүүлэхээр заасан нь практикт үйлдэгдэж буй жолоодох эрхийн үнэмлэхгүй, эсхүл жолоодох эрхээ хасуулсан этгээдийн үйлдэлд ял хүндрүүлэн хариуцлага хүлээлгэх боломж бүрдүүлнэ.<br>- Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн 27.10-ын 4 дэх хэсэгт **энэ гэмт хэргийгсогтуурсан, мансуурсан үедээ үйлдэж хүний амь нас хохироосон бол ял хүндрүүлэхээр заасан** нь өнөөгийн нөхцөл байдалд тохирсон, иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодохоос татгалзахад хүргэх чухал өөрчлөлт болно. | хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасч, нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох, баривчлах ял хасагдаж, гэрийн хорионд байлгах ялын төрөл нэмсэн. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:** тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасч, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 2 жилээр багассан бол дээд хэмжээ өөрчлөгдөөгүй.<br>Торгох ял хасагдаж, гэрийн хорионд байлгах ялын төрлийг нэмсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасч, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хоёр эсхүл түүнээс дээш хүний амь насыг хохироосон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасч, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>215.4 энэ хэргийн улмаас хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: Энэ зүйлд заасан "жолооч" гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд, "тээврийн хэрэгсэл" гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн бусад механикжсантээврийн хэрэгслийг тус тус ойлгоно | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:**<br>тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасч, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй бол дээд хэмжээ 2 жилээр багассан. |
| 6. | **17.2 дугаар зүйл. Дээрэмдэх**<br>1.Бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар гэрийн хориод байлгах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br><br>2.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр | **147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх**<br>147.1.Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>147.2.Энэ хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд энэ | -Энэ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд **бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар авах үйлдлийг** хуульчилсан. Ингэж практикт ялгаж зүйлчлэхэд бэрхшээл учирдаг бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн үйлдлийн аргыг оруулж өгснөөр энэхүү бэрхшээл үгүй болно.<br>**-** Энэ гэмт хэргийг **давтан,** | **Үндсэн бүрэлдэхүүн:**зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар гэрийн хориод байлгах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жил байсан бол 6 сар болж, 6 дахин багассан болдээд хэмжээ 2 жил болж, 3 жилээр багассан.<br>Зөвхөн хорих ялтай байсан бол гэрийн хориод байлгах ялын төрөл шинээр нэмэгдсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | заналхийлж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br><br>3.Энэ гэмт хэргийг:<br>3.1.байнга тогтвортой үйлдсэн;<br>3.2.зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн;<br>3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, эсхүл зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>147.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан бол эд хөрөнгийг хураах арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | **бүлэглэж** үйлдсэн болхүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан.<br>-Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд **байнга тогтвортой үйлдсэн буюу энэ төрлийн гэмт хэргийг амьдрах эх үүсвэрээ болгож, тогтмол үйлдэх** талаар заасан. Энэ нь энэ төрлийн гэмт хэргийг байнга үйлдэж, амьдрах эх үүсвэрээ болгосон этгээдүүдийн үйлдийн нийгмийн аюулын шинж чанарт тохирсон хүнд ял оногдуулах боломж олгоно.<br>**-зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн** бол онц хүндрүүлэхээр заасан нь өнөөгийн эрүүгийн нөхцөл байдалд тохирсон, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад ач холбогдолтой. | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жилээр, дээд хэмжээ 2 жилээр тус тус багассан.<br>Зөвхөн хорих ял оногдуулахаар заасан байсан бол гэрийн хорионд байлгах ялын төрөл шинээр нэмсэн. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:**найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 2 жилээр, дээд хэмжээ 5 жилээр тус тус багассан. |
| 7. | **27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах**<br>1.Энэ хуулийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн жолооч хэргийн газрыг зориуд орхиж зугтаасан бол нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр сараас | **216 дугаар зүйл. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах**<br>216.1.Зам тээврийн осол гаргасан жолооч хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлэх, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод | -Зам тээврийн осол гаргасан жолооч хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлэх, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсон. | нэг зуун тооцооны нэгжээс хоёр мянга гурван зуун дөчин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл хоёр сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох ялын доод хэмжээ 50 дахин, дээд хэмжээ 1.5 дахин тус тус багассан.<br>Хорих ялын доод хэмжээ 10 сараар, дээд хэмжээ 4 жил 6 сараар багассан.<br>Баривчлах ялыг хасч, гэрийн хорионд байлгах ялын төрлийг нэмсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | хэмжээг тавaас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>216.2.Жолооч зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | | |
| 8. | **16.1 дүгээр зүйл.Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах**<br>1.Хүүхдэд амлалт өгч, эсхүл хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хориoнд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Хүүхдийг зохион байгуулалттай гэмт бүлэгт, эсхүл найман жилээс дээш хугацаагаар хорих ял | **114 дүгээр зүйл.Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах**<br>114.1.Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавaас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>114.2.Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч | -гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үйлдлийн аргыг дэлгэрэнгүй заасан.<br>-Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ялын бодлогыг чангатгасан.<br>- насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсныг хассан. | **Үндсэн бүрэлдэхүүн:** нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хориoнд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>**Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Гэрийн хориoнд байлгах, хорих ялын төрөл нэмэгдэж, торгох, баривчлах ялын төрөл нэмэгдсэн.<br>Хорих ялын доод хэмжээ 3 жилээр багасч, дээд хэмжээ өөрчлөгдөөгүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | үйлдсэн бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>114.3.Насанд хүрээгүй хүнийг зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэлд элсүүлсэн, эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | | |
| 9. | **20.10 дугаар зүйл. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар ашиглах**<br>1.Хориглосон мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хориод байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | **192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах**<br>192.1.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>192.2.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, | -Хориглосон мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн түүхий эдийг олж авсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсон.<br>-Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд энэ төрлийн бодисыг улсын хил нэвтрүүлсэн үйлдлийг шинээр хуульчилсан. /Энэ үйлдлийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд заасан./<br>-энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан.<br>-Олон Улсын жишгийн дагуу энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасан. | **Үндсэн бүрэлдэхүүн:** нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Торгох, баривчлах ялыг хасч, гэрийн хорионд байлгах, хорих ялын төрлийг нэмсэн. |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жилээр багасч, дээд хэмжээ өөрчлөгдөөгүй. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:** таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 5 жил, дээд хэмжээ 3 жилээр тус тус багассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3.Энэ гэмт хэргийг:<br>3.1.байнга тогтвортой үйлдсэн;<br>3.2.улсын хилээр нэвтрүүлсэн;<br>3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хоёр зуун мянган тооцооны нэгжээс дөрвөн зуун мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.<br>Тайлбар:<br>-энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис эсхүл эдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, эсхүл таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг илрүүлсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис эсхүл эдгээртэй адилтгах зүйлийг мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй. | илгээсэн, борлуулсан бол тавaас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>192.3.Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг:<br>192.3.1.онц их хэмжээгээр;<br>192.3.2.насанд хүрээгүй хүн оролцуулж;<br>192.3.3.онц аюултай гэмт хэрэгтэн;<br>192.3.4.давтан;<br>192.3.5.урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн: /хуулийн этгээд үйлдсэн бол/** тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хоёр зуун мянган тооцооны нэгжээс дөрвөн зуун мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. | Харьцуулах боломжгүй. Одоогийн Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хуриуцлага хүлээлгэх талаар заагаагүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10. | **12.1 дүгээр зүйл.Хүчиндэх**<br>1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн;<br>2.2.бүлэглэсэн;<br>2.3.гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн;<br>2.4.хохирогчийг жирэмсэн болгосон;<br>2.5.хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдаасан;<br>2.6.Энэ зүйлд заасан гэмт хэргийг хоёр эсхүл түүнээс дээш хүний эсрэг үйлдсэн, эсхүл урьд энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан;<br>2.7.харгис хэрцгий аргаар, бие махбодийн болон сэтгэл санааны шаналал, зовиур | **126 дугаар зүйл. Хүчиндэх**<br>126.1.Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>126.2.Энэ хэргийг:<br>126.2.1.хохирогчийг тохуурхан даажигнаж, зовоон тарчлааж;<br>126.2.2.хүндэвтэр буюу хүнд гэмтэл учруулж;<br>126.2.3.давтан;<br>126.2.4.насанд хүрээгүй хүнийг;<br>126.2.5.албан тушаал, эд хөрөнгийн болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнийг;<br>126.2.6.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>126.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан, эсхүл бага насны, өөрөөр хэлбэл арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ. | - **"Хүсэл зоригийн эсрэг"** гэж субъектив талын шинжийг тусгаж өгсөн.<br>- Хүчиндэх гэмт хэргийг **үйлдэх аргыг** *"хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах"* гэж диспозицид дэлгэрэнгүй хуульчилсан. Ингэснээр практик энэ төрлийг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.<br>- "**хохирогчийг жирэмсэн болгосон"-** тохиолдолд хүндрүүлэхээр заасан нь дэвшилттэй алхам болсон. Учир нь гэр бүлийн болон бусад хүрээнд үйлдэгдэж буй энэ гэмт хэргийн улмаас хохирогч жирэмсэн болох тохиолдол цөөнгүй байдаг. Энэ тохиолдолд гэмт этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл болдоггүй, ял завшуулж байсан.<br>- **Хуулийн төслийн тайлбар хэсэгт:**<br>-хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн | **Үндсэн бүрэлдэхүүн:**нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Өөрчлөгдөөгүй. |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:**хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жилээр багасч, дээд хэмжээ мөн 2 жилээр багассан. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:**арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ 3 жилээр багасч, дээд хэмжээ мөн 5 жилээр багассан.<br>Цаазаар авах ялын төсөл хасагдаж, бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үүсгэж, тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>4.Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар:<br>- хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.<br>- бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.<br>- бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно. | | халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.<br>-бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй" гэж заасан нь **хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах боломжийг бүрдүүлж байна.**<br>- **Хуулийн төслийн тайлбар хэсэгт:**<br>-бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, эсхүл хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно" гэж заасан нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хуульд заасан аргаар бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан үйлдлийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, гэмт этгээдэд ял завшуулж байсан буруу тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцсэн алхам болсон. | | |
| 11. | **17.4 дүгээр зүйл. Хөрөнгө завших, үрэгдүүлэх**<br>1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан, | **150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших,үрэгдүүлэх**<br>150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг | -Энэ гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан.<br>- Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж үйлдсэн бол | **Үндсэн бүрэлдэхүүн:** нэг зуун тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх | Баривчлах ялын төрлийг хассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үрэгдүүлсэн бол нэг зуун тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br><br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн;<br>2.2.хүний эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхэд ноцтой хохирол учруулсан,<br>2.3.их хэмжээний хохирол учруулсан бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хорин дөрвөн мянган тооцооны нэгжээс жаран мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>150.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>150.3.Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан.<br>-Албан тушаалын байдлаа ашиглаж энэ гэмт хэргийг үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан. | хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ нэг жилээр, дээд хэмжээ 3 жилээр нэмэгдсэн.<br>Баривчлах ялын төрөл хасагдсан. |
| | | | | **Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:** хорин дөрвөн мянган тооцооны нэгжээс жаран мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, дээд хэмжээ 2 жилээр нэмэгдсэн.<br>Зөвхөн хорих ял шийтгэхээр заасан бол төсөлд торгох ялын төрлийг шинээр нэмсэн. |
| 12. | **10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх**<br>1.Эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг | **95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх**<br>95.1.Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий | Хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан. Тухайлбал, "...улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол..." гэж төсөлд гэж заасан. | **Үндсэн бүрэлдэхүүн:**нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ нэг жилээр багассан бол дээд хэмжээ өөрчлөгдөөгүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | | |
| 13. | **24.5 дугаар зүйл.Хууль бусаар ан агнах**<br>1.Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, эсхүл агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, | **203 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих**<br>203.1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон хориотой үед, хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, ховор ан амьтанг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, тэжээж гаршуулсан,тэдгээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>203.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, нэн ховор ан амьтан агнасан, барьсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх | **-амьтны гаралтай түүхий эд, зүйлийг гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийх үйлдлийг** энэ зүйлд гэмт хэрэгт тооцсон. Ховор амьтныг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.<br>-Энэ гэмт хэргийг **хуулийн этгээд үйлдсэн** бол онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилж, **тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хоёр зуун мянган тооцооны нэгжээс дөрвөн зуун мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял** шийтгэхээр заасан. | **Үндсэн бүрэлдэхүүн:** дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хориондбайлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, дээд хэмжээ 2 жилээр нэмэгдсэн.<br>Торгох ялын доод хэмжээ өөрчлөгдөөгүй, дээд хэмжээ 2 дахин нэмэгдсэн.<br>Баривчлах ялын төрөл хасагдсан. |
| | | | | **Хүндрүүлэх бүрэлдэхүүн:** арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | Хорих ялын доод хэмжээ нэг жилээр багасч, дээд хэмжээ 3 жилээр нэмэгдсэн.<br>Торгох ялын доод хэмжээ 1.5 дахин багасч, дээд хэмжээ 2 дахин нэмэгдсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хоёр зуун мянган тооцооны нэгжээс дөрвөн зуун мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. | хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | | |
| 14. | Булаах гэмт хэрэг Эрүүгийн хуулийн төсөлд тусгагдаагүй. Харин бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаах үйлдлийг дээрэмдэх гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд заасан. | **146 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг булаах**<br>146.1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>146.2.Энэ хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, нийтэд | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | учирсан гамшигт байдал, хохирогчийн эд хөрөнгөө хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. | | | |
| 15. | **10.1 дүгээр зүйл.Хүнийг алах**<br>1.Хүнийг алсан бол арван жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Хүнийг:<br>2.1.онц харгис хэрцгийгээр;<br>2.2.олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар;<br>2.3.захиалгаар;<br>2.4.өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор;<br>2.5.өөртөө болон бусдад эдийн, эдийн бус ашигтай байдал бий болгох зорилгоор;<br>2.6.хоёр, түүнээс олон хүнийг;<br>2.7.хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, эсхүл бага насны хүүхэд, эсхүл жирэмсэн болохыг мэдсээр байж;<br>2.8.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж;<br>2.9.хүнийг эрхэлж буй ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж, | **91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах**<br>91.1.Энэ хуулийн 91.2-т заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>91.2.Хүнийг:<br>91.2.1.шунахайн сэдэлтээр;<br>91.2.2.танхайн сэдэлтээр;<br>91.2.3.өс хонзонгоор;<br>91.2.4.захиалгаар;<br>91.2.5.хохирогчийн цус, эд, эрхтэнийг ашиглах зорилгоор;<br>91.2.6.өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор;<br>91.2.7.уулгалан довтлох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ;<br>91.2.8.хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэрэг үйлдэхдээ;<br>91.2.9.онц аюултай гэмт | **-** Хүнийг шунахайн, танхайн, өс хонзонгийн сэдэлтээр санаатай алсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан. Учир нь практикт гэмт хэргийн бүрэлдэхүүнийсубъектив талын шинжийг тогтооход бэрхшээлтэй байдаг, гэмт этгээдийн субектив талд төдийлөн анхаарал хандуулалгүйгээр гэмт үйлдэл, эс үйлдэхүйд анхаардаг олон улсын жишгийг харгалзсан.<br>-энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, давтан үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасныг хассан.<br>- гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, эрүүдэн шүүж, үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан хүндрүүлэх | | Үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан хорих ялын хэмжээ өөрчлөгдөөгүй. Харин энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан цаазаар авах ялыг хасч, бүх насаар нь хорих ялын төрлийг нэмсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эсхүл түүний ойр дотны хүнийг;<br>2.10.зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад;<br>2.11.бүлэглэж;<br>2.12.эрүүдэн шүүж;<br>2.13.цус, эд, эрхтэнийг авах зорилгоор;<br>2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван таван жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар:<br>- Энэ хуульд заасан бага насны хүүхэд гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно. | хэрэгтэн;<br>91.2.10.хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн /энэ хуулийн 93 дугаар зүйл хамаарахгүй/;<br>91.2.11.бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;<br>91.2.12.онц харгис хэрцгий аргаар;<br>91.2.13.нийтэд аюултай аргаар;<br>91.2.14.хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж;<br>91.2.15.хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;<br>91.2.16.хоёр буюу түүнээс олон хүнийг;<br>91.2.17.албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ. | бүрэлдэхүүнд хуульчилсан. | | |

Жич: Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жинг тогтоохдоо ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төвийн “2014 онд улсын хэмжээнд бүтгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ”-г ашиглав. Эх сурвалж: http://www.police.gov.mn/news/list/type/18/menuid/11

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИ**

**(ХАРЬЦУУЛАЛТ)**

2015.02.13

| № | Монгол Улсын Эрүүгийн хууль (2002 он) | Монгол Улсын Эрүүгийн хуулийн төсөл | Шинэчлэн боловсруулсан байдал | Ялын интервалын өөрчлөлт | Тайлбар, үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |